

ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ
СОЁЛ, УРЛАГИЙН ГАЗАР



“НҮҮДЭЛЧИН” ДЭЛХИЙН СОЁЛЫН ФЕСТИВАЛЬ

ТАЙЛАН

Улаанбаатар хот
2022 он

“НҮҮДЭЛЧИН” ДЭЛХИЙН СОЁЛЫН ФЕСТИВАЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт соёлын биет бус өвийг хадгалж хамгаалах, түүнийг өвлөн уламжлагчийг тодруулах, алдаршуулах, авьяас билгийг хөгжүүлэх, олон нийтэд сурталчлан түгээн дэлгэрүүлэх зорилгоор гурван жил тутамд улсын хэмжээнд соёлын биет бус өвийн их наадмыг зохион байгуулна гэж заасан байдаг.

Энэхүү наадмыг 1948 оноос “Ерөөлч магтаалчдын улсын анхдугаар уралдаан”, 1966 оноос “Ардын язгуур урлагийн наадам”, 1991 оноос “Ардын урлагийн их наадам” нэрээр улсын хэмжээнд зохион байгуулж ирсэн түүхэн уламжлалтай. 2018 онд Улаанбаатар хотын Хүй долоон худагт “Нүүдэлчин Монгол” соёлын биет бус өвийн их наадам нэрээр Соёлын биет бус өвийн хамгаалах тухай ЮНЕСКО-ийн 2003 оны конвенцын зарчим, үзэл баримтлалын дагуу 5 ай савын хүрээнд 27 засаг захиргааны нэгжийн 2697 өвлөн уламжлагч хамрагдаж, оролцогч аймаг тус бүр отгийн зохион байгуулалтад орж, өөрийн нутаг дахь соёлын биет бус өвийн төрөл зүйлийг олон нийтэд сурталчлан таниулсан наадам болсноороо онцлог болсон.

“Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогод “Нүүдлийн соёл иргэншлийн голомт байгууллагыг байгуулж, дэлхийн нүүдэлчдийн төв болох”, Монгол Улсын Ерөнхийлөгчийн мөрийн хөтөлбөрт “Монгол Улсыг дэлхийн нүүдэлчдийн соёл иргэншлийн төв болгох, дэлхийн монголчуудтай хамтран ажиллах зорилгоор “Нүүдэлчдийн соёл, спортын их наадам”-ыг эх орондоо тогтмол зохион байгуулах” гэсэн зорилт дэвшүүлсэнтэй уялдуулан Монгол Улсын Соёлын яам, Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Соёл, урлагийн газраас Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт заасан соёлын биет бус өвийн их наадмыг 2022 оны 08 дугаар сарын 12-14-ний өдрүүдэд Горхи - Тэрэлжийн байгалийн цогцолбор газар /Сайхны саравч/-т “Нүүдэлчин” дэлхийн соёлын фестиваль нэртэйгээр зохион байгуулав.

Энэ удаагийн фестивалийг нүүдэлчдийн байгаль хамгаалах арга ухааныг эрхэмлэн байгаль орчинд ээлтэй, эко орчныг бүрдүүлж тэг хаягдал (zero waste) буюу аливаа бүтээгдэхүүн, нөөцийг боломжит хязгаарт нь хүртэл дахин ашиглах, хог хаягдал үүсэхээс урьдчилан сэргийлэх, нүүрс төрөгчийн ялгарлыг (carbon limited) бууруулахын тулд эрчим хүчний хэрэглээг багасгах зэрэг нөлөөллийн ажлуудыг хийснээс гадна гэр бүл, хүүхэд залуучууд, наадамчин олонд зориулж эсгий хийх, айраг исгэх, сур боловсруулах, нум сум харвах зэрэг уламжлалт монгол ахуйн арга ухаанаас суралцах боломж бүрдүүлснээр онцлог болов.

Тус ажлын хүрээнд Соёлын сайдын 2022 оны 06 дугаар сарын 13-ны өдрийн А/181 дүгээр тушаалаар наадмын зохион байгуулалтын хүрээнд салбар хоорондын уялдааг хангахад бодлогын дэмжлэг үзүүлэх ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг баталсан. Монгол Улсын Соёлын яамны Төрийн нарийн бичгийн дарга С.Оюунбилэгээр ахлуулсан ажлын хэсгийн бүрэлдэхүүнд Гадаад харилцааны яам, Байгаль орчин, аялал жуулчлалын яам, ЮНЕСКО-ийн Монголын үндэсний комисс,

Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Соёл, урлагийн газар, аймаг, нийслэлийн Засаг даргын орлогч нар, нийслэлийн харьяа нутгийн захиргааны байгууллага, Монголын Үндэсний Олон нийтийн телевиз, Монголын Үндэсний худалдаа аж үйлдвэрийн танхим зэрэг төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгжийн төлөөлөл ажиллав.

Мөн, Соёлын сайдын 07 дугаар сарын 27-ны өдрийн “Зардал баталж, эрх шилжүүлэх тухай” А/261, 2022 оны 08 дугаар сарын 04-ний өдрийн “Зардал баталж, эрх шилжүүлэх тухай” А/273, 2022 оны 8 дугаар сарын 10-ны өдрийн “Зардал баталж, эрх шилжүүлэх тухай” А/302 дугаар тушаалыг тус тус баталсан.

Соёлын сайдын 2022 оны 06 дугаар сарын 13-ны өдрийн А/181 дүгээр тушаалыг үндэслэн Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Соёл, урлагийн газраас “Нүүдэлчин Монгол - 2022” соёлын биет бус өвийн их наадмын Удирдамж (*хавсралт 1*), оролцогчдод өгөх отог үүсгэх үйл ажиллгааны заавар, түр байрлахад мөрдөх заавар, эрүүл мэнд, аюулгүй байдлыг хангах заавар, эрүүл ахун зааварчилгаа (*хавсралт 2*) зэргийг тус тус боловсруулж 21 аймаг, нийслэлийн Соёл урлагийн газруудад хүргүүлж, мэргэжил арга зүй, зохион байгуулалтын дэмжлэг үзүүлж ажиллав.

Мөн, Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Соёл, урлагийн газрын даргын 2022 оны 07 дугаар сарын 28-ны өдрийн “Зардал гаргах тухай” А/49, 2022 оны 08 дугаар сарын 08-ны өдрийн “Зардал гаргах тухай” А/53, 2022 оны 08 дугаар сарын 12-ны өдрийн “Зардал гаргах тухай” А/56, 2022 оны 08 дугаар сарын 09-ний өдрийн “Нүүдэлчин Монгол - 2022 соёлын биет бус өвийн их наадмын шүүгчдийн бүрэлдэхүүн томилох тухай” А/54 дүгээр тушаалаар мэргэшсэн болон техникийн шүүгчдийн бүрэлдэхүүн, ажиллах дүрмийг (*хавсралт 3*) тус тус батлав.

Тус фестивалийн хүрээнд соёлын биет бус өвийн 7 ай савын 362 өвийн төрөл зүйл, Монгол Улсаас Соёлын биет бус өвийг хамгаалах тухай ЮНЕСКО-ийн 2003 оны конвенцын жагсаалтад бүртгэгдсэн 15 өвийг фестивальд оролцогчид, хүүхэд залууст таниулан сурталчлах, түгээн дэлгэрүүлэх зорилгоор 21 аймаг, нийслэлийн “22 отог” “Соёлын өвийн хүрээ”, “Худалдааны хүрээ”, “Үндэсний спортын хүрээ”, “Уламжлалт идээ ундааны хүрээ”-г тус тус зохион байгуулав.

“Нүүдэлчин” дэлхийн соёлын фестивалийг нийт 24,900 гаруй, үүнээс гадаадын жуулчид 1,000, хүүхэд 4,000 ирж үзсэн байна. Мөн, Горхи-тэрэлжийн бүсийн 75 жуулчны баазад 10,198 орчим хүн/хоногийн эрэлт үүсгэж, 407,920,000 төгрөгийн эргэлт бий болгосон. Соёлын бүтээлч үйлдвэрлэлийн 90 гаруй бизнес эрхлэгчдэд 656,700,000 орчим төгрөгийн эргэлт үүссэн байна.

Түүнчлэн, 180 объектийг цахилгаанаар хангаж, 1,5 км шороон замын сайжруулалтын ажлыг хийж гүйцэтгэсэн. Мөн, 40 тонн цэвэр ус хэрэглэж, газрын зургийн дагуу талбай дээр өгөгдсөн 300 гаруй цэгийн байршлыг тогтоож, хил хязгаарын тэмдэглэгээ хийж гүйцэтгэв. “Нүүдэлчин” дэлхийн соёлын фестивалийн

талбайн 6 цэгт 70 ширхэг био ариун цэврийн өрөө байршуулсан бөгөөд үйл ажиллагааны мэдээлэл, зүг чиг, тэмдэглэгээ заасан 12 самбар, 70 туг байршуулсан.

Тус фестивальд зам тээвэр, хэв журмын цагдаагийн 125, мэргэжлийн хяналт, эмнэлэг, цэрэг, онцгой байдал 212, зохион байгуулагчид 200 зэрэг нийт 637 албан хаагч нар ажиллав.

“Нүүдэлчин” дэлхийн соёлын фестивалийг сурталчлах ажил олон нийтийн цахим сүлжээнд 150 орчим зорилтод группуудад хүрч, давхардсан тоогоор 16 сая хандалт авсан бөгөөд 2 мянга орчим агуулга түгээлтэд 14 продакшн баг, 100 гаруй баг бүрэлдэхүүн, 35 орчим зурагчид ажилласан. Монголын үндэсний олон нийтийн телевиз 45 хүний бүрэлдэхүүнтэйгээр нээлт, хаалтын үйл ажиллагааг шууд дамжуулж, өдөр бүр мэдээ, сурвалжлага, нэвтрүүлэг бэлтгэн олон нийтэд хүргэж ажилласан. Мөн, UBS, SBN, C1, ТВ5, ТВ8, ТВ9, Тэнгэр, Малчин, Сүлд телевиз нь аймаг, нийслэлийн отгуудын үйл ажиллагааг баримтжуулж баримтат нэвтрүүлэг, үндэсний архив бүрдүүлэх контентийн ажлыг хийж гүйцэтгэсэн.

Түүнчлэн, тус фестивалийн хүрээнд агуулга үйлдвэрлэл, архив бүрдүүлэлтэд 24 гаруй боловсрол олгох агуулга, 21 аймаг, нийслэлийн нэвтрүүлэг, 19 өвлөн уламжлагчдын нэвтрүүлэг боловсруулагдаж, каталоги, 4 баримтат кино нэвтрүүлгийн ажлыг гүйцэтгэж байна.

“22 отог”

“Нүүдэлчин” дэлхийн соёлын фестивалийн 22 отгийн үйл ажиллагаанд “Монгол Улсын соёлын биет бус өвийн Төлөөллийн үндэсний бүртгэл”, ялангуяа “Яаралтай хамгаалах шаардлагатай соёлын биет бус өвийн үндэсний бүртгэл”-д хамаарах өвийн төрөл, зүйлийг хамруулах зарчим баримталж ажиллав.

Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын “Бүртгэл шинэчлэн батлах тухай” 2019 оны 11 дүгээр сарын 29-ний өдрийн А/759 дүгээр тушаалын 1 дүгээр хавсралтаар Соёлын биет бус өвийн Төлөөллийн үндэсний бүртгэлд бүртгэгдсэн соёлын биет бус өвийн 7-н ай савын төрөл зүйлд хамаарах 279 өв, 2 дугаар хавсралтаар “Монгол Улсын Яаралтай хамгаалах шаардлагатай соёлын биет бус өвийн үндэсний бүртгэл”-д бүртгэгдсэн 7 ай савын 83 өвийн төрөл зүйл зэрэг нийт 362 өв батлагдсан байдаг. Соёлын биет бус өв нь дараах 7 ай савд хуваан авч үздэг. Үүнд:

1. Эх хэл, аман уламжлал, илэрхийллүүд;
2. Ардын язгуур урлаг;
3. Уламжлалт баяр наадам, зан үйл, ёс, тоглоом наадгай, уриа дуудлага;
4. Байгалийн болон сав шим ертөнцийн тухай мэдлэг, зан үйл;
5. Уламжлалт арга ухаан;
6. Мал маллах арга ухаан;
7. Уламжлалт гар урлал.

Мөн, Засгийн газрын 2019 оны 475 дугаар тогтоолоор Соёлын биет бус өвийг ур чадварын өндөр түвшинд өвлөн эзэмшсэн “Соёлын биет бус өвийг өвлөн уламжлагчийн үндэсний жагсаалт”-д 102 өвлөн уламжлагч бүртгэгдсэн бол Монгол Улсын хэмжээнд 2022 оны байдлаар Соёлын өвийн улсын нэгдсэн бүртгэл, мэдээллийн сангийн анхан шатны бүртгэлд 11189 өвлөн уламжлагч бүртгэгдсэн байдаг.

22 отгийн үйл ажиллагаанд Монгол Улсын соёлын биет бус өвийн төлөөллийн үндэсний бүртгэлийн 362 өвийн төрөл зүйлээс 259 төрөл зүйл, Монгол Улсын Яаралтай хамгаалах шаардлагатай соёлын биет бус өвийн үндэсний бүртгэлд бүртгэгдсэн 83 өвийн төрөл зүйлээс 32 өвийн төрөл зүйлийг хамруулан хүүхэд, залуучууд, ард иргэдэд таниулан сурталчлах ажлыг зохион байгуулав.

Мөн Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 475 дугаар тогтоолоор баталсан Соёлын биет бус өвийг ур чадварын өндөр түвшинд өвлөн эзэмшсэн “Соёлын биет бус өвийг өвлөн уламжлагчийн үндэсний жагсаалт”-д бүртгэгдсэн 102 өвлөн уламжлагчаас 22 өвлөн уламжлагч оролцов.

“Нүүдэлчин” дэлхийн соёлын фестивалд 21 аймаг, нийслэлийн 1283 өвлөн уламжлагч, соёлын салбарын албан хаагч нар оролцсон бөгөөд ялангуяа соёлын биет бус өвийн 5 дахь ай сав буюу Уламжлалт арга ухааны ай савд багтах Уламжлалт анагаах арга ухааныг онцгойлон анхаарч 17 аймгийн 23 өвлөн уламжлагчдыг “Соёлын өвийн хүрээ”-нд нэг дор төвлөрүүлэн арга хэмжээ болгон зохион байгуулав.

22 отгийн үйл ажиллагаанд 84 гэр буюу аймаг, нийслэл тус бүрт Зан үйл, язгуур урлагийн өргөө, Гар урлалын үзэсгэлэн, Соёлын биет бус өвийг таниулан сурталчлах өргөө, Хүндэтгэлийн өргөөг тус тус байрлуулж, нийт 273 удаагийн тоглолтыг зохион байгуулав.

“Нүүдэлчин” дэлхийн соёлын фестивалд амжилттай оролцсон шилдэг өвлөн уламжлагч, баг, хамт олныг дараах байдлаар шагнаж урамшуулав. Үүнд:

№	Овог, нэр	Аймаг, нийслэл	Нас	Хүйс	Ай сав	Өвийн төрөл зүйл
1. Шилдэг өвлөн уламжлагч (тус бүр 1.000.000 төгрөг)						
1	Ж.Эрхэмсайхан	Дархан-Уул	58	Эрэгтэй	Эх хэл, аман уламжлал, илэрхийллүүд	Уран бичлэг
2	С.Сэрээтэр	Дорноговь	69	Эмэгтэй		Малын уриа дуудлага
3	А.Лүндээжанцан	Өвөрхангай	60	Эрэгтэй		Ерөөл
4	Т.Цэмбэл	Ховд	78	Эмэгтэй	Ардын язгуур урлаг	Торгууд бийч
5	Д.Балган	Улаанбаатар	62	Эрэгтэй		хотон бийч
6	Ц.Хашбат	Завхан	64	Эрэгтэй		уртын дуу
7	Д.Даваарагчаа	Завхан	25	Эрэгтэй	Уламжлалт баяр наадам, зан үйл,	Гийнгоо цол
8	Х.Батням	Архангай	40	Эрэгтэй		Тоглоом наадгай

9	Д.Чинбат	Хөвсгөл	58	Эрэгтэй	ёс, тоглоом наадгай, уриа дуудлага	Ангийн уриа дуудлага
10	Э. Чинзориг	Хэнтий	38	Эрэгтэй	Байгалийн болон сав шим ертөнцийн тухай уламжлалт мэдлэг, зан үйл	Шувуучлах эрдэм
11	Ц.Буянхишиг	Дархан-Уул	56	Эмэгтэй		Монгол бичгийг сав шим ертөнцтэй холбох
12	Х.Баярсайхан	Ховд	60	Эрэгтэй		уул овоо тахиx
13	Д.Дарьсүрэн	Булган	70	Эмэгтэй	Уламжлалт арга ухаан	Сүүн будгийн технологи
14	М.Сүрэн	Баянхонгор	60	Эмэгтэй		Ааруул хийх шинэ арга
15	Ч.Өнөдэлгэр	Өмнөговь	49	Эмэгтэй		Эсгий урлал
16	Д.Пүрэв	Дорнод	53	Эрэгтэй	Мал маллах арга ухаан	Хөсөг нүүдэл
17	Д.Таванжин	Дундговь	50	Эрэгтэй		Тэнгэр шинжих
18	Н.Батхуяг	Өмнөговь	53	Эрэгтэй		Мал хатгах
19	Б.Мөнхтуяа	Завхан	36	Эмэгтэй	Уламжлалт гар урлал	Зоосон ширээ хатгамал
20	Б.Эрдэнэтогос	Дундговь	39	Эмэгтэй		Зоосон ширээ хатгамал
21	Т.Үүрийнтуяа	Өмнөговь	39	Эмэгтэй		Зоосон ширээ хатгамал
2. Хамгийн өндөр настай өвлөн уламжлагч (тус бүр 500,000 төгрөг)						
1	Б.Дашзэвэг	Өвөрхангай	87	Эрэгтэй	Ардын язгуур урлаг	Ардын дуу
2	Ё.Дашзэвэг	Төв, Эрдэнэсант	87	Эрэгтэй	Уламжлалт баяр наадам, зан үйл, ёс, тоглоом наадгай, уриа дуудлага	Шагай, тоглоом наадгай, уриа дуудлага
3	Х.Рэнцэндорж	Төв, Баянжаргалан	87	Эрэгтэй	Мал маллах арга ухаан	Мал маллах арга ухаан (Контент)
4	Т.Норжмаа	Улаанбаатар, Баянгол дүүрэг	85	Эмэгтэй	Үзэсгэлэн худалдаа	Зээгт наамал
5	Н.Лантуу	Дорноговь, Сайншанд	85	Эмэгтэй	Ардын язгуур урлаг	Аялгуут үлгэр
3. Хамгийн олон шавь сургасан өвлөн уламжлагч (тус бүр 500.000 төгрөг)						
1	Д.Цэрэндаваа	Ховд	68	Эрэгтэй	Ардын язгуур урлаг	Хөөмий
2	Ц.Шарав	Баянхонгор	77	Эрэгтэй	Эх хэл, аман уламжлал, илэрхийллүүд	Уриа дуудлага
3	Х.Ёндонжамц	Баянхонгор	64	Эрэгтэй	Уламжлалт баяр наадам, зан үйл, ёс, тоглоом наадгай, уриа дуудлага	Дуутай хуруу
4	Д.Зоригт	Булган	60	Эрэгтэй	Эх хэл, аман уламжлал, илэрхийллүүд	Цол дуудлага

5	Г.Цээсүрэн	Сүхбаатар	64	Эмэгтэй	Уламжлалт гар урлал	Эсгий урлал
4. Шилдэг өвлөн суралцагч - 5 хүүхэд (тус бүр 300.000 төгрөг)						
1	Б.Лувсанжамц	Баян-Өлгий	12	Эрэгтэй	Ардын язгуур урлаг	Цуур
2	Б.Марал-Эрдэнэ	Сэлэнгэ	15	Эмэгтэй	Уламжлалт гар урлал	Эсгий урлал
3	Б.Гүнмөрөн -	Хөвсгөл	2	Эрэгтэй	Мал маллах арга ухаан	Цаа буга маллагаа
4	Ө.Маралжингоо	Ховд	13	Эмэгтэй	Ардын язгуур урлаг	Бий биелгээ
5	Ө. Баярхүү	Дорнод	13	Эрэгтэй	Ардын язгуур урлаг	
5. Шилдэг бүтээл үйлдвэрлэл – 5 баг (тус бүр 1.000.000 төгрөг)						
1	Увс аймаг				"Уялга" Ц.Батнасан	
2	Дундговь				"Агар" брэнд С.Бат-Эрдэнэ	
3	Улаанбаатар				Л.Бүрэнбаясах- Гэрийн үүсэл хөгжил- уламжлал	
4	Хэнтий				М.Мөнгөнбагана - Арьс ширийн урлал, Батноров хийц	
5	Дархан-уул				Б.Булганчимэг Монгол бичиг QR код	
6. Шилдэг гар урлал, үзэсгэлэн - 5 баг (тус бүр 1.000.000 төгрөг)						
1	Дорноговь аймаг					
2	Улаанбаатар хот					
3	Төв аймаг					
4	Өмнөговь аймаг					
5	Хэнтий аймаг					
7. Шилдэг аймаг						
1	Хөвсгөл				I байр 100,000,000 төгрөг	
2	Ховд				II байр 70,000,000 төгрөг	
3	Дорноговь				III байр 50,000,000 төгрөг	

4	Дундговь				Тусгай байр 20,000,000 төгрөг	
5	Өмнөговь				Тусгай байр 20,000,000 төгрөг	
Нийт шагналын сан 297,500,000 төгрөг						



Мөн, соёлын биет бус өвийн 6 дахь ай сав буюу Мал маллах арга ухааны өвлөн уламжлагчдын оролцоог богино хэмжээний (5-7 минут) контент байдлаар бэлтгэх ажлыг зохион байгуулж, 19 аймаг, нийслэлийн нийт 10.6GB-ийн багтаамжтай контент бүрдүүлэв. Доорх хүснэгтээр харуулав.

№	Аймаг, нийслэл	Контентийн агуулга	Хугацаа /цаг,мин, сек/	Цахим файлын хэмжээ
1	Архангай	Мал маллах арга ухаан	06 мин 34 сек	491 МВ
2	Баян-Өлгий	Мал маллах арга ухаан	06 мин 48 сек	309 МВ
3	Баянхонгор	Сарлаг	07 мин 38 сек	855 МВ
4	Булган	ирүүлээгүй		
5	Говь-Алтай	ирүүлээгүй		
6	Говь-Сүмбэр	Мал маллах арга ухаан - Д.Батмөнх	05 мин 46 сек	334 МВ
		М.Батсайхан	07 мин 04 сек	410 МВ
		Г.Адьяасүрэн	04 мин 44 сек	279 МВ
7	Дархан-Уул	Мал маллах арга ухаан	06 мин 18 сек	234 МВ
8	Дорноговь	Мал маллах арга ухаан	21 мин 48 сек	446 МВ
9	Дорнод	Зөөдөл богино	07 мин 54 сек	883 МВ
10	Дундговь	Мал маллах арга ухаан	09 мин 31 сек	687 МВ

11	Завхан	Айраг исгэх ёс	07 мин 54 сек	188 МВ
		Мал маллах арга ухаан	09 мин 28 сек	29.0 МВ
12	Орхон	Мал маллах арга ухаан	07 мин 01 сек	328 МВ
13	Өвөрхангай	Мал маллах арга ухаан	06 мин 59 сек	780 МВ
14	Өмнөговь	Мал маллах арга ухаан	07 мин 28 сек	780 МВ
15	Сүхбаатар	Мал маллах арга ухаан	07 мин 19 сек	841 МВ
16	Сэлэнгэ	мал хөнгөлөх ёс	04 мин 04 сек	454 МВ
17	Төв	Мал маллах арга ухаан	04 мин 50 сек	354 МВ
18	Увс	Мал маллах арга ухаан	07 мин 36 сек	458 МВ
19	Ховд	Мал маллах арга ухаан	07 мин 00 сек	516 МВ
20	Хөвсгөл	Цаатны нүүдэл	04 мин 38 сек	256 МВ
21	Хэнтий	Мал маллах арга ухаан-Д.Цагаан-Өвгөн	07 мин 37 сек	561 МВ
22	Улаанбаатар	Мал маллах арга ухаан	07 мин 26 сек	390 МВ
НИЙТ				10.6GB

“Зан үйл, язгуур урлагийн өргөө”

“Зан үйл, язгуур урлагийн өргөө”-нд соёлын биет бус өвийн уламжлал ахуй, орчныг бүрдүүлж, язгуур хэв шинж, нутгийн болон угсаатны онцлогийг харуулсан 40 минутын хугацаатай үзүүлэх тоглолтыг аймаг, нийслэл тус бүр зохион байгуулав. Үүнд:

АРХАНГАЙ АЙМАГ

№	Бүтээлийн нэр	Өвлөн уламжлагчийн нэр
1	Гэрийн ерөөл	СТА Ү.Дүүбат
2	Халх уртын дуу (Шанаган хуурчид)	Тэргүүний ардын авъяастан Г.Эрдэнэчулуун
		СТА Н.Баатар
		Тэргүүний ардын авъяастан Ж.Цэнд-Аюуш
		Тэргүүний ардын авъяастан Д.Пүрэвдулам Д.Чимэддорж
3	Өөлд бий биелгээ	Э.Саранжаргал
4	Цол дуудлга	Ц.Рагчаа
5	Дэмбээ	Д.Ганбаатар
		СТА Л.Ганболд
6	Халх богино дуу	Тэргүүний ардын авъяастан Ж.Цэнд-Аюуш
7	Миний Архангай тоглоом	Х.Батбаяр
8	Морин хуур	СТА Л.Ганболд
9	Баяд бий биелгээ	Р.Бүжин
10	Шударга хөгжим	Сурагч В.Уянга-Эрдэнэ
11	Нуман нуур	СТА Ж.Пүрэвдорж

		Н.Алтангэрэл
12	Хангайн магтаал	СТА Л.Энхцэцэг
		Б.Дэлгэрдалай
		СТА Б.Батсайхан
		Тэргүүний ардын авьяастан Б.Мөнх-Эрдэнэ

БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ

№	Бүтээлийн нэр	Өвлөн уламжлагчийн нэр
1	Казак зан үйл “Сүйт тавих ёс”	Муса Тилеубек, Жомарт Армангүл, Тилеген Аймөлдөр, Хумархан Саттигүл
2	Казак хурмин зан үйл “Бет ашар”	Муса Тилеубек, Жомарт Армангүл, Адилхан Инкарбек, Томпай Өркен
3	Күй - “Жекбе жек”	Ануарбек Исмайл
4	Естай-Хорлан	СТА Хумар Айгүл
5	Урианхай ардын дууны	СТА Равсаны Сайнбилэг
6	Күй - “Кусайын Кенжетал”	СТА Тилегений Аймөлдөр
7	Казак ардын дууны	Адилханы Инкарбек
8	Могой хээр морь минь	Октибрийн Хонгорзул
9	Казак ардын дууны	СТА Хумарханы Саттигүл

БАЯНХОНГОР АЙМАГ

№	Бүтээлийн нэр	Өвлөн уламжлагчийн нэр
1	Чулуун царгил хөгжим, чоны уриа дуудлага нэгдсэн үзүүлбэр	Тэмүжин театрын чулуун царгил хөгжмийн дугуйлангийн сурагчид
2	Төв халхын “Хурмын ерөөл”	Ардын авьяастан Д. Амарбаяр н.Түшвинжаргал
3	Төв халхын “Адуучин” магтаал	Ардын авьяастан Б.Занданболд
4	Даш до гүний хошууны уртын дуу “Баялаг хангай”	Ардын авьяастан н.Энхболд
5	“Их богд уул” уртын дуу	СТА Д.Хорлоо
6	“Дуутай хуруу” үзүүлбэр тоглолт	н.Ёндонжамц ахлагчтай баг
8	“Жэгүүн жэгүүн мэргэн хаан, цагаан төмөр хаан” төв халхын тууль	Ардын авьяастан Ч.Мягмарсүрэн
9	“Тахил” наадгай үзүүлбэр	СТА н.Үнэнбуян ахлагчтай баг

БУЛГАН АЙМАГ

№	Бүтээлийн нэр	Өвлөн уламжлагчийн нэрс
1	Бэлэг дэмбэрлийн үгс	Д.Оюун-эрдэнэ
2	Цол дуудлага	Д.Зоригт
3	Үзэмчин – Дарьганга уртын дуу Морин хуур	н.Янжинлхам Б.Лхагвацэнгэл
4	Уран нугаралт	Б.Цэнгүүн Б.Хүслэн Н.Энхжин
5	Алтаргана Буриад богино дуу	Ч.Мөнхсүх
6	Халх богино дуу	Г.Батдорж
7	Хотон бии биелгээ	Э.Ангараг

		Б.Гэрэлт-ирээдүй У.Эрдэнэсүвд Э.Эрдэнэбат Д.Буянжаргал Б.Даваажаргал
8	Битүү амьсгаагаар лимбэдэх	Батбаяр
9	Наадам дээр буриад богино дуу	Б.Мөнхзул

ГОВЬСҮМБЭР АЙМАГ

№	Бүтээлийн нэр	Өвлөн уламжлагчийн нэр
1	Гэрийн эзэн найрын дарга, ерөөл хоёрыг урина: Хадаг барина.	Хөдөлмөрийн гавьяаны улаан тугийн одонт Д.Лхагвасүрэн
2	Гэрийн ерөөл-Хадган боосон хонины сүүлтэй мод барина	СТА Ерөөлч О.Алтанхүү
3	Найрын дарга найрын дэг танилцуулж хулч, сөнч нарыг томилно	Сөнч Г.Батсайхан. Хулч Д.Сэлэнгэ , Г.Мягмардорж
4	“Түмэн эх” боржигин уртын дуу. Дугараа	Дуучин МУСТА О.Алтанхүү Түрлэг: Эрэгтэйчүүд МУСТА Г.Арилд МУСТА Д.Энхтулга
5	“Зүйтийн тал” Боржигин уртын дуу	Морин хуурч Г.Арилд. Лимбэч Д.Энхтулга
6	Дугараа, солбио дагнаа	Оролцогчид
7	“Жаргалтайн дэлгэр” боржигин уртын дуу, түрлэг	Уртын дуучин Г.Арилд Бусад дуучид түрнэ
8	Сөнгийн ерөөл-хадаг барина	Ерөөлч: Г.Батсайхан
9	Найр дэлгэрэх хэсэг	Д.Лхагвасүрэн
10	Найрын дарга Д.Лхагвасүрэн	Сөнч Сэлэнгэ, Хулч Г.Мягмардорж, МУ-ын Тэргүүний ардын авьяастан Г.Батсайхан
11	“Баяр наадмын уриа”	Уртын дуучин Г.Арилд
12	“Дөрвөн настай бор” боржигин уртын дуу	Уртын дуучин О.Бадамцэцэг
13	“Ардын дууны найруулга”	Шанзчин Ж.Цэндмаа
14	“Зээргэнэтийн шил”боржигин уртын дуу	Уртын дуучид А.Саранзул А.Хоролоо
15	“Ар хөвчийн унага”	Боржигин уртын дуучин Э. Дашжаргал

ДАРХАН-УУЛ АЙМАГ

№	Бүтээлийн нэр	Өвлөн уламжлагчийн нэр
Эхлэл: Ая. Д.Лувсаншарав МУ-ын хөдөлмөрийн баатар, Төрийн соёрхолт, Ардын жүжигчин Үг. Д.Пүрэвдорж МУ-ын хөдөлмөрийн баатар, Ардын уран зохиолч, Төрийн шагналт “Дархан хотын сүлд дуу”		
1	Магтаал Д.Пүрэвдорж “Төрийн түмэн эх”	МУСТА, Алтан гадас одонт Ц.Дүйнхэрсүрэн /70 настай/
2	Уртын дуу “Эр бор харцага”	МУСТА Б.Дарханням /41 настай/

	Уртын дуу “Шалзад баахан шарга”	МУСТА Алтан гадас, Хөдөлмөрийн гавьяаны улаан тугын одонт Р.Содовдорж /74 настай/
3	Хөгжмийн дөрвөл “Монгол ардын 2 дууны найруулга”	МУСТА, Алтан гадас одонт Ц.Дүйнхэрсүрэн /70 настай/
		МУСТА, Алтан гадас одонт Д.Жавзанжав /69 настай/
		МУСТА, Хөдөлмөрийн хүндэт Ц.Цэрэнжав /64 настай/
		МУСТА Ш.Алтанцэцэг /61 настай/
	-Зан үйл “Гурил тээрэмдэх”	Ч.Зунгарай /82 настай/
4	Хотгойд ардын дуу “Жаран цагаан хонь”	Ш.Наранцэцэг /66 настай/
5	Ташлын урлаг “Жалам хар”, “Могой хээр”	П.Батжаргал /59 настай/
6	Хулсан хуур “Ардын хоёр дууны найруулга”	МУСТА, Алтан гадас одонт Д.Жавзанжав /69 настай/
7	Магтаал “Гэрийн ерөөл” Ардын дуу “Эрүү цагаан болжмор”	Б.Дарханням /41 настай/
8	Ардын дуу “Лоолой”	С.Отгонцэцэг /41 настай/
9	Уран нугаралт “Хайрын бурхан”, “Монгол шигтгээ”	М.Ариунчимэг /16 настай/
		М.Мөнгөнчимэг /14 настай/
10	Ардын дуу “Сүнжидмаа”	МУСТА, МУ-ын тэргүүний уран сайханч, Алтан гадас одон, Хөдөлмөрийн гавьяаны улаан тугын одонт Р.Содовдорж /74 настай/
11	Хөгжмийн дуэт УГЗ Пүрэвхүү “Экилийн эгшигт нутаг”	МУСТА, Алтан гадас одонт Ц.Дүйнхэрсүрэн /70 настай/
		МУСТА, Алтан гадас одонт Д.Жавзанжав /69 настай/
12	Үзэмчин ардын дуу “Янтайван геге”	МУСТА Ж.Цэвэлмаа /74 настай/
13	Домборын гоцлол	МУСТА, Ардын авьяастан Х.Балхаш /54 настай/
14	Бөхийн цол	Ерөөлч, магтаалч, Улсын морь бөх цоллооч МУСТА Б.Дарханням /41 настай/
	Морьны цол	Д.Гантөгс /13 настай/
15	Бий биелгээ “Хотон цацал”	Бүх бий биелээчид
	Хотон бий биелгээ “Хөдөлмөр”	Ардын авьяастан Д.Буяндэлгэр /76 настай/
		Ардын авьяастан Ч.Орлом /70 настай/
		Б.Мөнгөн, /76 настай/ /Хотон бий биелгээ Экил хуураар татна/

Урианхай бий биелгээ	Ш.Амгалан /67 настай/
	Г.Дархан-Очир /8 настай/ /Ач хүү/
	С.Ариунбилэг /10 настай/ /Зээ охин/
Хотон бий биелгээ “Журай гэлдэн”	МУСТА Х. Журай /66 настай/
	Б.Даариймаа /61 настай/
Дөрвөдийн бий биелгээ	Ардын авъяастан С.Одонцоо /52 настай/
	Х.Энхсаран /13 настай/
	Х.Алтансүх / 6 настай/
Баяд бий биелгээ “Элхэндэг”	Алтангадас одонт, Ардын авъяастан,Б.Дэжидмаа /57 настай/
	А.Дэмбэрэлнямбуу /43 настай/ /Баядын бий биелгээг Экил хуураар татна/
Хотон бий биелгээ “Цэдэн залуу”	Монгол Улсын Тэргүүний ардын авъяастан Б.Таамж /65 настай/ Б.Мөнгөн, /76 настай/ /Хотон бий биелгээ Экил хуураар татна/
	“Журай гэлдэн” Бүх бий биелээчид
Төгсгөл: Үг: Төрийн шагналт яруу найрагч Д.Сэнгээ Ая: Төрийн шагналт, Ардын жүжигчин, хөгжмийн зохиолч Л. Мөрдорж “Эх орон дуу”	

ДОРНОГОВЬ АЙМАГ

№	Бүтээлийн нэр	Өвлөн уламжлагчийн нэр
1	Морин хуурын магтаал	Х.Данзанравжаа, Г.Мөнхзаяа, Д.Дөлгөөн, Ч.Бардаваа, Ч.Эрдэнэбаатар
2	Нутгийн ардын татлага “Хар хоолойн жонон”	Х.Данзанравжаа, Ч.Эрдэнэбаатар
3	Монгол ардын уртын дуу “Өвгөн шувуу”	Довчиндоржийн Батдэлгэр, МУСТА Ганхуягийн Мөнхзаяа
4	Монгол ардын уртын дуу “Хурмаст тэнгэр” /Лимбэ хөгжмийн битүү амьсгаа/	Ариунцэцэгийн Уранжаргал
5	Ардын дуу “Жонхуу муутуу хоёр” /Шанз хөгжим/	Монгол улсын Тэргүүний ардын авъяастан Мөнгөнцэцэгийн Бумбааш

6	Нутгийн ардын дуу “Мэргэ вангийн нутаг”	Монгол Улсын Гавьяат жүжигчин Нанзадын Лантуу
7	Монгол ардын үлгэр, домог, сургаалийн аялгуут холбоо	Хуягбаатарын Данзанравжаа, Ганхуягийн Мөнхзаяа, Чинбатын Бардаваа, Тэрбишийн Одхишиг, Даваасүрэнгийн Дөлгөөн, Чулуунбаатарын Эрдэнэбаатар
8	Монгол ардын хоёр дуу/Боржигин морин хуур, исгэрээ, зуучин хуур/	СТА Халтарын Болдбаатар, СТА Сэрээдоржийн Лхагвасүрэн
9	“Хар хур шувууны дуудлага, хөөмэйн холбоо”	Чинбатын Бардаваа
10	Нутгийн ардын дуу “Уулзаж явлаа”	СТА Тэрбишийн Одхишиг
11	Нутгийн ардын дуу “Энх мэндийн баяр”	Дорноговь аймгийн соёлын биет бус өвийг өвлөн уламжлагчид

ДОРНОД АЙМАГ

№	Бүтээлийн нэр	Өвлөн уламжлагчийн нэр
1	Ерөөл	Э.Ганбат
2	Цол дуудах	Т.Амгалан
3	Буриад дайралцаа	Г.Буяндэлгэр Ө.Баярхүү
4	Магтаал	Ш.Отгонбаатар
5	Ёохор бүжиг	Б.Эрдэнэбаатар Д.Оюунчимэг Ц.Нарантуяа Т.Түмэнцэцэг Х.Чанцал Л.Балдандорж
6	Зээрэнхий бөөрөнхий бүжиг	А.Бөртэ-Үжин Э.Цэндмаа С.Мөнхтөмөр У.Талынбүүвэй
7	Уртын дуу	Л.Хишигдэлгэр
8	Тагнай ташил, Морин хуур	Тэргүүний ардын авьяастан Д.Батзаяа
9	4 утастай хуур	СТА Д.Энхзаяа
10	Суух хуурын магтаал	СТА Ө.Лхамдорж
11	Үзэмчин уртын дуу	СТА М.Мөнхжаргал
12	Сэрэг ботгох ёслол	Б.Ганцэцэг М.Долгорсүрэн

		Ч.Жаргалмаа Г.Саранхуяг Ц.Одсүрэн Л.Эрдэнбаяр Л.Есөнтөмөр Г.Дэндэв
--	--	---

ДУНДГОВЬ АЙМАГ

№	Бүтээлийн нэр	Өвлөн уламжлагчийн нэр
1	Цэцлэн ерөөх	МУ-ын Тэргүүний ардын авьяастан Б.Эрдэнэбаатар
2	Будал, Цолмон, Дөмөн Жаргалтайн дэлгэр боржигон аялгуу /Монгол ардын дуу/ “Сэрүүн сайхан хангай” уртын дуу /боржигон аялгуу/	МУСТА Т.Шонуу, Р.Хандсүрэн Ч.Шинэбаяр
3	Монгол ардын харилцаа дуу	МУ-ын Тэргүүний ардын авьяастан Д.Лхагвадорж МУ-ын Тэргүүний ардын авьяастан Ч.Баатар
4	Монгол ардын дууны найруулга /товшуур хөгжмөөр ташлын төрөлд дангилдах/	МУСТА Ц.Хадхүү
5	33 говийн магтаал	Ч.Өрнөлт
6	Таван хошуу малын уриа дуудлага	МУСТА Ч.Шинэбаяр, Т.Шануу, Р.Хандсүрэн
7	“Хөхөө намжил” домог	МУСТА Б.Ууганбаяр
8	Төв халх татлага морин хуур /өөрийн бүтээл/	МУСТА Ё.Нэргүй
9	“Агай улаан хаан” халх тууль, “Дэлгэрхангайн магтаал”	Б.Сэрчмаа, У.Мэндбаяр, С.Нарангоо
10	Монгол ардын дуу	МУСТА Л.Сарангэрэл Б.Сосорбурам Х.Төмөрбат Б.Батцэрэн

ЗАВХАН АЙМАГ

№	Бүтээлийн нэр	Өвлөн уламжлагчийн нэр
1	Отгонтэнгэр хайрханы магтаал “Оройн чимэг” уртын дууны 1,2 дугаар бадаг	МУСТА Ж.Оюун МУСТА О.Бат-Өлзий МУСТА Р.Хашбат Ж.Ёндонренчин
2	Морин хуур хөгжмийн уламжлалт татлага	Б.Бинчин
3	“Богдын өндөр” Нутгийн ардын уртын дуу	Ж.Ёндонренчин
4	Идэр нутгийн хуримын ерөөл	МУСТА С.Амардаваа

5	Отгонтэнгэр хайрханы магтаал “Оройн чимэг” уртын дууны 2,3 дугаар бадаг	МУСТА Ж.Оюун МУСТА О.Бат-Өлзий Р.Хашбат Ж.Ёндонренчин
6	Хулсан хуур хөгжим	МУСТА Ж.Оюун
7	Уран нугаралтын үзүүлбэр	С.Дэлгэрмаа Э.Энхзул
8	Монгол ардын дуу	МУСТА Б.Дэмбэрэлнямбуу
9	Отгонтэнгэр хайрханы магтаал “Оройн чимэг” уртын дууны 5,6,7 дугаар бадаг	МУСТА Ж.Оюун МУСТА О.Бат-Өлзий МУСТА Р.Хашбат Ж.Ёндонренчин
10	МАУртын дуу “Дөмөн” Бүүвэйн дуу	МУСТА Б.Отгонжаргал
11	Хулсан хуур, Монгол ардын үлгэр	Д.Цэрэндаваа
12	Отгонтэнгэр хайрханы магтаал “Оройн чимэг” уртын дууны 8,9,10 дугаар бадаг	МУСТА Ж.Оюун МУСТА О.Бат-Өлзий МУСТА Р.Хашбат Ж.Ёндонренчин
13	Монгол ардын уртын дуу “Сэвхэт бор”	МУСТА Р.Хашбат
14	Монгол ардын уртын дуу “Тосонгийн орой”	МУСТА Л.Баасанжав
15	Отгонтэнгэр хайрханы магтаал “Оройн чимэг” уртын дууны 14,15,16 дугаар бадаг	МУСТА Ж.Оюун МУСТА О.Бат-Өлзий МУСТА Р.Хашбат Ж.Ёндонренчин
16	Бий биелгээ	Ц.Бадамаа
17	Исгэрээ, бөхийн цол	Б.Зоригт
18	Хөөмэй, хархираа	Б.Намбардагжин
19	Ерөөл магтаал	С.Дашдэлэг
20	Отгонтэнгэр хайрханы магтаал “Оройн чимэг” уртын дууны 17,18,19 дүгээр бадаг	МУСТА Ж.Оюун МУСТА О.Бат-Өлзий МУСТА Р.Хашбат Ж.Ёндонренчин

ОРХОН АЙМАГ

№	Бүтээлийн нэр	Өвлөн уламжлагчийн нэр
1	Монгол ардын Уртын дуу “Дөрвөн цаг ” дууны домог	МУСТА Бэгзсүрэн Одончимэг
2	Монгол ардын Уртын дуу “Эртний сайхан”	Ардын авьяастан Утайхүү Отгонсүрэн
3	Гэрийн ерөөл	МУСТА Нямдэлэг Гүндэгмаа
4	Хотон богино дуу “Өндөр заагийн шил”	Сайнжаргал Оюунтунгалаг
5	Хотгойд богино дуу “Дэлтэй цэнхэр”	Ардын авьяастан Лхагважав Эрдэнэчимэг
6	Дархад богино дуу “Цэцэгтэй хормой”	Ардын авьяастан Баян Баярсайхан
7	Халх богино дуу “Нуруу нь алаг шаазгай”	МУСТА Ядам Шаш
8	Эрдэнэтийн магтаал	МУСТА Ишдорж Гомболхүүдэв
9	Урианхай аман аялгуу	МУСТА Гүнжил Мөнгөнчимэг

10	Дайралцаа үг	Шарав Мянганбаяр, Бэгзсүрэн Одончимэг
11	Түргэн хэллэг	МУСТА Агваан Пунсалдулам
12	Морин хуур	Хайдав Эрдэнэбат
13	Уран нугаралт	Эрдэнэлүрэв Нарангарав
14	Хөөмий	МУСТА Мягмаржав Саруултөгс
15	Бий биелгээ /Олон ястан/	Ардын авьяастан, Икэлч Гүзээн Бүүвэйбаатар /Биелээчид/

ӨВӨРХАНГАЙ АЙМАГ

№	Бүтээлийн нэр	Өвлөн уламжлагчийн нэр
1	Монгол Ардын Уртын “Эртний сайхан” уртын дуучид	
2	XIII дугаар зууны Эзэнт гүрний нийслэлийн шав тавьсан газрын магтаал	А.Лүндээжанцан
3	Хөгжмийн гоцлол (Лимбэний битүү амьсгаа)	МУСТА Нямдэлэг Гүндэгмаа
4	Хотон богино дуу “Өндөр заагийн шил”	Сайнжаргал Оюунтунгалаг
5	Хотгойд богино дуу “Дэлтэй цэнхэр”	Ардын авьяастан Лхагважав Эрдэнэчимэг
6	Дархад богино дуу “Цэцэгтэй хормой”	Ардын авьяастан Баян Баярсайхан
7	Халх богино дуу “Нуруу нь алаг шаазгай”	МУСТА Ядам Шаш
8	Эрдэнэтийн магтаал	МУСТА Ишдорж Гомболхүүдэв
9	Урианхай аман аялгуу	МУСТА Гүнжил Мөнгөнчимэг
10	Дайралцаа үг	Шарав Мянганбаяр, Бэгзсүрэн Одончимэг
11	Түргэн хэллэг	МУСТА Агваан Пунсалдулам
12	Морин хуур	Хайдав Эрдэнэбат
13	Уран нугаралт	Эрдэнэлүрэв Нарангарав
14	Хөөмий	МУСТА Мягмаржав Саруултөгс
15	Бий биелгээ /Олон ястан/	Ардын авьяастан, Икэлч Гүзээн Бүүвэйбаатар /Биелээчид/

ӨМНӨГОВЬ АЙМАГ

№	Бүтээлийн нэр	Өвлөн уламжлагчийн нэр
1	“Нүүдэл тосох” зан үйл	Ардын авьяастанууд
2	Монгол уран бичлэг “Хээр хэвтэвч яс нэг, хэвлийд урсавч цус нэг” Батмөнх даян цэцэн хаан гэж бичээд туг болгоо	Уран бичээч Б.Ганзориг
		Б.Аюуш

3	“Уулган шарын явдал” нутгийн хуурын татлаганы аяанд “Их говийн ингэн бүүвэй” бүжиг	А.Тунгалагтамир Н.Дэлгэрмаа Ч.Оюундарь Б.Анар Н.Тэнүүн
		Э.Мөнхсүлд А.Амирлан Н.Аминхүслэн Т.Хөхдэй
		Морин хуурч Ө.Батжаргал
4	Говийн айлын гадаа дээс томох, утас ээрэх, зоодой хийх, сур элдэх, шагайн харваа	Ардын авьяастнууд
5	“Шилийн говьд нутагтай Ширмэн мөндөр баатар” говь нутгийн туулийн хэсгээс хайлна.	Ө.Батжаргал ахмад үе Ё.Гандулам дунд үе
		Б.Сайнгэрэл залуу үе
6	“Нарын хээр, Хурдан сайхан” нутгийн уртын дуу	Ц.Содномцэенпи
		Б.Хүүхэндүү
		Т.Тогосмаа
		С.Хасбаатар
7	Шууд цэцлэн ерөөх, ахмад, дунд, залуу гурван үеийн ерөөлч “Нүүдэлчин монгол-2022” Соёлын биет бус өвийн наадам “Өмнөговь аймгийн ерөөл”, “Тэмээний ерөөл”	Э.Эрдэнэчулуун Нийт ардын авьяастан
		С.Мөнхжаргал ахмад үе
		Г.Батзориг дунд үе Д.Мөнгөнбаатар залуу үе
8	“Бүжин туулай” нутгийн ардын дуу	Ж. Дагвасамба
9	“Тэмээний алхаа, жонжоо” аман хуурын ардын татлага	Б.Хүүхэндүү ахмад үе Т.Бөгбаатар дунд үе
		Б.Оюухай залуу үе
10	“Манантай хөндий, Жамбал гуай” нутгийн ардын харилцаа дуу	Б.Хүүхэндүү Ө.Батжаргал Нийт ардын авьяастан
	“Дөрвөн цаг” монгол ардын уртын дуу лимбэний битүү амьсгаагаар тоглох	Ө.Батжаргал ахмад үе
		Б.Энхжин дунд үе

11	уламжлалт арга барилаар хөгжимдөнө.	О.Одхүү залуу үе
12	“Балдан засгийн жонон” морин хуурын татлага	Мөнхсүлд С.Хасбаатар Ө.Батжаргал
13	Домог	Д.Мөнхбаатар
14	“Говийн өндөр” нутгийн ардын дууг хоолойн лимбэ, лимбэний битүү амьсгаагаар тоглоно.	Т.Бөгбаатар хоолойн лимбэ Б.Энхжин лимбэ, О.Одхүү лимбэ
15	Таван хошуу малын уриа дуудлага	Ж.Дагвасамба
16	“Ахуйн биелгээ”	Б.Аюуш А.Тунгалагтамир Дэлгэрмаа Б.Анар Г.Мөнхсүлд А.Амирлан Н.Аминхүслэн Н.Тэнүүн
17	Цагаан идээ боловсруулах, цагаа чанах, ингэний цэнхэр нэрэх, сүү хөөрүүлэх	Ч.Өнөрдэлгэр
18	“Монгол ардын Зүйр цэцэн үг” тэмээн хуучир хөгжимд аялгуулан хэлнэ.	Ө.Батжаргал З.Чулуунцэцэг А.Отгонбат
19	“Нүүдэлчин монгол-2022” соёлын биет бус өвийн наадам, Өмнөговь отог монгол уран бичлэг	Г.Ганзориг
20	“Шилийн говьд нутагтай Ширмэн мөндөр баатар” говь нутгийн туулийн төгсгөл хэсгийг хайлна.	Ө.Батжаргал ахмад үе Ё.Гандулам дунд үе Б.Сайнгэрэл залуу үе нийт ардын авьяастан

СҮХБААТАР АЙМАГ

№	Бүтээлийн нэр	Өвлөн уламжлагчийн нэр
1	Ардын дуу	Ч.Должин
2		Л.Гантуул
3		Ө.Миеэгомбо
4		Б.Мөнхтулга
5		Б.Чанцалдулам
6		Ц.Хосбаяр
7		Д.Адъяа

8	Ардын хөгжим	С.Бат-Орших
9		Ж.Чойжилсүрэн
10		Н.Уранбилэг
11		Б.Банзрагч
12		М.Ангармөрөн
13		Э.Сэвжидмаа
14		М.Ганболд
15	Аман билэг	З.Далай
16		З.Түвшинбаяр
17	Оролцон тоглогч	Ч.Ганхүү
18		Б.Мянганбаяр
19		Х.Отгонтөгс
20		Ц.Батнаран
21		О.Батзаяа
22		О.Уранзаяа
23		М.Батцэцэг
24		Б.Энхзул
25		Э.Алдармаа
26		Д.Энхсүвд
27		Л.Сарангоо
28		Б.Долгормаа

СЭЛЭНГЭ АЙМАГ

№	Бүтээлийн нэр	Өвлөн уламжлагчийн нэр
1	“Оломгүй далай” уртын дуу	Уртын дуучин- Баруун бүрэн сумын ардын авьяастан Монгол Улсын Тэргүүний ардын авьяастан Тогтохын Батбаатар, Алтанбулаг сумын ардын авьяастан Сайнбаярын Пүрэвсүрэн Морин хуурч-Жавхлант сумын ардын авьяастан Болдбаатар.Баттулга
2	Шинэ гэрийн ерөөл, айлтгал	Ерөөлч, Магтаалч- Жавхлант сумын ардын авьяастан, Монгол Улсын Соёлын тэргүүний ажилтан Мотоогийн Дашдорж
3	Ардын язгуур урлагийн хөгжмийн цөөхүүл	Морин хуурч, хөөмийч - Жавхлант сумын ардын авьяастан Болдбаатар.Баттулга Цуур хөгжимчин- Баруунбүрэн сумын ардын авьяастан Н.Гантогтох Лимбэчин- Ерөө сумын ардын авьяастан Сүхбаатарын Чинчулуун Шанз- Баруунбүрэн сумын ардын авьяастан Монгол Улсын Соёлын тэргүүний ажилтан, Боловсролын Тэргүүний ажилтан Б.Алтай Ятга- Жавхлант сумын ардын авьяастан Монгол Улсын Соёлын тэргүүний ажилтан Гэлдээгийн Бямбасүрэн
4	Хөөмий	Хөөмийч- Жавхлант сумын ардын авьяастан Монгол Улсын Соёлын тэргүүний ажилтан Баатархүүгийн Оюунбат, Монгол Улсын соёлын тэргүүний ажилтан

		Мотоогийн Дашдорж, Болдбаатарын Баттулга, Ганбаатарын Ууганбаатар, Гантөмөрийн Ганбагана
5	“Еэвэн голын голын урсгал” икэл хуурийн татлага	Икэл хуурийн татлага- Баруун бүрэн сумын ардын авьяастан Монгол Улсын Ардын Тэргүүний авьяастан Ү.Цогбадрах
6	Язгуур урлаг бий биелгээ	Цацал биелгээ-Баруун бүрэн сумын ардын авьяастан Монгол Улсын Соёлын тэргүүний ажилтан, Боловсролын Тэргүүний ажилтан Бат-Очирын Алтай, Шавганцын Нүрдээ, Ац биелгээ- Баруун бүрэн сумын ардын авьяастан Монгол Улсын Тэргүүний ардын авьяастан Надмидын Гантогтох Сэдэн залуу биелгээ- Баруун бүрэн сумын ардын авьяастан Монгол Улсын Тэргүүний ардын авьяастан Ц.Цолмон, Баруун бүрэн сумын ардын авьяастан Монгол Улсын Соёлын тэргүүний ажилтан, Боловсролын Тэргүүний ажилтан Бат-Очирын Алтай Жороо биелгээ- Баруун бүрэн сумын ардын авьяастан Ш.Нүрдээ, Баруун бүрэн сумын ардын авьяастан Монгол Улсын Соёлын тэргүүний ажилтан, Боловсролын Тэргүүний ажилтан Бат-Очирын Алтай Балчин хээр- Баруун бүрэн сумын ардын авьяастан Монгол Улсын Тэргүүний ардын авьяастан Ц.Цолмон, Баруунбүрэн сумын ардын авьяастан Монгол Улсын Соёлын тэргүүний ажилтан, Боловсролын Тэргүүний ажилтан Бат-Очирын Алтай, Захчин биелгээ-Жавхлант сумын ардын авьяастан Монгол Улсын Соёлын тэргүүний ажилтан Лхасүрэнгийн Халтмаа, Баяд бий биелгээ- Жавхлант сумын ардын авьяастан Монгол Улсын Соёлын тэргүүний ажилтан Гэлдээгийн Бямбасүрэн, Жавхлант сумын ардын авьяастан Гантөмөрийн Ганбагана, Чинбатын Мөнхжин Жуурай гэлдэн-Бүх бийч Дөрвөд ойрд – Бүх бийч

ТӨВ АЙМАГ

№	Бүтээлийн нэр	Өвлөн уламжлагчийн нэр
1	Гэрийн эзэн ламд хадаг барьж ном айлтгахыг хүснэ.	Зуунмод сумын ардын авьяастан А.Ганзориг
2	Гэрийн эзэн Ерөөлчид гүү барихын Ерөөл хэлэхийг хүсч хадаг барина.	
3	Гэрийн эзэн уртын дуучдад “Хурдан сайхан” гэдэг дууг өргөхийг аяны дугараа өргөнө.	
4	“Жороо биелгээ” ардын авьяастанууд биелнэ.	Алтанбулаг сумын ардын авьяастан Н.Занданбал, Аргалант сумын ардын авьяастан О.Мөнгөнсүх
5	Цоохор морь	Борнуур сумын ардын авьяастан Т.Алтантулга

6	Жороо хэллэг	Зуунмод сумын ардын авьяастан Д.Эрдэнэбаатар, Борнуур сумын ардын авьяастан Н.Ургамал
7	Хүүхдийн наадгай ардын авьяастан бүжигчид бүжиглэнэ.	Баянчандмань сумын ардын авьяастан Ц.Мөнхбаяр, Цээл сумын ардын авьяастан Н.Надинцэцэг, Өндөрширээт сумын ардын авьяастан Б.Сансарбилэг, Борнуур сумын ардын авьяастан Т.Ануцэцэг, Батсүмбэр сумын ардын авьяастан П.Хонгорзул
8	“Монгол ардын хоёр дуу” ардын авьяастнуудын цөөхүүл хөгжимдөнө. Монгол ардын дуу Жавхлант адуун сүрэг Уртын дуучид дуулна. Цөөхүүл хөгжимчид хөгжимдөнө.	

УВС АЙМАГ

№	Бүтээлийн нэр	Өвлөн уламжлагчийн нэр
1	Баяд хуримын ерөөл	Ч.Батбаатар
2	Дөрвөд гэрийн ерөөл	Ц.Лхагва
3	Баядын тууль	М.Цолмонхүү
4	Тууль	Н.Анхбаяр, Н.Намсрай
5	Дөрвөд тууль	А.Алтангэрэл
6	Икэлийн татлага	М.Балжир, И.Төгсөө
7	Дөрвөд бий биелгээ	Б.Буянжаргал, Б.Дөлгөөн -Эрдэнэ, Д.Соёлхүү,
8	Дөрвөд ардын уртын дуу	С.Намсрай, Ч.Оюунбилэг, Б.Сүрэн
9	Ангийн уриа дуудлага	П.Мөнхсайхан
10	Хөөмий	А.Лхагва, Х.Жамсран
11	Баядын икэлийн татлага	Ж.Хумбаа, З.Дэлгэр, Н.Намсрай
12	Баядын бий биелгээ	Д.Дорж, М.Цэдгээ,
13	Баяд ардын уртын дуу	Д.Бямбадорж
14	Хөөмий, Цуур	Н.Нансалмаа
15	Ардын богино дуу	Х.Түмэнжаргал Б.Бадам
16	Хотон икэлийн татлага	Х.Түмэнжаргал

17	Хотон бий биелгээ	А.Дөлгөөн, С.Батсүх, И.Рагчаадорж, Т.Оюун, Б.Чунаг, Б.Бадам
18	Элжгэн халх уртын дуу	Д.Нина

ХОВД АЙМАГ

№	Бүтээлийн нэр	Өвлөн уламжлагчийн нэр
1	Уул овоо тахих зан үйл	Х.Баярсайхан
2	Алтайн магтаал	Р.Даваажав
		Д.Батзаяа
		Б.Золбоо
		А.Баатарням
		Н.Буяндэлгэр
		Э.Гомбожав
3	Тууль хайлах	Д.Дамдиндорж
		Ц.Цэндсүрэн
4	Уртын дуу	Х.Ганбат
		Б.Дагвадорж
		Н.Мөнжин
5	Уран нугаралт	М.Марал-Эрдэнэ
		Б.Ганцоож
		Э.Болормаа
		Н.Үржинбадам
6	Домборын кюй	К.Сатыпалды
7	Сариг тэх наадуулах	Г.Хонгороо
8	Олон угсаатны бий биелгээ	Т.Цэмбэл
		Г.Цэнд-Аюуш
		Х.Баяраа
		Г.Бямбажав
		Б.Бадамцэцэг
		Д.Нандинцэцэг
		Б.Хишигтөгөлдөр
		Ө.Маралжингоо
		О.Энхсайхан
		Б.Азжаргал
		А.Цэндмаа
		Э.Байгаль
9	Морин хуур	Э.Энхжин
		Б.Мөнхгэрэл
10	Бэр буулгах зан үйл	Б.Энхболд

ХӨВСГӨЛ АЙМАГ

№	Бүтээлийн нэр	Өвлөн уламжлагчийн нэр
1	Уйгар ардын дуу “Самгалдай” хоолойн лимбэ	О.Лхагваажий Б.Янжиндулам
2	“Самгалдай”	Н.Цогбадрах Д.Агармаа М.Солонго
3	Цаатан бүжиг	Д.Батдэмбэрэл
		Г.Пүрэвням
		Э.Цэцэнгүнж

		Т.Даваатогтох М.Баярмаа Т.Анужин Д.Отгонтүвшин
4	Уйгар ардын дуу “Улуг хэмбээ”	Ч.Бундхорол
5	“Тайгын эгшиг” хөгжмийн хамтлаг	Л.Түдэв Б.Батцогт О.Лхагваажий Д.Чинбат Д.Агармаа
6	Уйгар ардын дуу “Авая огла”	М.Солонго
7	Уйгар бөөгийн тамлага	Д.Чинбат
8	Бөөгийн бүжиг	Д.Батдэмбэрэл Өвлөн уламжлагчид
9	Уйгар дуу	М.Навчаа
10	Ангийн дуудлага	Б.Батцогт Л.Түдэв Д.Чинбат
11	Уйгар үлгэр	М.Солонго Б.Болорцэцэг

ХЭНТИЙ АЙМАГ

№	Бүтээлийн нэр	Өвлөн уламжлагчийн нэр
1	Чингис хааны магтаал	Т.Мөнхтөр
2	Ёохор хатар	Өвлөн уламжлагч нар
3	Хэрлэнгийн бариа	Д.Ариунчимэг, масс
4	Үлгэр	Б.Нансалмаа, хуурч Р.Энхбаяр
5	Жонон харын татлага	Д.Ганчөдөр, П.Бямбадагва, Т.Мөнхтөр
6	Буриад ардын дуу	Ц.Ариунаа, Д.Гэрэлтуяа
7	Халх бүжиг	М.Соёлсүвд, Масс
	Нийтийн үзүүлбэр	Өвлөн уламжлагч нар

УЛААНБААТАР ХОТ

Урлагийн тоглолтын нэр: Долоон хошуу наадам

Тоглолтын хугацаа: 40 минут

Хүрээ: XX зууны эхэн үеийн Даншиг наадмаас 1911 онд Монгол Улс тусгаар тогтнож, Их Хүрээг улсын нийслэл хот болгож, Нийслэл Хүрээ болгосон арваад жилийн хүрээг хамарна.

Тоглолтын агуулга: Даншиг наадмын нөлөөгөөр Улаанбаатар хот, тэр үеийн Их Хүрээ монголчуудын нийгэм соёлын төв болж, Монгол Улс тусгаар тогтносон гэсэн санааг илтгэн харуулна.

Тоглолтын бүтэц: 3 бүлэг (Даншгийн ёслол, Даншиг наадам, Төрийн тусгаар тогтнол), 9 үзэгдэл

Тоглолтын үзүүлбэр: Тоглолтод уртын дуу (Эртний сайхан, Эрхэм төр, Түмний эх), богино дуу (Зуун лангийн жороо луус) дуулагдаж, ардын бүжиг, уран нугаралт, дуу хөгжим тоглогдоно. Мөн, хурдан морь, бөх, харваачдын цол дуудагдана. Богд хааны зарлиг, ерөөл магтаалыг хэлж, олон үндэстэн ястны урлагийн тоглолтын цоморлигоор тоглолтыг хаана.



Гар урлалын үзэсгэлэн өргөө

“Гар урлалын үзэсгэлэн өргөө”-нд нутгийн онцлогтой малын тоног хэрэгсэл, уран хатгамал, ширмэл, сийлбэр, уран дарханы урлал гэх мэт гар урлалын бүтээлийн үзэсгэлэнг, “Соёлын биет бус өвийг таниулан сурталчлах өргөө”-нд уламжлалт тоглоом наадгай, бэсрэг уралдаан, тэмцээн зэрэг танин мэдэхүйн болон суралцах боломжийг бүрдүүлсэн олон нийтэд чиглэсэн үйл ажиллагаа зохион байгуулав.

Худалдааны хүрээ

Нийслэлийн Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээг дэмжих төв НӨҮГ нь Монголын уламжлалт гар урлал, мал аж ахуйн тоног хэрэгслийн гар урлал, Монголын үндэсний хувцасны гар урлал, уламжлалт арьс ширэн гар урлал, Монгол дарханы гар урлал (эмээл, авдар, сийлбэр) болон Хүрээ панз уламжлалт дуудлага худалдаа,”-г зохион байгуулав.

Мөн, Монголын Үндэсний худалдаа аж үйлдвэрийн танхимтай хамтран Эмэгтэйчүүд Энтрепренер хөгжил хоршооны эсгий урлал, гоёл чимэглэл, Ноосон зураг ХХК-ны сувинер зураг, Энхжин сувенир ХХК-ны ноосон эдлэл, Ноосон зангилаа дундын хоршооны ноосон эдлэл, Сайнтүмэн кашимер ХХК-ны ноолуур, Мэргэн тур ХХК-ны савхин цүнх, Хөх урлан ХХК-ны арьсан цүнх бэлэг дурсгалыг дэлгэж үзэсгэлэн зохион байгуулав.



Уламжлалт хоол, идээ ундааны хүрээ

Уламжлалт хоол, идээ ундааны хүрээнд Мастер тогоочдын холбоотой хамтран зохион байгуулж Улаанбаатар хотын 3 дүүрэг, 18 аймгийн 128 тогооч, ажлын хэсгийн 21 хүн оролцож нийт 16 угсаатны хоол идээ ундааг сурталчлан амталгаат үзэсгэлэн худалдаа зохион байгуулав.



Үндэсний спортын хүрээ

“Нүүдэлчин 2022” Дэлхийн Соёлын фестивалийн үеэр Үндэсний спортын төрлүүдийг сурталчлан таниулах үзүүлэх тоглолтыг Горхи- Тэрэлжийн цогцолборт газрын Сайханы Саравч хэмээх газарт 2022 оны 08 дугаар сарын 12-13-ний өдрүүдэд амжилттай зохион байгууллаа. Үндэсний спортын төрлүүдийн үзүүлэх тоглолтыг Нүүдэлчин Дэлхийн соёлын фестивалийн талбайн дэргэд Үндэсний спортын хүрээ болон Оторчин бага тайз, Нүүдэлчин их тайзны өмнөх талбайд 3

өдрийн турш нийт үзэгчид, оролцогчдод зориулан зохион байгууллаа. Үзүүлэх тоглолтод Монголын Үндэсний Тулааны урлагийн холбоо, Монголын Сээр цохих наадгайн холбоо, Монголын Адуучдын холбоо, Монголын Көкбар, Аударсбак, Тенгеилү холбоо, “Чандага” Морин спортын сургалтын төвийн нийт 168 тамирчин, үндэсний спортын өв тээгчид Монгол-Зо үндэсний бие хамгаалах тулааны урлаг, Сээр цохих наадгай, Адуучдын ур чадвар, Морьт харваа, Морьтны ур чадварын үзүүлбэр, Морьт барилдаан, тулам булаалдах зэрэг уламжлалт спортын төрлүүдийг “Нүүдэлчин 2022” Дэлхийн соёлын фестивалийг үзэж сонирхохоор ирсэн нийт 20,000 үзэгчид, жуулчдад нийт 710 минутын хөтөлбөр үзүүлж сонирхуулав. Нийт 15 үндэсний спортын төрөл, 25 цагийн хөтөлбөрт арга хэмжээг зохион байгуулав.



Нүүдэлчин” их тайз, бага тайз

“Нүүдэлчин” дэлхийн соёлын фестивалийн нээлт хаалтын үйл ажиллагааны ерөнхий найруулагчаар МУГЖ Н.Онон, туслах найруулагчаар Д.Мөнх-Од, Б.Чинзориг, О.Сүххуяг мөн гэрлийн техникчээр Г.Ган-Очир, дууны техникчээр Г.Билгүүн нар ажиллав.

Фестивалийн үйл ажиллагааг 2022 оны 08 дугаар сарын 12-ны өдрийн 14:00 цагт зохион байгуулсан бөгөөд наадмыг Монгол Улсын Ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнэ нээж, нээлтийн ёслолын жагсаалд 21 аймаг, нийслэлийн 1283 өвлөн уламжлагч, соёлын салбарын албан хаагч нар оролцож, ҮУИТ-ын 200 гаруй уран бүтээлчид болон Хөсөгтөн хамтлаг уран бүтээлээ хүргэв.

Фестивалийн 2 дахь өдөр буюу 2022 оны 08 дугаар сарын 13-ны өдрийн 11:00 цагт “Монгол түмний их цэнгэл наадаан” хүндэтгэлийн тоглолт (*хавсралт ...*)-ыг зохион байгуулав. Тоглолтод ҮУИТ, УДБЭТ, Улсын филармони, Морин хуурын чуулга зэрэг мэргэжлийн урлагийн байгууллагын 350 гаруй уран бүтээлчид, чөлөөт уран бүтээлчид оролцов.

21 аймаг, нийслэлийн 94 соёлын биет бус өвийн өвлөн уламжлагчдын нэгдсэн гала тоглолтыг 2022 оны 08 дугаар сарын 14-ний өдөр зохион байгуулав. Соёлын биет бус өвийн шилдгүүдийг шалгаруулах үйл ажиллагаанд ҮУИТ-ын Үндэсний их найрал хөгжмийн 36 уран бүтээлчид, Чингис хаан ордонт МУГЖ Г.Ариунбаатар нар уран бүтээлээр мэндчилгээ хүргэв.

Отор бага тайзан дээр соёлын бүтээлч үйлдвэр эрхлэгчдийн бүтээгдэхүүний дуудлага худалдаа, Сээр цохих үзүүлбэр, Морьтон циркийн тоглолт, Монгол Зо тулааны урлагийн үзүүлбэрүүдийг толилуулсан. Отор бага тайзны хөтлөгчөөр УДЭТ-ын жүжигчин Ганзориг ажилласан.

“Нүүдэлчин Монгол-2022” Соёлын биет бус өвийн их наадмын үйл ажиллагааны оролцогч 21 аймаг болон нийслэлийн биет бус өвийг өвлөн уламжлагчдад зориулсан “Нүүдэлчин” лого бүхий эко тор, халуун баригч аяга, пудволк, шоколад, хамгийн өндөр настай биет бус өвийг өвлөн уламжлагч хамгийн өндөр настанд зориулсан 5,5 хэмжээ бүхий мөнгөн аяга, 10 өртөөгөөр аялсан хүүхдэд зориулсан урамшууллын чихэр, сувинерийн араг зэрэг бүтээгдэхүүнийг аж ахуйн нэгж, иргэдээс худалдан авсан.

“Нүүдэлчин” лого бүхий мөнгөн аяга, хадаг, ааруул болон лого бүхий эко тор, лого бүхий шоколад, халуун баригч аягаас бүрдсэн “Хүндэтгэлийн багц”-ыг 21 аймаг 9 дүүрэг тус бүрийн 1-3 хамгийн өндөр настай биет бус өвийг өвлөн уламжлагч 32 хүнд Ерөнхий сайд, Шадар сайд, Соёлын сайд нар наадмын 22 отгоор гардуулсан бөгөөд бусад өвлөн уламжлагч 1282 оролцогчид, Соёлын яамны хүндэтгэлийн өргөөнд уригдсан аймаг нийслэлийн 50 төлөөлөл, зочдод лого бүхий эко уут, шоколад, халуун баригч аяга болон пудволк бүхий энгийн багцыг бэлтгэн өгсөн. 21 аймгийн өв соёл, уламжлал, зан үйлийн үзүүлбэр, язгуур урлаг, гар урлалын үзэсгэлэн, соёлын биет бус өвүүд, идээ ундаа, нүүдэлчдийн олон талт үйл ажиллагаанд оролцон 10 өртөөгөөр аялагч хүүхдүүдэд зориулан үндэсний үйлдвэрийн бүтээгдэхүүнээр урамшуулав.



Тусгай хэрэгцээт иргэдийн соёлын үйлчилгээ

Тус фестивалд хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, иргэдийг хамруулах, тэгш хүртээмжийг нэмэгдүүлэх үйл ажиллагааг Соёлын Яамны Залуучуудын хөгжлийн зөвлөл, Соёл, урлагийн менежер залуучуудын хөгжлийн зөвлөл хамтран зохион байгуулж 3 өдрийн турш нийт 200 гаруй иргэдийг зохион байгуулалттайгаар автобус унаа, хөтөч тайлбарлагч, дохионы хэлмэрчтэйгээр хамруулав. Хөтөлбөрт сонсголын болон хэл ярианы бэрхшээлтэй хүүхдийн нийслэлийн 29 дүгээр тусгай дунд сургууль, оюун ухаан, аутизм, дауны бэрхшээлтэй хүүхдүүдийн онцлог хэрэгцээнд нийцүүлсэн ерөнхий эрдэм болон хөдөлмөр заслын сургалттай нийслэлийн ерөнхий боловсролын 55 дугаар дунд сургуулийн сурагчид, Дархан-Найрамдал ТББ, Түгээмэл хөгжил ТББ, Монголын хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр сургалтын үндэсний төв, Гэрэлт-Ундарга хэвлэл ТББ, Монголын дүлий иргэдийн соёл, урлагийн холбоо, Монголын тэргэнцэртэй иргэдийн үндэсний холбоо, Монголын дауны холбоо, Монголын хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн эцэг эхийн холбоо, Сэргээн засалтын үндэсний төв, Монголын хараагүйчүүдийн үндэсний холбоод, чөлөөт уран бүтээлчид, өсвөр үеийн залуус, хүүхдүүд хамрагдав.

Мөн фестивалийн үеэр үзэсгэлэн худалдаанд тусгай хэрэгцээт иргэдийг оролцуулж, тэдгээр иргэд өөрсдийн хийсэн соёлын бүтээлч үйлдвэрлэлийн гар урлалын бүтээлүүдээ иргэдэд дэлгэн сонирхуулж худалдан борлуулав.

Соёлын өвийн хүрээ

“Соёлын өвийн хүрээ”-г Соёлын яамны харьяа 13 байгууллагын 160 албан хаагч, соёлын биет бус өвийг өвлөн уламжлагчид, эрдэмтэн судлаачидтай хамтран, отог хэлбэрээр зохион байгууллаа. Үүнд:

1. “Эх хэл, аман уламжлал, илэрхийллүүд өргөө”- Чингис хааны өв соёлын хүрээлэн;

2. “Ардын язгуур урлагийн өргөө”-г Монголын театрын музей;
3. “Уламжлалт баяр наадам, зан үйл, ёс, тоглоом наадгай, уриа дуудлага”-ын өргөөг Монголын үндэсний музей;
4. “Байгалийн болон сав шим ертөнцийн тухай мэдлэг, зан үйл”-ийн өргөөг Байгалийн түүхийн музей;
5. “Уламжлалт арга ухаан”-ын өргөөг Чойжин ламын сүм музей;
6. “Мал маллах арга ухаан”-ын өргөөг Богд хааны ордон музей;
7. “Уламжлалт гар урлал”-ын өргөөг Дүрслэх урлагийн музей;
8. “Нүүдлийн соёл иргэншлийн үнэт зүйлс - хүн төрөлхтний соёлын биет бус өвийн өргөө”-г Соёлын өвийн үндэсний төв болон Нүүдлийн соёл, иргэншлийг судлах олон улсын хүрээлэн;
9. “Эрчист Монгол өргөө”-г Монголын уран зургийн галерей болон Бурхан Халдун уул түүнийг хүрээлсэн тахилгат газар нутгийн хамгаалалтын захиргаа;
10. “Хүүхдийн өргөө”-г Хүүхдийн төв номын ордон болон Хүүхэлдэй театр хариуцан, зохион байгуулав.

“Соёлын өвийн хүрээ” арга хэмжээний өргөө гэрүүдэд давхардсан тоогоор нийт 210 үйл ажиллагааг хөтөлбөрийн дагуу зохион байгуулан ажиллав.

1.1 “Эх хэл, аман уламжлал, илэрхийллүүд өргөө”- Чингис хааны өв, соёлын хүрээлэн

Чингис хааны өв, соёлын хүрээлэн соёлын биет бус өвийн “Эх хэл, аман уламжлал, илэрхийллүүд” ай савыг сурталчлах ажлыг ШУА-ийн Хэл зохиолын хүрээлэнгийн Аман зохиолын салбартай хамтран зохион байгуулсан. Тус ай савд нийт 49 соёлын биет бус өвийн төрөл зүйл багтдаг бөгөөд 3 өдрийн үйл ажиллагаанд эдгээрээс 21 өвийн төрөл зүйлийг сурталчилж, олон нийтэд түгээн дэлгэрүүлэх ажлыг зохион байгуулав. “Эх хэл, аман уламжлал, илэрхийллүүд” өргөөгөөр 3 өдрийн хугацаанд ойролцоогоор 700 гаруй хүн зочилж эх хэл, аман уламжлалын илэрхийллүүдтэй танилцсан болно.

№	Онцолсон эх хэл, аман уламжлалын илэрхийллүүд	Сурталчилсан байдал
1.	Буриад аман аялгуу	<ul style="list-style-type: none"> • Дорнод аймгаас ирсэн өвлөн уламжлагч Б.Оюунчимэг Буриад аман аялгууг, залуу өвлөн уламжлагч Ө.Баярхүү, Г.Буяндэлгэр нар “Буриадын эртний таавар мэтгэлцээн”-ийг тус тус танилцуулав.
2.	Халх аман аялгуу	<ul style="list-style-type: none"> • Уртын дууч, ерөөлч, магтаалч, СТА Э.Хүрэлбаатар Халх аман аялгууг танилцуулав.
3.	Захчин аман аялгуу	<ul style="list-style-type: none"> • Улсын засуул, ерөөлч, магтаалч Ж.Энхтөр Захчин аман аялгууг танилцуулсан.

- | | |
|-----------------------------|---|
| 4. Урианхай аман аялгуу | <ul style="list-style-type: none"> • Баян-Өлгий аймгаас ирсэн өвлөн уламжлагч Н.Сумъяа Урианхай аман аялгууг танилцуулсан. • Орхон аймгаас ирсэн өвлөн уламжлагч Г.Мөнгөнчимэг Урианхай аман аялгуу болон үйшүүр, хорол тоглоомыг танилцуулсан. |
| 5. Алтайн казах аман аялгуу | <ul style="list-style-type: none"> • Баян-Өлгий аймгаас ирсэн өвлөн уламжлагч Х.Саттигүл Казах аман аялгууг танилцуулсан. • Ховд аймгаас ирсэн өвлөн уламжлагч А.Зулмира Казах аман аялгууг танилцуулав. |
| 6. Монгол уран бичлэг | <ul style="list-style-type: none"> • Уран бичээч Э.Анхбаяр, Уран бичээч, хэл шинжлэлийн доктор М.Авирмэд нар уран бичлэгийг танилцуулж, уран бичлэгээр бичиж үйлчилсэн. |
| 7. Домог | <ul style="list-style-type: none"> • Магтаалч, СТА Р.Даансүрэн Чингис хаантай холбоотой магтаал уншиж, үлгэр домог ярьж танилцуулав. |
| 8. Зүйр цэцэн үг | <ul style="list-style-type: none"> • Олон Улсын Улаанбаатар их сургуулийн багш, доктор Г.Гэрэлмаа “Таван эрдэнэтэй зүйр цэцэн үг”, “ертөнцийн гурав”, “оньсого”-ыг тайлбарлаж, хүүхэд багачуудын дунд “Зүйр үг хэн сайн мэдэх вэ” уралдаан зохион байгуулав. |
| 9. Ертөнцийн гурав | |
| 10. Оньсого | |
| 11. Түргэн хэллэг | <ul style="list-style-type: none"> • Уртын дууч, СТА О.Оюун-Эрдэнэ Түргэн хэллэг, жороо үг тайлбарлаж танилцуулав. |
| 12. Жороо үг | <ul style="list-style-type: none"> • Орхон аймгаас ирсэн өвлөн уламжлагч А.Пунсалдулам Түргэн хэллэгийг тайлбарлаж, түргэн хэллэг уншиж танилцуулав. |
| 13. Цацлын үг | <ul style="list-style-type: none"> • ШУА-ийн Хэл зохиолын хүрээлэнгийн АЗСС-ын ЭША, доктор Ч.Заяасүрэн Цацал, мялаалгын үгсийг тайлбарласан. |
| 14. Мялаалга үг | |
| 15. Цол дуудлага | <ul style="list-style-type: none"> • Улсын морь, бөх цоллооч, уртын дууч, СТА Э.Хүрэлбаатар “Морины цол”, “Бөхийн цол” дуудаж танилцуулав. • Дархан-Уул аймгаас ирсэн улсын морь, бөх цоллооч Г.Дарханням “Бөхийн цол” дуудсан. |
| 16. Ерөөл | <ul style="list-style-type: none"> • Улсын засуул, ерөөлч, магтаалч Ж.Энхтөр “Хуримын ерөөл” өргөсөн. |
| 17. Магтаал | <ul style="list-style-type: none"> • Дундговь аймгаас ирсэн “Чандмань эртэнэ” хамтлагийн залуу өвлөн уламжлагчид болох С.Нарангоо, У.Мэндбаяр, Б.Сэрчмаа |

нар “Их газрын чулууны магтаал”-ыг танилцуулав.

- Дундговь аймгаас ирсэн залуу өвлөн уламжлагч Н.Өрнөл “Гучин гурван говийн магтаал” хэлсэн.
 - Дархан-Уул аймгаас ирсэн улсын морь, бөх цоллооч Г.Дарханням “Жонон хонгорын магтаал” уншсан.
 - Хөсөгтөн хамтлагийн гишүүн, хөөмийч, морин хуурч В.Батзориг “Чингисийн магтаал” уншсан.
 - Ерөөлч, магтаалч, СТА Л.Лхамрагчаа “Чингисийн магтаал” уншсан.
 - Туульч, МУСГЗ А.Балдандорж “Алтайн магтаал” уншсан.
 - Дархан-Уул аймгаас ирсэн улсын морь, бөх цоллооч Г.Дарханням “Жонон хонгорын магтаал” уншсан.
 - Туульч, МУСГЗ А.Балдандорж тахилга тайлгын үгсийг тайлбарласан.
 - Улсын морь, бөх цоллооч, уртын дууч, СТА Э.Хүрэлбаатар “Малын өнгө зүс, нэр, малын ураа дуудлага”, “Мал амьтныг хүйсээр ялга нэршил үг”-ийг тайлбарласан.
18. Тахилга, тайлгын үгс
19. Мал, амьтныг зүслэх нэршил үг
20. Мал, амьтныг насаар нь ялгах нэршил үг
21. Мал, амьтныг хүйсээр нь ялгах нэршил үг

Мөн тус хүрээлэнгийн үйл ажиллагааны чиг үүрэг, судалгааны чиглэлтэй уялдуулан Чингисийн магтаал, “Чингисийн эр хоёр загал” тууж, Чингис хаантай холбоотой магтаал, үлгэр домгийг өвлөн уламжлагчид, эрдэмтэн судлаачдаар яриулж, олон нийтэд сурталчлав.



Ерөөлч, магтаалч, СТА Л.Лхамрагчаа “Чингисийн магтаал” уншиж байна.



Улсын засуул, ерөөлч, магтаалч Ж.Энхтөр “Хуримын ерөөл” өргөж байна.

1.2 “Ардын язгуур урлагийн өргөө” - Монголын театрын музей

Монголын Театрын музей нь “Ардын язгуур урлаг” ай савын 68 өвийн төрөл зүйлээс 25 өвийн төрөл зүйлийг 28 өвлөн уламжлагчийн тоглолтоор дамжуулан дотоод, гадаадын үзэгч 1400 гаруй үзэгч, 70 гаруй хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд сурталчлан таниулав.



Увс аймгийн өвлөн уламжлагч Д.Балган, Алтай хамтлагийн хөгжимчин Б.Ганзориг икел хөгжмөөр тоглож үзэгчдэд тайлбар хийв.

1.3 “Уламжлалт баяр наадам, зан үйл, ёс, тоглоом наадгай, уриа дуудлага”-ын өргөө - Монголын үндэсний музей

“Уламжлалт баяр наадам, зан үйл, ёс, тоглоом наадгай, уриа дуудлага”-ын өргөө нь нийт 74 өвийн төрөл зүйлээс 13 өвийн төрөл зүйлийг соёлын биет бус

өвлөн уламжлагчидтай 3 өдрийн турш хамтран сурталчлан таниулж, 8000 гаруй үзэгч, наадамчин олонд толилуулав.



Захчин хуримын зан үйл

1.4 “Байгалийн болон сав шим ертөнцийн тухай мэдлэг, зан үйл”-ийн өргөө - Байгалийн түүхийн музей

Байгалийн Түүхийн музей нь Монгол Улсын соёлын биет бус өвийн төлөөллийн үндэсний бүртгэлд хамаарах Байгаль болон сав шим ертөнцийн тухай мэдлэг, зан үйл айн 10 соёлын биет бус өв, Уламжлалт арга ухаан айн 3 өв, Монгол Улсын яаралтай хамгаалах шаардлагатай соёлын биет бус өвийн үндэсний бүртгэлд хамаарах өвүүдээс Байгаль болон сав шим ертөнцийн тухай мэдлэг, зан үйл айн 5, нийт 18 соёлын биет бус өвийг өвлөн уламжлагч нарын хамт танилцуулж ажиллав.



Говь-Сүмбэр аймгийн өвлөн уламжлагч Г.Ганхуяг Байгаль хамгаалах уламжлалт арга мэдлэг, зан үйлийн талаар ярилцаж байгаа нь

Өргөөнд зочилсон хүүхэд багачуудын дунд Байгаль хамгаалах уламжлалт арга ухаан, Ан, амьтны насны нэршил, Монголын уламжлалт тоо тоолол, хэмжил зүй, Газар нутгийн нэршил зэргээр танин мэдэхүйн тэмцээн уралдаан зохион байгуулж ялагчдад Аргуун групп-ээс хэвлэн гаргадаг Буддаг ном (амьтны дүрс, өнгө, бусад дүрс), хоёр төрлийн эвлүүлдэг тоглоом зэргээр шагнаж урамшуулав.

Дээрх үйл ажиллагааны хүрээнд тус наадмын нэг дэх өдөр 495, хоёр дах өдөр 845, гурав дах өдөр 915 буюу нийт 2255 хүнд хүрч ажиллав.

1.5 “Уламжлалт арга ухаан”-ын өргөөг Чойжин ламын сүм музей

Чойжин ламын сүм музей нь “Уламжлалт арга ухаан” ай савд хамаарах Монгол Улсын соёлын биет бус өвийн Төлөөллийн үндэсний бүртгэлд багтсан 39, Монгол Улсын Яаралтай хамгаалах шаардлагатай соёлын биет бус өвийн бүртгэлд багтсан 6, нийт 45 соёлын биет бус өвийн төрөл зүйлээс дараах 13 өвийн төрөл зүйлийг онцлон наадмын үеэр олон нийтэд үзүүлэн сурталчилсан. Үүнд:

1. Сульхарын гурил боловсруулах арга
2. Цагаан идээ бэлтгэх уламжлалт арга
3. “Ажийн бор” ааруул хийх арга
4. Улаан идээ боловсруулах арга
5. Битүү хоол хийх арга
6. Монгол үндэсний уламжлалт, цай ундаа хийх арга
7. Шимийн архи нэрэх уламжлалт арга технологи
8. Хүндэтгэлийн зоог шүүс бэлтгэх арга
9. Бариа заслын аргаар анагаах арга ухаан
10. Зүү тавих арга ухаан
11. Хануур хийх арга ухаан
12. Төөнүүр хийх арга ухаан
13. Угийн бичиг хөтлөх монгол уламжлалт мэдлэг

Д/д	Соёлын биет бус өвийн нэр	Хэрхэн танилцуулсан тухай
1.	Угийн бичиг хөтлөх монгол уламжлалт мэдлэг	Архивын баримтад тулгуурлаж угийн бичиг хөтлөх монгол уламжлалт мэдлэг ухааныг олон нийтэд таниулах зорилгоор “Гэрийн үеийн бичиг” гэрэл зургийн үзэсгэлэнг дэлгэн толилуулсан. Тус үзэсгэлэнд Үндэсний төв архивд хадгалагдаж буй 3 төрлийн “Гэрийн үеийн бичиг”-ийн гэрэл зургийг тайлбарын хамт дэлгэсэн болно.
2.	Монгол үндэсний уламжлалт, цай ундаа хийх арга	Булган аймгийн Хангал сумын I багийн харьяат өвлөн уламжлагч Б.Мөнхням монголын уламжлалт цай бэлтгэхэд ашигладаг түүхий эд, орцыг бодитоор харуулж, үнэрлүүлж, тухайн төрөл зүйлийн зүйлийн талаар танилцуулж, уламжлалт аргаар цай ундаа

- бэлтгэх аргыг биетээр үзүүлж, бэлтгэсэн цайгаар зочдыг дайлж таниулан сурталчилсан.
3. СУИС-ийн СУСХ-ийн эрдэм шинжилгээний ажилтан С.Энхнаран, өвлөн уламжлагч Б.Мөнхням нар хамтран 20 хүртэлх оролцогсдыг нэг удаад хамруулж, уламжлалт цай ундаа бэлтгэх, боловсруулах арга ухааныг биетээр үзүүлж, оролцогч тус бүр өөрийн биеэр оролцох боломжийг бүрдүүлэн ажилласан.
4. Хөх буюу ургамлын гаралтай идээ боловсруулах арга
Монгол Улсын Яаралтай хамгаалах шаардлагатай соёлын биет бус өвд бүртгэлтэй “Сульхарын гурил боловсруулах арга”-ыг Говь-Алтай аймгийн харьяат Ардын өвлөн уламжлагч Ш.Түнжин үзүүлж, оролцогчдын биет оролцоог ханган ажилласан. Сульхар гэж ямар ургамал болох, хаана ургадаг, тухайн ургамлыг хэрхэн боловсруулж гурил болгодог, түүнийг юунд ашигладаг, ямар ач тустай зэрэг мэдээллийг нийт оролцогч нарт хүргэж ажилласан.
5. “Ажийн бор” ааруул хийх арга
Монгол Улсын Яаралтай хамгаалах шаардлагатай соёлын биет бус өвд бүртгэлтэй “Ажийн бор” ааруул хийх аргыг Говь-Алтай аймгийн харьяат Ардын өвлөн уламжлагч Ш.Түнжин танилцуулж, тухайн биет бус өвийн онцлогийн талаар тайлбарлаж, зочдыг дайлж ажилласан.
6. Бариа заслын аргаар анагаах арга ухаан
Уламжлалт анагаах ухааны ардын өвлөн уламжлагчид гурван өдрийн турш олон нийтэд нээлттэй үйлчилж, тухайн арга ухааныг биетээр үзүүлж ажилласан. Үүнд:
7. Зүү тавих арга ухаан
- Архангай аймгийн харьяат өвлөн уламжлагч Т.Дагмид “Тан бэлтгэх, хануур хийх, судас барих”
8. Хануур хийх арга ухаан
- Дархан-Уул аймгийн харьяат өвлөн уламжлагч “Эмийн ургамал бэлтгэх арга”
- Дорноговь аймгийн харьяат өвлөн уламжлагч Д.Алтангэрэл “Эмийн ургамал бэлтгэх арга”
- Хөвсгөл аймгийн харьяат өвлөн уламжлагч “Эмийн ургамал бэлтгэх арга”
9. Төөнүүр хийх арга ухаан
- Хэнтий аймгийн харьяат өвлөн уламжлагч Н.Ууганцэцэг “Бариа засал, судас барих”
- Ховд аймгийн харьяат өвлөн уламжлагч Г.Шомбо “Бариа засал”
- Өвөрхангай аймгийн харьяат өвлөн уламжлагч “Бариа засал, галын тарни”

- Увс аймгийн харьяат өвлөн уламжлагч, цахиач Ш.Бадамсамбуу “Дом шившлэгээр анагаах ухаан”

Мөн уламжлалт анагаах ухааны чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг мэргэжлийн байгууллагуудтай хамтран ажиллаж, уламжлалт анагаах ухааныг олон нийтэд таниулан сурталчилсан. Үүнд:

- *Манба Дацан* МУЭСТ-ийн Тэргүүн, Оточ Манрамба Их Сургуулийн захирал, Монгол Улсын Хүний гавьяат эмч, *Хамба* лам Д.Нацагдорж “Уламжлалт анагаах ухаан”
- Уламжлалт анагаах ухааны *Оточ Манрамба Их Сургуулийн Уламжлалт анагаах ухааны тэнхимийн багш*, *Уламжлалт анагаах ухааны их эмч Ч.Одончимэг* “Судас барих, зөвлөгөө өгөх”
- Уламжлалт анагаах ухааны Оточ Манрамба Их Сургуулийн багш, эмч нар “Судас барих, зөвлөгөө өгөх, бариа засал хийх”
- Анагаахын Шинжлэх Ухааны Үндэсний Их Сургуулийн багш уламжлалт анагаах ухааны багш, эмч нар “Судас барих, зөвлөгөө өгөх, бариа хийх”

Уламжлалт Анагаах Ухааны Технологийн Хүрээлэнгийн Эмнэлгийн их эмч Ц.Бямба-Очир “Бумба тавих, судас барих, тан бэлдэх түүхий эд танилцуулах, зөвлөгөө өгөх”

- | | | |
|-----|---|---|
| 10. | Цагаан идээ бэлтгэх уламжлалт арга
“Бяслаг хийх арга” | Цагаан идээ бэлтгэх уламжлалт арга ухааны нэг болох “Бяслаг хийх арга”-ыг Монгол улсын соёлын гавьяат зүтгэлтэн, профессор Г.Гонгоржав хөтлөн явуулж, өвлөн уламжлагч Ч.Хорлоосүрэн биетээр үзүүлж, зочдод хүртээж ажилласан болно. |
| 11. | Цагаан идээ бэлтгэх уламжлалт арга
“Тос хайлах уламжлалт арга” | Цагаан идээ бэлтгэх уламжлалт арга ухааны нэг болох “Тос хайлах арга”-ыг Монгол улсын соёлын гавьяат зүтгэлтэн, профессор Г.Гонгоржав хөтлөн явуулж, өвлөн уламжлагч Ч.Хорлоосүрэн биетээр үзүүлж, зочдод хүртээж ажилласан болно. |
| 12. | Шимийн архи нэрэх уламжлалт арга технологи | “Шимийн архи нэрэх уламжлалт арга технологи”-ийг Монгол улсын соёлын гавьяат зүтгэлтэн, профессор Г.Гонгоржав хөтлөн явуулж, өвлөн уламжлагч |

Ч.Хорлоосүрэн биетээр үзүүлж, зочдод хүртээж ажилласан болно.

13. Хүндэтгэлийн зоог шүүс бэлтгэх арга

14. Битүү хоол хийх арга

15. Малын гэдэс дотроор хоол хүнс бэлтгэх арга

16. Гүүний айраг эсгэх уламжлалт арга технологи

“Хүндэтгэлийн зоог шүүс бэлтгэх арга”-ыг Монгол улсын соёлын гавьяат зүтгэлтэн, профессор Г.Гонгоржавыг зааврын дагуу мэргэжлийн байгууллага бэлтгэж, гурван өдрийн турш хүндэтгэлийн зоог шүүсийг хэрхэн бэлтгэх, байрлуулах, хөндөх, эвдэж хишиг хүртээх зэргийг олон нийтэд таниулан сурталчилсан. Мөн “Малын гэдэс дотроор хоол хүнс бэлтгэх арга”, “Битүү хоол хийх арга”-ыг Монгол улсын соёлын гавьяат зүтгэлтэн, профессор Г.Гонгоржавыг зааврын дагуу мэргэжлийн байгууллага бэлтгэж хөтөлбөрийн дагуу олон нийтэд таниулан сурталчилж, хүртээж ажилласан болно.

Монгол улсын соёлын гавьяат зүтгэлтэн, профессор Г.Гонгоржав “Гүүний айраг эсгэх уламжлалт арга технологи”-ийг товчхон танилцуулж, гурван өдрийн турш олон нийтэд хүртээж, таниулан сурталчилж ажилласан.



Шимийн архи нэрэх уламжлалт арга технологийг үзүүлж буй нь



Уламжлалт анагаах ухааны өвлөн уламжлагч, бариач Г.Шомбо бариа хийж буй нь

2022 оны 8 дугаар сарын 12-ны өдрөөс 8 дугаар сарын 14-ний өдрүүдэд “Уламжлалт арга ухааны өргөө”-нд нийт 1000 гаруй үзэгч, үйлчлүүлэгч зочлов.

1.6 “Мал маллах арга ухаан”-ын өргөө - Богд хааны ордон музей

Богд хааны ордон музей нь наадмын үеэр 4 ай савын 7 өвийн төрөл зүйлийг онцлон сурталчлав. Үүнд:

- Ингэ хөөслөх
- Хонь тойглох
- Тэмээн тэрэг хөллөх
- Үхэр тэрэг хөллөх
- Цагаан идээ бэлтгэх уламжлалт арга
- Цаа хөллөх
- Эсгий хийх уламжлалт арга

Айлчлан ирсэн зочин үзэгч олонд малчин айлын зун цагт өдөр тутам хэрэглэдэг сүү цагаан идээ болох айраг, өрөм, цөцгий, ааруул, эззгий, гэрт хайрсан боорцог зэргийг бэлтгэн идээ зоогоор дайлж, хүүхэд багачуудад бяцхан гарын бэлэг бэлтгэн бэлэглэв. 2022 оны 8 дугаар сарын 12-14-ний өдрүүдийн хооронд “Мал маллах арга ухааны өргөө”-д давхардсан тоогоор 800 гаруй зочид айлчилж, 200 гаруй хүүхдэд гарын бэлэг өгч, гэрийн танилцуулга, гэр дэх эд хогшил бүрийг хэрхэн хийдэг, юунд ашигладаг, эрүүл мэндэд хэрхэн ач тустай болох, мөн түүхийг тайлбарлан хэлж танилцуулав.



Сайн малчны гэр

“Мал мал арга ухааны өргөө” нь 1970-1980 оны хооронд Сайн малчин хүнд улсаас шагнал болгон бэлэглэж байсан бүтэн сийлбэртэй иж бүрэн 6 ханатай гэр юм. Гэрийг тохижуулахдаа одоогоос 100 гаруй жилийн өмнө жирийн малчин айл хэрхэн аж төрж байсныг харуулахыг зорьсон бөгөөд тухайн үед эдэлж хэрэглэж байсан эд зүйлсийг цуглуулан тохижуулсан болно. Гэрт буй эд зүйлс нь малын гаралтай түүхий эд болон байгалийн гаралтай эдээр монголчууд ахуйн хэрэглээний эд зүйлс, хогшил тавилгыг хэрхэн уламжлалт аргаар бүтээн, хэрэглэж байсныг үзэгч зочдод танилцуулах зорилготой байв. Орчин цагт ч эдгээр бат бөх бөгөөд эрүүл мэндэд чухал нөлөөтэй ахуйн хэрэглээний эд хогшил, хоол сав, болон адуу, мал ахуйн тоног хэрэгслийг ахуйдаа ахин өөрсдөө бүтээн хэрэглэх нь чухал ач холбогдолтой талаар сурталчлан харилцан санал солилцож, хүүхэд багачуудад нэг бүрчлэн тайлбарлан өгөв.



Эсгий хийх үйл явц

1.7 “Уламжлалт гар урлал”ын өргөө - Дүрслэх урлагийн музей

Соёлын биет бус өвийн Уламжлалт гар урлалын 7 дахь ай савын 77, Монгол Улсын яаралтай хамгаалах шаардлагатай 5 өвөөс Зүмбэр урлал, Эсгий ширмэл урлал, Эсгий хувцас урлал, Зээгт наамлын урлаг, Монголын уламжлалт арьс ширэн эдлэлийн урлал, Уламжлалт уран хатгамал, оёдлын урлал, Зоос ширээний сүлжмэл, Монголын уламжлалт модон эдлэлийн урлал, Модон сийлбэрийн урлал, Морин хуур хөгжмийн урлал, Монголын уламжлалт уях зангидах урлал, Монгол дархны уламжлалт арга ухаан, Ган сийлбэрийн урлал, Мөнгөн аяга хийх урлал зэрэг гэх мэт 14 өвийг 3 өдрийн турш Уламжлалт гар урлалын өргөөндөө сурталчлан таниулах ажлыг зохион байгуулав.

Нийт 82 өвөөс Үндэстэн ястны хувцас урлалын уламжлал, төрөл бүрийн тэрэг хийх уламжлал, нум сум хийх уламжлалт урлалуудыг хөдөө орон нутгаас оролцож буй өвлөн уламжлагчдын отогуудаас танилцах боломжтой учраас давхардуулахгүй байх үүднээс оруулсангүй. Мөн нум сум урлал, гэрийн уламжлалт урлалууд нь орчин нөхцөл, орон зай шаардагдах учраас үзүүлэх боломжгүй байлаа. Мөн тус өргөөнд Үндэсний шилдэг, билиг авьяаст өвлөн уламжлагч, үндэсний хөгжим урлаач МУСГЗ П.Байгалжав, нэрт уран хатгамалч, өвлөн уламжлагч С.Цэрэнлхам, уран хатгамалч С.Буд, Бурмаа, Соёлын яамны дэргэдэх Залуучуудын хөгжлийн зөвлөл, Уран сийлбэрийн “Шинэ өглөө” нийгэмлэгийн уран бүтээлч, өвлөн уламжлагч Ө.Очирсүрэн, С.Цэнгэл, Уран сийлбэрийн “Дөрвөлжин дугуй” нийгэмлэгийн уран бүтээлч, өвлөн уламжлагч Ц.Батмөнх, Дашчойлин хийдийн бурханч лам М.Эрдэмбилэг, Дүрслэх урлагийн академи дээд сургуулийн уран дарханы багш Н.Дуйнхар, уран дархан Цэнгүн, ШУТИСургуулийн Үйлдвэрлэлийн технологийн сургуулийн дизайны салбарын эрхлэгч, Доктор, дэд профессор Ц.Батсайхан, Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн мэргэжлийн боловсрол ур чадвар олгох сургуулийн багш А.Наранзул, Загдцэнд, Арьсан урлагийн “Хүрэл буга нийгэмлэг”-ийн уран бүтээлч Б.Бямбабаяр, Г.Бурмаа, Б.Нармандах, Түмэн эрдэнэс холбооны уран бүтээлч, уран дархан, өвлөн уламжлагч МУУГЗ Т.Төмөрсүх, уран дархан Б.Баярбаатар, уран дархан, ган сийлбэрч Б.Баярсайхан, өвлөн уламжлагч Б.Цэрэнчанаа зэрэг төрийн болон төрийн бус байгууллагууд, өвлөн уламжлагч хувь хүмүүс оролцож ҮЗЭНГЭЭ СУРАЛЦЬЯ уриан дор ардын уламжлалт гар урлалаа өвлөн уламжлуулж, түгээн дэлгэрүүлж, сурталчлан таниулав.

Соёлын биет бус өвийн “Уламжлалт гар урлал”-ын ай савын хүрээнд 3 өдрийн туршид өглөө 9:00-19:00 цагийн хооронд тасралтгүй үзүүлэн, сурталчлан таниулсан бөгөөд нийт 2000 орчим хүмүүс “Уламжлалт гар урлалын өргөө” гэрт морилон саатаж өөрсдийн сонирхсон гар урлалын төрлүүдээс сонирхолтой асуулт асуун, гараараа хийж туршин үзэж, уламжлалт гар урлалаараа бахархан, сэтгэл өндөр байгаагаа бидэнд илэрхийлж байлаа.



Гар урлалын өвийг өвлөн уламжлагчид

- 1.7 “Нүүдлийн соёл иргэншлийн үнэт зүйлс- хүн төрөлхтний соёлын биет бус өвийн өргөө” - Соёлын өвийн үндэсний төв, Нүүдлийн соёл, иргэншлийг судлах олон улсын хүрээлэн

Соёлын өвийн үндэсний төв

Монгол Улсаас ЮНЕСКО-ийн Соёлын биет бус өвийн жагсаалтад бүртгэгдсэн 15 өвийн зурагт танилцуулга, баримтат кино болон өвийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг PDF танилцуулгаар иргэдэд хүргэсэн. Мөн соёлын өвийн талаарх байгууллагаас гаргасан номын үзэсгэлэнг гарган олны хүртээл болгов. “Ковидын нөлөө цахим орчинд- өвлөн уламжлагчдын оролцоог тодорхойлох нь” судлагааг наадамд оролцож буй 50 орчим өвлөн уламжлагчаас авч ажиллав. Мөн Уламжлалт анагаах ухааны төрөлд хамаарах бариа засалч, судас барьж оношлох зэрэг 4-н өвлөн уламжлагчийг гэрэл зураг, дүрс бичлэгээр баримтжуулалт хийж өвийн мэдээллийн санд хадгалав.



Гэр үзэсгэлэнгийн танхимаар үйлчлүүлж буй олон нийт

“Нүүдлийн соёл иргэншлийн үнэт зүйлс: Нүүдэлчин Монгол” эрдэм шинжилгээний хурлын тайлан (Нүүдлийн соёл, иргэншлийг судлах олон улсын хүрээлэн)

ЮНЕСКО-ийн ивээл дор Нүүдлийн соёл иргэншлийг судлах олон улсын хүрээлэн нь “Нүүдлийн соёл иргэншлийн үнэт зүйлс – Нүүдэлчин Монгол” нэрийн дор дотоодын эрдэм шинжилгээний хурлыг гаргасан хөтөлбөрийн дагуу 8-р сарын 12, 13-ний өдрүүдэд Горхи Тэрэлжийн Сайханы Саравчид зохион байгуулж оролцов. Хурал нь үндсэн хоёр илтгэл, “Нүүдэлчдийн идээ ундааны соёл”, “Монгол улс 2023 онд зохион байгуулах Дэлхийн нүүдэлчдийн наадмын үзэл баримтлал, агуулга, цар хүрээ, зохион байгуулалт”, “Ардын уламжлалт анагаах ухаан”, “Нүүдлийн зан үйл, мал маллах арга ухаан” гэсэн дөрвөн дэд сэдвүүдийн дор илтгэл, хэлэлцүүлэг зохион байгуулав. Хуралд үндсэн хоёр илтгэл, дөрвөн дэд панелийн нийт 13 илтгэл болон Дэлхийн нүүдэлчдийн наадмын үзэл баримтлал, агуулгын талаар хэлэлцүүлэг зохион байгуулагдав.

Уг хуралд нийт 200 орчим хүн шууд оролцсон. Мөн хурлыг цахимаар шууд дамжуулсан бөгөөд “zoom”-ээр монгол болон гадаадын 100 гаруй үзэгч, мөн НСИСОУХ-ийн пэйжээр шууд дамжуулалтыг 2000 гаруй хүн цахимаар үзсэн. Тус хуралд оролцсон хүндэт зочид болон хурлын илтгэгчид, мөн хурал зохион байгуулагч нийт 30 гаруй хүнийг Горхи Тэрэлжийн “Хөмөг тур” амралтын газар байрлуулан, байр, тээврээр хангаж ажиллав.

Уг хурлаар монголчуудын уламжлалт арга ухааныг ЮНЕСКО-д бүртгүүлэх арга зам, бүртгэгдсэн соёлын өвүүд болон цаашид бүртгүүлэх шаардлагатай болон боломжтой өвүүдийн талаар салбарын эрдэмтдийг урин илтгэл хэлэлцүүллээ. Хурлын дэд хэсгүүд болох “Нүүдэлчдийн идээ ундааны соёл”, “Монгол улс 2023 онд зохион байгуулах Дэлхийн нүүдэлчдийн наадмын үзэл баримтлал, агуулга, цар хүрээ, зохион байгуулалт”, “Ардын уламжлалт анагаах ухаан”, “Нүүдлийн зан үйл,

мал маллах арга ухаан” сэдвүүдийн дор илтгэсэн панел бүрийн дараа хэлэлцүүлэг зохион байгуулсанд хуралд оролцогчдийн зүгээс талархал илэрхийлж байв. Цаашид Нүүдэлчдийн соёлын наадмыг эрдэмтэн судлаачдыг оролцуулан зохион байгуулах, онол практик хослуулан зохион байгуулах нь үр дүнтэй гэж үзэв. Хурлын илтгэгчид, хуралд танхимаар болон цахимаар оролцсон хүмүүсийн саналыг нэгтгэхэд дараах дүгнэлт гарч байна. Үүнд:

- Монгол улс “Нүүдэлчид” болон “нүүдлийн соёл, иргэншил” гэх ижилсэл, соёлын уламжлал, сэтгэлгээний онцлогын дэвшилтэт талыг даян дэлхийд түгээн дэлгэрүүлэх, бүс нутагт манлайлахад нэг гол тулгуур багана болж ажиллах, энэхүү ижилслийг дангаар өмчлөхөөс илүү бусад улсуудтай хуваалцах байдлаар олон улсын анхаарлыг Монгол улсад татах,
- Дэлхийн нүүдэлчдийн их наадамыг 2023 онд Монгол улсад зохион байгуулах үзэл баримтлалын талаар дараах саналыг гаргав. Үүнд:
 - Үзэл баримтлал боловсруулахдаа мэргэжлийн холбоод, судлаачид, хувийн хэвшил, төр засгийн оролцоог хангасан ажлын хэсгийн хүрээнд 2022 оны 9 сард боловсруулж дуусгах, 2023 оны төсвийн төсөлд суулгаж, 2022 оны 11 сар гэхэд ажлын төлөвлөгөөг батлуулж, олон улсад зарлах,
 - Их наадмын гол үзэл санаа нь нүүдэлчдийн талаарх ойлголт үзэл баримтлалыг эерэг болгоход чиглэх, ялангуяа суртал ухуулгад баригдаагүй орон орны шинэ залуу үеийг зөв ойлголттой болгоход чиглүүлэх,
 - Их наадмын зохион байгуулалтыг орчин үеийн шинэ хандлага хэлбэр хандлага тухайлбал “Playtime” зэрэг урлаг соёлын фестиваль, зохион байгуулалтын зоримог шийдэл хайж, арилжааны болон төрийн зохион байгуулалтыг хослуулж зардал, үр ашгаа нөхөх тогтолцоонд алгуур шилжүүлэхийг одооноос тооцох. Зохион байгуулалтыг гэрээгээр хувийн хэвшил, мэргэжлийн холбоодуудад өгч зохион байгуулах.
 - Зохион байгуулалтын хувьд аялал жуулчлалын оргил цагт, орон зайн багтаамж бүхий газар, өв соёлоо уламжлан хадгалж буй бодит орчныг бүрэлдүүлэн хийх нь цаашдын тогтвортой байдал, бусад наадмаас ялгарах онцлог болно.
- Монголчуудын соёлын биет бус өвийн уламжлал, орчин үеийн талаар эрдэм шинжилгээний судалгаа, цуврал хэлэлцүүлэг, соён гэгээрүүлэх сургалт сурталчилгааны ажлыг нэмэгдүүлэх, санхүүжилтийг шийдэх,
- Төв болон Дотоод Азийн улс орнуудад нүүдлийн соёл иргэншлийн өв, уламжлалыг тандан судлах ажлыг одооноос системтэйгээр, шат дараатайгаар тодорхой он жилүүдэд давтамжит байдлаар явуулах ажлыг төлөвлөх, стратеги боловсруулах,
- Өвлөн уламжлагч-хувийн хэвшил-судлаачдын хамтын ажиллагааг сайжруулах өртөг зардлаа нөхөх арилжааны шинжтэй төслүүдийг дэмжих, соёл урлагыг дэмжих санд тусгах,
- Тус хурал дээр “идээ ундаа,” “уламжлалт анагаах ухаан,” “мал маллах арга ухаан” зэрэг соёлын биет бус өвийг хэлэлцээд эдгээрийг ЮНЕСКО-д бүртгүүлэх бүрэн боломжтой гэж дүгнэсэн төдийгүй, соёлын биет бус өвүүдийг судалж буй байгууллага, институци дан дангаар үйл ажиллагаа явуулж байгааг Соёлын яам

нэгтгэх, нэгдсэн удирдлагаар хангаж, ай сав бүрээр өргөжүүлсэн хороо, судлаачдын сүлжээг бий болгох зэрэг болно.



Эрдэм шинжилгээний хуралд оролцогчид

1.8 “Эрчист Монгол өргөө” - Монголын уран зургийн галерей, Бурхан Халдун уул түүнийг хүрээлсэн тахилгат газар нутгийн хамгаалалтын захиргаа

Монголын уран зургийн галерей болон Бурхан халдун уул, ТХТГНХЗ хамтран Монгол Улсын энергийн төв болсон (Дэмчогийн хийд, Даян дээрхийн агуй, Төвхөн хийд, Хамрын хийд, Дэлүүн болдог гэх мэт) газруудыг сурталчлан таниулах, орчин үеийн техник технологийг ашиглан гэрийг тохижуулж байгаль дэлхийн эрчим энергээс үзэгчид дэргэд нь очиж энерги авсан мэт мэдрэмжийг төрүүлэх, үзэгчдийг мэргэжлийн байгаль эхийн бясалгагч багш чиглүүлж, Sound Artist өндөр давтамжтай хөгжмийн зэмсгийг ашиглан байгалийн энергийг мэдрэх боломжийг бүрдүүлэх зэргийг агуулгаа болгон гурван өдрийн турш дээрх зүйлсийг тусган үйл ажилаагааны хөтөлбөрөө төлөвлөн зохион байгуулж, хэрэгжүүлсэн юм.

Эрт цагийн амар амгалан ба байгальд ойр Монгол /8 сарын 12-14 үндсэн үйл ажиллагаа/ Үндсэн үйл ажиллагаа гэрийн гадна болон гэрийн дотор хэсэгт явагдах бөгөөд гэрийн дотоод орчныг Байгаль эх, дотоод энерги, амар амгаланг агуйн доторх декрациар илэрхийлж, гэрлийн шийдлээр гэрийг DAZ ART студиогоор мэргэжилийн өндөр түвшинд хийлгэн, тохижуулсан бөгөөд мөн гэрийн дотор байгалийн үнэрийг бүрдүүлсэн юм. Гэрийн дотоод орчныг уламжлалт болон орчин үеийн техник технологийг хослуулж хойморын хэсэгт ханыг дагуулан хагас дугуй хэлбэрийн лед дэлгэцийг байрлуулсан. Уг дэлгэцээр Монгол орны төв болсон газруудыг үзүүлсэн бөгөөд тус бүрт нь 15-20 минутын дүрсийг дуу дүрсний өндөр чанартай, тайлбар домог түүхийн хамт тусгайлан бэлтгэсэн юм. Үүнд Монгол улсын төрийн тахилгат хайрхад болох /Алтай таван богд, Алтан хөхий, Алтан овоо, Богд хан хайрхан, Бурхан халдун хайрхан, Говь гурван сайхан, Отгонтэнгэр хайрхан, Суварга хайрхан, Сутай хайрхан, Хан Хөхий уул/ зэрэг 10 уул мөн байгалийн үзэсгэлэнт газруудыг багтаасан болно. Мөн гэрийн дотор манай орны энергийг төвүүд хийгээд бусад тахилгат шүтээний газруудын эрчим энерги шингэсэн ус, мод,

чулуу зэргийг хүмүүст сонирхуулсан юм. Жишээ нь: Хэрлэн, Онон, Туул гурван голын домгийг контент хэлбэрээр үзүүлэхээс гадна бодитоор гурван голын усыг авчирсан бөнөөд гурван голын домгийг сонссон үзэгчид гурван голыг нэгтгэх уламжлалт домгыг хийсэн юм.

Эрчист Монгол өргөөнд дан ганц байгалийн орчинг бүрдүүлснээс гадна байгалийн дуу авиан засалч sound artist хөгжимдөж, Байгаль эхийн бясалгалч багш үзэгчдийг энерги авахад чиглүүлсэн юм. Ингэснээр Монгол хүн дэлхийн бусад хүн төрөлхтнөөс онцгойрон ялгарах шинж болох “Нүүдэлчин ахуй, бүтээлч сэтгэлгээ, өндөр дасан зохицох чадвар”-ыг эргэн сануулж, одоо ч бид байгаль эхтэйгээ холбогдож, ямагт ойр оршин түүнээсээ амьдралын эрч хүч, энергийг авч, зөв хуваарилж чадна гэдгийг хүн бүрд мэдүүлэхийг зорьсон билээ.



Эрчист Монгол өргөө

1.8 “Хүүхдийн өргөө”-г Хүүхдийн төв номын ордон болон Улсын Хүүхэлдэй театр

Улсын Хүүхэлдэйн Театр

Хүүхдийн өргөө нь соёлын биет бус өвийн 7 ай савын хүрээнд соёлын биет бус өвийг хүүхэд багачуудад таниулах олон төрлийн үйл ажиллагааг зохион байгуулав.

Хүүхдийн өргөөний үйл ажиллагааг гэрт болон гадаа хийх 2 хэсэгт хуваан үйл ажил тус бүрийг 1-3 хүн хариуцан ажилласан. Гэрт болох үйл ажиллагаанд: Эсгий ширмэл оёх, хээ угалз зурах, ээрүүлээр утас ээрэх, хүүхэлдэйн театрын үзмэрийн хүүхэлдэйнүүд болон үйл ажиллагааг танилцуулах, оньсон тоглоом тоглох аргыг заах, дээлийн шилбэ зангидах зэрэг үйл ажиллагаанууд явуулсан бол гадаа болох

үйл ажиллагаанд: “Жигүүрхэндээ хүчтэй” хүүхэлдэйн жүжгийн урран бүтээлийн тоглолт, сур элдэх арга, хүүхдүүдийн дундах асуулт хариултын тэмцээн, нум сум харвах арга, сур элдэх арга зэрэг үйл ажиллагаануудыг үзүүлэх, сургаж зааж өгөхийн зэрэгцээ үйл ажиллагаа бүрийн мэдээ мэдээллийг хүн бүрт танилцуулан ажилласан. Тус театраас “Хүүхдийн өргөө”-нд зохион байгуулсан үйл ажиллагаанд давхардсан тоогоор нийт 619 том хүн, 1446 хүүхэд оролцсон байна.



Хүүхэлдэйн жүжиг

Хүүхдийн төв номын сан

Соёлын өвийг сурталчлах, таниулах зорилгоор Хүүхдийн төв номын сангийн өргөөнд Эзэн Чингисийн мэндэлсний 860 жил, Ардын хувьсгалын 100, 101 жилд зориулсан витрин-хэсэг, мөн Төрийн бэлгэдэл, Нүүдэлчин Монгол ахуй, Язгуур урлаг гэсэн сэдэв агуулгаар үзэсгэлэн дэглэж, Хүүхдийн өргөөгөөр зочилсон 800 гаруй хүүхэд багачууд, иргэдэд холбогдох соёл уламжлал, түүхээс тайлбарлаж таниуллаа.

Рома Хүүхэлдэйн театртэй хамтран Ойн амьтадтай хамт бий биелэх хөгжилтэй сургалт тэмцээнийг зохион байгуулж, үндэсний бий биелгээг хэрхэн бүжиглэхийг зааж утга агуулгыг тайлбарлан өгч, оролцогч бүх хүүхдийг гарын бэлгээр урамшуулсан. Бий биелгээг 5 удаа зохион байгуулж 550 гаруй хүн оролцсон байна.

Дэд бүтэц

1. Гадна болон дотор цахилгааны ажил:

8-р сарын 11-12-нд гадна болон дотор цахилгааны ажлыг нийт 15 хүний бүрэлдэхүүнтэй баг 7 генераторын, 5400м цахилгааны монтаж, 60 ширхэг дотор гэрэлтүүлэг, 140 ширхэг разетка, 4 ширхэг гадна гэрэлтүүлгийн угсралт, холболтын ажлыг хийж гүйцэтгэсэн байна. Нийт 190 гаруй гэр, асар, их, бага 2 тайзыг цахилгаанд холбов.

Талбай дээр 7 байнгын, нөөцөнд 2 генератор ажиллуулав. Генераторуудын байнгын үзлэг үйлчилгээг УБЦТС ТӨХК-ийн Налайх түгээх салбарын багтай хамтран 24 цагийн ээлжээр хяналт тавин ажиллалаа. Зурагт тусгагдаагүй гэр гал тогоог нийслэлийн байрлаж байсан отогт барьж ажиллуулсаны улмаас 30кВА-ийн 1 ширхэг генераторын нэгдүгээр фазад хэт ачаалал үүссэний улмаас 8-р сарын 11-ний 22:00 цаг орчимд гэмтэл гарч яаралтай арга хэмжээ аван өөр генератораар орлуулан ажиллуулав. Генераторуудын түлшний дүүргэлтийг байнгын түлш цэнэглэх автомашин байршуулан цэнэглэн ажиллав.

Наадмын өдрүүдэд 1 инженер, 4 цахилгаанчин жижүүрлэн ажиллав. Ашиглалтын явцад ямар нэгэн цахилгааны саатал доголдол гараагүй болно.

2. Авто зогсоол:

8-р сарын 11-ний өдөр сайн дурын 10 хүүхэд, цагдаагийн газартай хамтран план зургийн дагуу А, В, С, D, E гэсэн 5 хэсэгт 1700 автомашины багтаамжтай зогсоолийн зурвасуудыг тууз болон цагаан шохойгоор 1200м урт тэмдэглэгээ хийж цагдаагийн байгууллагад хүлээлгэн өгөв. Нэмэлтээр цагдаагийн хамгаалалтын 480ш зориулалтын металл хашлагуудыг төв зам дагуу 2км зайд тараан байршуулан хазгаарлалтыг тогтоов. Мөн авто зогсоол болгон дээр зогсоолын шалган нэвтрүүлэх пост ажиллуулах асар байрлуулж сайн дурын ажилтнуудыг цагийн хуваарийн дагуу цагдаагийн албан хаагчидтай хамт ажиллуулав.

3. Цэвэр усны хангамж:

Чандмань Налайх ОНҮААТҮГ-ээс 20 тонны 1 ёмкост, шаардлагатай 4 цэгт 1-4 тонныг цэвэр усны танк байрлуулан гал тогоо, худалдааны гудамж, аймгуудын асарт цэвэр усаар хангасан бөгөөд Налайх дүүрэг дэхь мэргэжлийн хяналтын хэлтэст 8-р сарын 11-ний өдөр усны шинжилгээ өгч, ёмкостуудад ариутгал хийж, шинжилгээгээр баталгаажсан цэвэр усаар хангаж ажилласан.

4. Бие засах газар, бохир зайлуулах менежмент:

8-р сарын 11-15 өдрүүдэд Даваамөнх ХХК, Мөнхийн хүндлэл ХХК, иргэн Б.Энхчимэг, Э.Энхтайван, Налайн дүүргийн Чандмань Налайх ОНҮААТҮГ нартай ажил гүйцэтгэх гэрээ хийж наадмын нийт талбайн нийтийн бие засах газрыг байгуулах, цэвэрлэгээ үйлчилгээг хариуцан ажиллуулаа.

Нийт 6 байршилд 70 ширхэг зөөврийн БИО ариун цэврийн зөөврийн байгууламж байршуулж, 35 удаа бохирыг нь соруулж, 390 тонн бохир зөөвөрлөн асгууллаа. Наадмын талбай дээр анхнаасаа байсан нийт 14 хаалга бүхий нийтийн модон бие засах газруудыг доторхыг цэвэрлэж шал ханаыг будаж угааж цэвэрлэн нийтэд үйлчлэхэд бэлэн болгож өнгө үзэмжийг сайжруулан бэлдсэн. Өдөр болгон ариутгалын бодисуудыг цацаж, угааж, цэвэрлэх ажлуудыг тогтмол хийж гүйцэтгэсэн.

Гал тогооны бохирын ёмкост, худалдааны төв, 21 аймгийн хоолны асраас нийт 8 удаагийн рейсээр 20 тонн бохир соруулж Налайх дүүргийн бохирын цэгт зөөвөрлөн асгасан.

5. Хог тээвэрлэлт, цэвэрлэгээний менежмент:

21 аймаг, нийслэлийн отог, Соёлын өвийн хүрээний гэрүүд, хэвлэл мэдээллийн төв, зохион байгуулах штаб, Био 00-д нийт 200 ширхэг жижиг хогийн сав, 28 газарт 200л бошка бүхий зөөврийн хогийн цэгүүд байгуулж сайн дурын ажилтнууд байнга тэдгээрийг төв цэг рүү зөөж, цэвэрлэх ажлыг хийж гүйцэтгэсэн. Нийт 14 тамхины цэгийг, хогийн савтай нь байрлуулсан. Наадмын талбайн гол цэгүүдэд 4 ширхэг зөөврийн хогийн том тэвш байршуулж дүүрсэн үед ээлжлэн зөөх хэлбэрээр нийт 26 удаагийн тээвэрлэлтээр 65 тонн хог хаягдал зөөвөрлөсөн.

Наадмын талбайн хогийг сайн дурын ажилтнууд болоод цэргүүд өглөө, өдөр, оройд тогтмол цэвэрлэх ажлыг зохион байгуулж байсан бол төв хаалганаас гадна талд авто машины зогсоолын дэргэдүүр зөвшөөрөлгүй ирж худалдаа үйлчилгээ хийсэн иргэдийн тарьсан хог хаягдал хэт их байсан бөгөөд өөрсдийн тарьсан хогийг огт цэвэрлэхгүйгээр хаяад явцгаасан 49 га талбайн 40 тонн хогийг сайн дурын ажилтнууд болон цэргүүд цэвэрлэж Лишцэцэг ХХК-аар тээвэрлүүлсэн. Горхи Тэрэлжийн байгалийн цогцолборт газрын хамгаалалтын захиргаанд наамдын талбайг анх хүлээж авсан байдлаар хоггүй бүрэн бүтэн хүлээлгэн өгөв.

6. Сайн дурын ажилтнуудын оролцоо:

Монголын Скаутын Холбооны нийт 100 сайн дурын залуучууд 7 хоногийн хугацаанд ажилласан. 1 өдөрт 1 сайн дурын ажилтан дунджаар 10 цаг ажилласан бөгөөд 7 хоногт 100 сайн дурын ажилтан нийт 7000 цагийн ажил хийж гүйцэтгэсэн байна. Наадмын үйл ажиллагаанд сайн дурын ажилтнууд:

1. Бүтээн босголтын бэлтгэл ажлууд,
2. Дэд бүтцийн тохижилтын ажлууд
3. Орчны цэвэрлэгээ, хог хаягдлын менежмент
4. Авто зогсоол, шалган нэвтрүүлэх цэгийн зохицуулалт
5. Хоолны заалны үйлчилгээ

6. Мэдээллийн төвүүдэд туслан ажиллах,
7. Зочдод үйлчлэх багуудад хуваарилагдан ажиллах,
8. Тусгай хэрэгцээт зочид, оролцогчдод туслах
9. Наадмын талбайн эргүүл, хамгаалалтанд гарах,
10. Үйл ажиллагааны төвүүд, спорт, наадмын хүрээний менежментэд тусалж ажиллах,
11. Ачаа тээвэр, зөөх буулгах ажлуудад туслах,
12. Зохион байгуулах багуудад хүн хүчний тусламж үзүүлэх зэргээр хамгийн өндөр ачаалалтайгаар туслан ажиллалаа.

7. Асар, гэр, майханы түрээсийн хангамж:

Оролцогч нарыг тосох, үдэх үйл ажиллагаа, уран бүтээлчдийг байрлуулах асар, шүүгчид, хэвлэл мэдээллийнхэн, зохион байгуулагч нарыг байрлуулах 5 ханатай 13 гэр, Аймаг, нийслэлийн соёлын бүтээлч үйлдвэрлэлийн үзэсгэлэн худалдаанд 22 асар, Нийслэлийн соёлын бүтээлч үйлдвэрлэлийн үзэсгэлэн худалдаанд 20 асар, 21 оролцогч аймаг, нийслэлийн уламжлалт идээ, ундааны үзэсгэлэнд 12 жижиг асар, 1 том дугуй асар, нийтийн худалдаа үйлчилгээнд зориулан 12 асар, мэдээллийн төвүүдэд зориулан 4 монгол асар, нийт 13 монгол гэр, 11 монгол асар, 94 европ асар, майхан түрээслэн барьж үйл ажиллагааг зохион байгууллаа.

8. Оролцогчдын тээвэрлэлтийн менежмент:

Автобус тээврийн үйлчилгээг 24 хүний суудалтай нийт 5 автобусаар 8-р сарын 11-ны өдрийн 06:30 цагаас эхлэн 8-р сарын 15-ны 21:30 цаг хүртэл тасралтгүй үйлчилгээ үзүүлсэн бөгөөд энэ хугацаанд дараах чиглэлийн дагуу нийт оролцогч, зочид, сайн дурын ажилтнуудыг тээвэрлэсэн.

Оролцогч, үзэгч нарын буудалласан байршлаас наадмын талбай хүртэлх тээвэр өглөө болон оройд нэг автобус 5-6 рейс хийсэн. Наадмын талбайн төв хаалганаас талбайн эсрэг тал хүртэл 4-5 км замд тасралтгүй явсан, энэ ажил нь цаг агаарын нөхцөл байдлаас болж нэмэлтээр хийгдсэн /Shuttle bus/ мөн нийтийн тээврийн автобус иртэл үзэгчдийг хамгийн ойрхон байгаа автобусанд хүргэж өгөх тээврийг хийсэн.

Нийт 21 аймгийн оролцогчдын 45 хүний суудалтай автобусыг шатахуунаар ханган ажилласан, аймгууд дийлэнх нь автобустай байсан боловч манай автобуснууд бүх амралтуудыг тойрч хоцорсон, үлдсэн хүмүүсийг наадмын талбайд авчирч байсан.

Сайн дурын ажилтнууд, шүүгч нарын Улаанбаатар хотоос наадмын талбай хүртэлх тээвэр мөн нэмэлтээр 19 аймгийн оролцогч нарын 24-45 хүний суудалтай

автобус тус бүрт наадмын талбайгаас оролцогч нарын буудалласан амралт хүртэл түлшний зарцуулалтыг тооцон нийт 3 өдрийн түлшийг талоноор тооцож олгосон.

8-р сарын 11-15-ныг дуустал нийт 5 хоногийн хугацаанд давхардсан тоогоор 3600 орчим хүнд наадмын талбай, байрлах амралт, наадмын талбайг тойрсон тээврийн үйлчилгээг 06:30-21:30 цаг хүртэл тасралтгүй үзүүлсэн байна. Энэ хугацаанд оролцогчид, үзэгч, сайн дурын ажилтнуудаас тээвэр үйлчилгээтэй холбоотой аливаа санал гомдол ирээгүй ба үзэгч, оролцогчдыг аюулгүй, сааталгүй тээвэрлэн ажиллалаа.

9. Хаяг, хаягжуулалт, чимэглэл, тэмдэг тэмдэглэгээ:

“Нүүдэлчин” дэлхийн соёлын фестивалд оролцогч аймаг, нийслэлийн отогийн хаягжилт, нэрийн пайз, соёлын өвийн хүрээний хаягжилт, худалдааны төвийн асар майхнуудын хөмсөг хаяг, орох, гарах хэсэг, тасалбар худалдах цэгийн хаягжилт, оролцогчдын хоолны газрын хаягжилтуудыг 8-р сарын 5-11-ний өдөр хийж гүйцэтгээд зохих газруудад байрлуулав.

№	Нэршил	Хэмжээ	Тоо ширхэг
1	Аймгуудын хаягжилт - даавуу	1,2м x 0.4м	88ш
2	Аймгуудын нэртэй пайз иштэй – түрээс	0,4м x 0,6м	22ш
3	Соёлын өвийн хүрээний хаягжилт - даавуун	1,2м x 0.4м	13ш
4	Худалдааны төвийн хаягжилт - хулдаас	5м x 0,5м	31ш
5	Орох хэсгийн хаяг - хулдаас	1,5м x 0,4м 3м x 0,4м	4ш
6	Аймгуудын хоолны худалдааны хаягжилт - хөөсөнцөр	1м x 1м	22ш
7	Хэвлэл мэдээллийн төвийн хаягжилт - хулдаас	2м x 0,4м	1ш
8	Зохион байгуулагчдын хорооны хаягжилт - хулдаас	2м x 0,4м	1ш
9	Автобусны хаягнууд - хөөсөнцөр	0,6 x 0,4	7ш
10	Оролцогчдын хоолны газрын хаягжилт – Хөөсөнцөр, хулдаас, даавуу	1,4м x 0,3м	4ш
11	Наадмын том туг	3м x 1м	28ш

12	Наадмын жижиг туг	1,8м x 0,6м	60ш
13	Аймгуудын далбаа	0,9м x 1,5м	22ш
14	Спортын хүрээний том туг	3м x 1м	8ш
15	Гурвалжин туг жижиг	0,4м x 0,4м	150ш
16	Гурвалжин туг том	1м x 1м	50ш

Аймаг, нийслэлийн отогийн хаягжилтуудын байгальд ээлтэй, эко байдлаар хийхийн тулд даавуун дээр хэвлэж гаргах, 2 төрлийн байрлалаар байрлуулах байдлаар загвар гаргасан бөгөөд гэрийн бүслүүрт уяж баруун талд нь тогтоосон.

Фестивалийн аймаг болгоны нэртэй далбааг хийж, 2ш тугийн өндөрлөг отог болгон дээр суурилуулан аймгийн үндсэн туг, наадмын далбааг байрлуулсан. Мөн эдгээр далбааг барьж нээлтийн үйл ажиллагаанд жагсаж оролцох тугны иш, аймгуудын нэртэй модон пайзуудыг түрээслэн бүх аймгуудад түгээсэн.

Худалдааны төв хэсэгт ажилласан асар майхнуудыг хөмсөгөн хаягжилтууд, аймгуудын хоол, идээ ундаагаа таниулан худалдах асарт 21 аймаг, Улаанбаатар хотын хаягыг хөөсөнцөрөөр хийж байрлуулав.

Талбайд оролцогчид, үзэгчдэд үйлчилж ажилласан газруудын хаягжилтуудыг захиалгын дагуу наадмын өнгө төрхөнд нь тааруулан хулдаас, хөөсөнцөр, даавуу, стикер зэрэг материалууд дээр хэвлүүлж хийж гүйцэтгэлээ. Нээлтийн үйл ажиллагаанд хэрэглэхээр 46 ширхэг төрийн далбааг, ишний хамт түрээслэн ашиглалаа. Фестивалийн өдрүүдэд бороо их орсон тул аймгуудын нэрийн пайзууд, асарын гадна хаяг, даавуун хэвлэл, хөөсөнцөрүүд норж, дахин ашиглагдах боломжгүй болж гэмтсэн.

Наадмын талбайн тэмдэг, тэмдэглэгээг дараах цэгүүдэд хийж байрлуулсан.

1. Автомашины зогсоолын тэмдэглэгээ – 6 хэсэгт
2. Ариун цэврийн БИО 00, хогийн цэгийн хаягжуулалтын тэмдэглэгээ – 6 газарт
3. Наадмын талбайн дунд зүг чиг заасан модон сум, хаягжуулалт – 9 газарт
4. Эмнэлэгийн үйлчилгээний газрын хаягжуулалт
5. ОБЕГ, Эмнэлэг, МХЕГ, Цагдаагийн хэсгийн ажиллах хэсгийн тэмдэглэгээ
6. Наадмын үзэгчдэд зориулсан талбайн дундах 3х2м хэмжээтэй газрын зураг – 3ш
7. Соёлын өвийн хүрээний хөтөлбөр бүхий 2х3м хэмжээтэй самбар – 1ш
8. Үзэгчдийг ирэх замыг тодорхой байлгах үүднээс Тэрэлжийн төв замаас наадам болох талбай руу салсан зам дээр 3 самбар дээр баннер тогтоож зүг чиг заах тэмдэглэгээ хийв.
9. Мэдээллийн төвүүдийн хаягжуулалт, тэмдэглэгээ – 4 газарт

10. Наадмын зохион байгуулалтын тугнуудад түрээсийн суурь, ишнүүд хийж төв замаас наадмын талбай хүртэл зам дагуу байрлуулан чиглэл заасан тэмдэглэгээ хийлээ.
11. 21 аймаг отог Нийслэл хүрээг холбосон модон түр гүүрийг нийт 500 ширхэг шургаагаар 6м х 25м -150м² харьцаатайгаар хийж гүйцэтгэв.

13. Зохион байгуулагчид, оролцогчдын байрлах байр, тээврийн менежмент:

“Нүүдэлчин” дэлхийн соёлын фестивалд оролцогчид болон зохион байгуулагчид, бусад харъяа агентлагууд болон ТВ, Маркетингийн агентлагууд зэрэг нийт 1741 хүнийг 22 жуулчны бааз, амралтын газруудад байршуулах ажлыг 2022 оны 8-р сарын 11-15-ны хооронд зохион байгууллаа. Амралтын газруудаас наадмын талбай хүртэлх зай харилцан адилгүй буюу 7-18км зайтай байсан бөгөөд аймгуудын өөрсдийн авч ирсэн автобусуудад бензин талон өгч тээвэрлэсэн. Үйл ажиллагаанд ашигласан 5 автобусыг өөрсдийн автобус тээвэргүй ирсэн Сэлэнгэ, Дархан-Уул, Баян-Өлгий аймгуудыг өглөө болон оройдоо наадмын талбай болон амралтын бааз руу тээвэрлэх, мөн үйл ажиллагаа болох талбайн дотор 07:00 цагаас 19:00 цаг хүртэл оролцогчид болон үзэгчдийн тав тухыг хангах үүднээс тээвэрлэх үйлчилгээнд зогсолгүй явуулж ажиллууллаа.

Үйл ажиллагаанд 8 ААН, 1 ОНӨҮГ, 10 хувь хүнтэй байрны менежмент хийж жижиг амралтын гэрүүд түрээслэх зэргээр нийт 22 амралтын газар, жуулчны баазуудад 1,741 ор хоногийн /4 өдрийн 6,964/ захиалга өгсөн ба 8 газраас бусад газруудад 4 өдрийн захиалга өгч төлбөр тооцооны хүрэлцээг шийдсэн.

Үндсэн үйл ажиллагаа болох эхний мэдээлэл авсанаас хойш Горхи-Тэрэлжийн байгалийн цогцолборт газрын жуулчны бааз, амралтын газруудад захиалга өгөх ажил хийгдэж эхэлсэн хэдий ч төсөв батлагдаагүй, хугацаа тодорхойгүй зэрэг шалтгааны улмаас төлөвлөсөн амралтын газруудынхаа захиалгаа алдсан. Үйл ажиллагаа болохоос 10 хоног хүрэхгүй хугацаанд дахин наадамд оролцогчдын байрлах байруудыг хайж захиалга өгөгдсөн. Энэ нь оролцогчид зохион байгуулагчдын байрлах байр нь ямар нэгэн сонголтгүй, Наадам болох талбайгаас хол, мөн өндөр өртөгтэй, зарим оролцогч аймгуудад тав тухгүй байр олдсон хүндхэн ажил болсон билээ. Иймд дараа дараагийн арга хэмжээнд үүнийг анхаарууштай гэж үзэж байна.

Соёлын фестивалд оролцохоор ирсэн 22 аймгийн оролцогчдын мэдүүлгээс гадна дагалдан ирсэн хүмүүсийн / Арын албаны ажилчид, тогооч нар, гэр бүлийн хүмүүс, асран халамжлагч нар г.м / тоо өгөгдөөгүй тул амралтын газрын захиалсан орны даацыг хэтрүүлсэн, зөвшөөрөгдөөгүй сул гэр болон байшинд дур мэдэн нэвтэрч амарсан асуудлууд гарсан. Мөн яамдын харъяа агентлагуудын оролцогчид, зохион байгуулагчид, нэмэлтээр үзэсгэлэн гаргасан болон урлаг соёлын зэрэг

хүмүүс нэмэгдсэн. Энэ нь үндсэн төсөвлөсөн оролцогчдын тооноос хэтэрч нэмэлт төлбөр нэхэх асуудал нилээдгүй дагуулсан болно. Дээрхи асуудлаас Өмнөговь аймгийн оролцогчдын зохион байгуулалтаас бусад аймгууд суралцаж цаашид анхаарах нь зүйн хэрэг юм. Өмнөговь аймаг нь үндсэн мэдүүлэг 61 хүн гэж өгснөөс Нэмэлт 25 хүн өөрсдийн зардлаар хамт 1 газар байрлах хүсэлтээ ирүүлсэн бөгөөд энэ нь ямар нэгэн үл ойлголцол үүсгэхээргүй маш зөв зүйтэй алхам болсон.

“Нүүдэлчин монгол-2022” дэлхийн соёлын фесвивальд оролцогчид болон зохион байгуулагчид, бусад харъяа агентлагууд, Телевизүүд, маркетинг агентлагууд зэрэг албан ёсны 1741 хүн, мөн дагалдан ирсэн 400 гаруй буюу нийтдээ 2141 хүнийг жуулчны бааз амралтын газруудад байршиж 300 гаруй сая төгрөгийн орлого оруулсан. Мөн ойролцоогоор 2000 гаруй үзэгчид 50 гаруй жуулчны баазуудаар байрласан бөгөөд 120,000,000 төгрөгийн орлого оруулж нийтдээ Горхи-Тэрэлжийн байгалийн цогцолбор газарт 420,000,000 гаруй төгрөгийг эргэлтэнд оруулсан нь бизнес эрхлэгчидэд ач тустай, мөн соёлын өв тээгч нарт маань хүртэл сэтгэл ханамж дүүрэн томоохон үйл ажиллагаа боллоо.

14. Нийтийн тээврийн менежмент

Нийслэлийн нийтийн тээврийн газар 3 өдрийн турш Офицеруудын ордоноос Нүүдэлчдийн наадам хүртэл 40 хүний суудалтай автобусаар нэг хүний 2300₮-р тээврийн үйлчилгээ үзүүлсэн.

Эхний өдөр буюу 8-р сарын 12-ны өдөр 2 цаг тутам автобус явсан нь хүрэлцээ муу байсан. Туулах замын хувьд нэг талдаа 110 минут зарцуулж явсан. Автобус хүрэлцэхгүй байсан тул Тэрэлжийн чиглэлийн автобус нүүдэлчдийн наадам хүртэл замаараа маршрутаа өөрчлөн хүргэлт хийсэн.

8-р сарын 13,14-ний өдрүүдэд 5 автобус 07:40; 09:00; 10:00; 10:30; 11:30; 13:00; 14:00; 15:00; 16:00; 17:00; 18:15 цагуудад Офицеруудын ордоноос хөдлөөд 1 цаг 50 минут явж очоод 10 мин болоод буцаад хотруу ирэх байдлаар үйлчилгээнд явсан.

Өглөө эхний автобус хоосон хүнгүй харин 10-15 цагийн хооронд хүн дүүрэн явсан ба орой 18 цагаас хойш хотруу ирэх хүмүүс багтахгүй нэмэлтээр Тэрэлжийн чиглэлд явдаг автобуснууд замаасаа хазайж үзэгчдийг авч ирсэн.

15. ХУдалдаа, үйлчилгээний хэсгийн үйл ажиллагаа

Наадмын үйл ажиллагааны Худалдаа үйлчилгээний төвд оролцогч 21 аймгийн хүнсний болоод гар урлалын бүтээгдэхүүний үзэсгэлэн худалдааны 11 асар, Нийслэлийн жижиг дунд үйлдвэрлэлийн худалдаа үйлчилгээний 20 асар, бусад хувь хүмүүс, байгууллагуудын худалдаа үйлчилгээ үзүүлэх асаруудын үйл

ажиллагааг зохион байгуулсан. Хоол, хүнсний худалдаа дээр Нийслэлийн захирагчийн албанаас 8 байгууллага, Налайх дүүргээс 6 байгууллагын нэр ирсэн. бүгд оролцсон. Хоол худалдаа дээр нийт 20 байгууллага хоол болон хүнс, кофе, ахуйн бараагаар үйлчилсэн.

21 аймгууд болон мастер тогооч нарын “УЛАМЖЛАЛТ ХООЛНЫ ӨРГӨӨ” барьж, тохижуулан наадамчдад үйлчлэн ажиллуулсан.

Худалдаа үйлчилгээний хэсгийн бас нэгэн ажил нь нийт наадамд оролцогчид болон зохион байгуулагч нарыг цэвэр усаар хангах ажил байсан бөгөөд нийт 6,8 тонн усыг 21 аймгийг отог, зохион байгуулах хорооны штаб, үйл ажиллагааны төвүүдэд тарааж хүргэсэн.

Наадмын нийт өдрүүдэд худалдааны төвийн дэргэд 40тн багтаамжтэй хөргүүр байрлуулан ажиллуулж наадмын үйл ажиллагааны оролцогчдын хоол ундаа, идээ шүүсийг хадгалах зохицуулалтыг хийж ажилласан.

Бидний үйл ажиллагааны төлөвлөгөөнд ороогүй гэнэтийн зүйл нь наадмын орох хаалганаас гадна байрласан зөвшөөрөлгүй гар дээрээс хоол, хүнсний зүйлс, хүүхдийн тоглоом, ахуйн бараа худалдаалж байгаа хувь хүмүүсийн худалдааны цэгүүд байлаа. Эдгээр нь ямар нэгэн зөвшөөрөл байхгүй, зохион байгуулалтгүй, эрүүл ахуйн шаардлага хангаагүй нөхцөлд хоол хүнс хийж зарсан, хог маш их хэмжээгээр тарьсан зохисгүй үйл ажиллагаа байсан бөгөөд хүчний байгууллагуудын шаардлагыг хүлээж авдаггүй, зохицуулахад хүндрэлтэй асуудал байлаа.

16. Оролцогчдын хоол, үйлдвэрлэл үйлчилгээний менежмент

Фестивальд оролцогч нийт 1800 орчим үйлчлүүлэгчдэд өглөө, өдөр, оройн хоолоор үйлчлэх ажлыг нийтийн хоол, үйлдвэрлэл үйлчилгээний 3 гол компани, бусад 9 жижиг компани, байгууллагуудын хамтаар зориулалтын хоол үйлдвэрлэлийн урсгал дамжлага зохион байгуулалтыг стандартын дагуу зохион байгуулж, нийт 790^{м2} талбай бүхий ажлын байрыг бий болгон ажиллаж үйлчилгээ үзүүлсэн байна. Үүнд:

- 540^{м2} талбай бүхий үйлчилгээний заал;
- 170^{м2} талбайтай гал тогоо, бэлтгэл, хоол үйлдвэрлэлийн хэсэг;
- 64^{м2} талбайтай угаалга, бохирын хэсэг
- 16^{м2} хуурай хүнсний агуулах
- Хоолны бэлтгэл мах, хүнсний ногоог “Номадс Хоспиталити” ХХК-ийн

Бэлтгэлийн цехэд урьдчилан бэлтгэж зориулалтын хөргүүртэй тээврийн хэрэгсэлээр тээвэрлэн авчирч 50тн-ийн багтаамжтай хөргүүрт хадгалж, хэрэглэсэн байна.

Хоол үйлдвэрлэл үйлчилгээнд Ерөнхий зохион байгуулагч, Үйлчилгээний зохион байгуулагч, Эрүүл ахуйч, Технологич, Ерөнхий тогооч, Тогооч, Бэлтгэгч, Угаагч, Туслах ажилтан, Арын албаны ажилтанууд зэрэг чиг үүргийн нийт 78 ажилтан ажиллаж өглөө, өдөр, оройн хоол, халуун уух зүйлийн үйлчилгээг үйл ажиллагаа эхлэхээс дуусах хүртэлх хугацаанд эрүүл ахуй, чанарын өндөр түвшинд хийж гүйцэтгэлээ.

Ажилчдыг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт хамрагдуулж бүртгэл хөтлөлтийг хийн ажилласан.

Оролцогчдод анх гаргасан үйлчилгээний цагийн хуваарийн дагуу үйлчилгээг үзүүлэхэд хүндрэлтэй байсан тул арга хэмжээний хөтөлбөр байршил, уралдаан тэмцээний зохион байгуулалт зэргээс хамаарч оролцогч нарт өглөө өдөр оройн хоолны үйлчлэх 2 цагийг 4 хүртэлх цагаар сунгаж бүх оролцогч нарт халуун хоол уух зүйлсээр бүрэн үйлчилгээг үзүүлж ажилласан.

Мөн хоолыг зөвхөн зааланд идэх зохицуулалттай байсан ч оролцогч нарын дунд өндөр настай, хөгжлийн бэрхшээлтэй (тусгай хэрэгцээт иргэд) хүмүүс байсан тул хоол үйлчилгээг зөөврөөр олгох зохицуулалтыг хийж ажилласан.

Наадмын өдрүүдэд үйлчлэх хоолны тусгай меню гарган, түүний дагуу бэлтгэл үйлчилгээг хангаж ажилласан.

Хоол үйлдвэрлэл үйлчилгээний явцад эрүүл ахуй, хоол хүнсний гаралтай хордлого, халдвараас сэргийлэх зорилгоор дараах ажлууд хийгдсэн байна.

Үүнд:

- Ажилчдын ариун цэвэр, хувцаслалт, эрүүл мэндийн байдалд байнгын хяналт тавьж бүртгэл хөтлөсөн.
- Ажил эхлэхэд ажилчдад хөдөлмөр хамгаалал аюулгүй ажиллагааны өдөр тутмын зааварчилгаа өгч бүртгэл хөтлөсөн.
- Хийсэн хоол бүрээс ариутгасан саванд 150гр дээж авч 72 цаг зориулалтын хөргүүрт хадгалан, зааврын дагуу устгасан.
- Хоол хүнсэнд хэрэглэх бүтээгдэхүүний ул мөр мөрдөн тогтоох бүртгэл хөтлөлтийг хийж, хүнсний бүтээгдэхүүн хадгалах 5 хөргөгч, 50 тоннын багтаамжтай хөргүүртэй агуулахад температурын хяналт хийж бүртгэл хөтлөсөн.
- Өдөр тутмын цэвэрлэгээнд Ecolab компаний үйлдвэрлэсэн OC Quat sanitizer KR бодисын 0.04 хувийн уусмалаар ширээ сандал, вандан тавиур зэрэг хүнстэй шууд харьцах гадаргууг шүршиж арчих аргаар, шал, бохирын хоолой зэрэг хүнстэй шууд харьцахгүй гадаргууг Compact Quat sanitizer бодисын 0.1 хувийн уусмалаар шүршиж халдваргүйтгэл, ариутгалыг тогтмол хийж ажилласан.

- Аяга таваг халбага сэрээний дамжлагат угаалганд фэйри, хүнсний содийн 1 хувийн уусмал, алимны цууны сулруулсан уусмал ашиглаж халдваргүйтгэл хийсэн.
- Бэлэн хоолыг халгалах нөхцөл хугацаанд хяналт тавьж, бэлэн хоолны хадгалж олгох хугацаа хэтэрсэн 6 нэрийн 60 кг, 2 нэрийн 19л хоол устгасан.
- Налайх дүүргийн “Чандмань Налайх” ОНӨААТҮГ-аас зөөврийн усаар хангасан ба 20 тоннын багтаамжтай ус нөөцлөх сав ашигласан. Зөөврийн уснаас 8-р сарын 11-ны өдөр Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газрын Налайх дүүрэг дэх мэргэжлийн хяналтын хэлтсийн улсын байцаагч дээж авч НМХГ-ын лабораторид шинжлүүлсэн.
- Ахуйн болон хоол үйлдвэрлэлийн хог хаягдлыг зориулалтын уутанд хийж хогийн цэгт цуглуулан тухай бүр ачуулсан. Шингэн хог хаягдлыг 2 тоннын багтаамжтай саванд цуглуулан соруулж, ачиж зориулалтын цэгт асгасан.

17. Оролцогчдын аюулгүй байдлыг хангах менежмент

8-р сарын 11-14 өдрүүдэд Налайх дүүрэг дэхь Цагаагийн хэлтсээс давхацсан тоогоор 125 цагдаагийн албан хаагч ажиллаж зам тээвэр, хөдөлгөөний зохицуулалт, хэв журам сахиулан ажилласан.

Нийслэлийн Онцгой байдлын газар, Налайх дүүрэг дэхь Онцгой байдлын хэлтсийн 32 албан хаагчийн баг бүрэлдэхүүн авран хамгаалах бэлтгэл ажлыг ханган гал унтраах зориулалтын МАЗ-11тн автомашин, хүн тээврийн зориулалтын МАЗ загварын автомашин амрах зориулалтын чиргүүлийн хамт, аврах ажиллагааны УАЗ-Фургон загварын автомашин, шуурхай дуудлагын Ланд-76 загварын автомашин, моторт завь-2ш нийт 6 нэгж техникийг тохиромжтой цэгт байрлуулж 24 цагаар үүрэг гүйцэтгэсэн. 8-р сарын 13-15-ны өдрүүдэд нийт 278 автомашиныг шавраас гаргаж хөдөлгөөнийг хэвийн үргэлжлүүлсэн. Гол усанд хүн унахаас сэргийлж явган болон мото завьт эргүүл аюулаас сэрэмжлүүлж моторт завьтай эргүүл 24 цагийн турш ажиллаж хяналт тавьж ажиллалаа.

Налайх дүүргийн Эрүүл мэндийн төвийн яаралтай тусламж үйлчилгээ, түр эмнэлэг, вакцинжуулалтын цэг байгуулж, 20-25 эмч, эмнэлгийн ажилтануудтай баг наадмын өдрүүдэд ажилласан. Нийт 58 дуудлага хүлээн авч, эмнэлгийн тусламж үйлчилгээг үзүүлж ажилласан.

Нийслэлийн болон Налайх дүүргийн Мэргэжлийн хяналтын хэлтсээс хоол хүнс болон орчны аюулгүй байдалд хяналт тавьж өдөрт 5-8 байцаагч наадмын талбайд ажилласан.

8-р сарын 11-ний өдрөөс бүх оролцогчид наадмын талбайд бүтээн байгуулалт, тохижилтын ажлаар ирсэнтэй холбоотой маш их замын тоосжилт үүссэн. Энэ онцгой нөхцөл байдалд яаралтай арга хэмжээ авч Налайх дүүргийн Цэцэрлэгжүүлэлтийн албанаас 10 тонны ёмкосттой усалгааны, Налайх дүүргийн Онцгой байдлын хэлтсийн галын машинаар 2 өдрийн турш 2 машин (2022.08.11-12-ны өдөр) нийт 19 удаагийн рейсээр 190 тонн усаар замыг чийглэсэн.

Нүүдэлчин соёлын фестиваль зохион байгуулагдах хугацаанд гал түймэр, гамшиг ослын дуудлагагүй, усны осол эндэгдэлгүй болж өндөрлөсөн.

18. Сайжруулсан зам тавих ажил

8-р сарын 10-11-ны өдрүүдэд Тэрэлжийн төв замаас наамдын талбай руу салж явах эхний 1,5км замыг Налайх АЗЗА ТӨХК нь 24 дугаартай Налайх-Тэрэлж чиглэлийн 10м өргөнтэй хайрган замыг хэв дүрс гарган автогрейдерээр тэгшлэх ажлыг хийсэн. Үргэлжлэл наадмын талбайн орох хэсэгт хүртэлх 1,5 км замыг Алтан талын зам ХХК-тай гэрээлж, хуучин шороон замыг тэгшилж, автогрэйдерээр хусч, хайрга асгаж тэгшилж, нягтруулан сайжруулсан шороон зам болгон тус тус засаж бэлэн болгосон.

19. ЗХЖШ-ийн дэмжлэг, туслалцаа

ЗХЖШ-ын даргын 2022 оны А/431 тушаалаар 8-р сарын 9-15-ны өдрүүдэд Налайх дүүргийн Горхи-Тэрэлжийн байгалийн цогцолбор газрын Сайханы Саравч газарт 150 цэргийн алба хаагчийн бүрэлдэхүүнтэй томилогдон үүрэг гүйцэтгэлээ.

8-р сарын 09-ний өдөр давхардсан тоогоор 87 ЦАХ, 8-р сарын 10-ны өдөр давхардсан тоогоор 235 ЦАХ, 8-р сарын 11-ний өдөр давхардсан тоогоор 350 ЦАХ, 8-р сарын 12-ны өдөр 197 ЦАХ, 8-р сарын 13-ны өдөр давхардсан тоогоор 153 ЦАХ, 8-р сарын 14-ний өдөр давхардсан тоогоор 363 ЦАХ, 8-р сарын 15-ны өдөр давхардсан тоогоор 345 ЦАХ, 7 өдөрт давхардсан тоогоор 1730 ЦАХ, 27680 хүн/цаг ажлыг хийж гүйцэтгэлээ.

Томилгоот бүрэлдэхүүн 8-р сарын 9-15-ны өдрүүдэд дараах ажлыг хийж гүйцэтгэсэн байна. Үүнд:

- Үндэсний урлагийн их театрын 8 хант гэр-1 ком, 5 хант гэр-1 ком, 11 асар;
- Нийслэлийн тамгын газрын 5 хант гэр -1ком, 2 асар;
- Монголын үндэсний телевизийн 5 хант гэр-1 ком;
- Шадар сайдын 8 хант гэр-1 ком;

- Соёлын өвийн хүрээний 6 хант гэр-10 ком, 8 хант гэр-2 ком;
- Улаанбаатар хотын 9 дүүргийн 8 хант гэр-5 ком, 5 хант гэр-2 ком, 3 асар;
- Найруулагчдын гэр 5 хант гэр-6 ком, 2 асар, 1 их тайз;
- 21 аймгийн 10 хантай гэр-8 ком, 8 хантай гэр-9 ком, 6 хантай гэр-19 ком, 5 ханатай гэр-29 ком, 4 ханатай гэр-1 ком тус тус барьж, буулгахад давхардсан тоогоор 516 хүн/цаг ажиллаа.

Бага тайз -1 ком, төв хаалга-1 ком, гадна хашаа-1 ком-ыг барих болон буулгахад 25 хүн/цаг ажлыг хийж гүйцэтгэсэн. Зурагт самбар-25 ширхэгийг босгох, буулгах ажилд 25 хүн/цаг зарцуулж, 7 бурханы билэгдэлийг байрлуулан ажиллалаа.

“Нүүдэлчин Монгол–2022” их наадмын нээлтийн ажиллагаанд 80 ЦАХ Монгол үндэсний хувцас өмсгөлтэй оролцсон.

ОБЕГ-тай хамтран усан эргүүлд 6 ЦАХ өдрийн 16 цагийн хугацаатайгаар үүрэг гүйцэтгэж, 5 өдрийн турш иргэд, наадамчдын аюулгүй байдлыг ханган ажилласан.

Өглөө бүр хуримтлагдсан хогийг 5:20-7:00 цагийн хооронд цэвэрлэж, 3 хогийн цэгт төвлөрүүлэн цуглуулж, ачилтыг хийсэн.

Нүүдэлчин хаалга 1 ком, Цагдаагийн хаалт 504 ш байрлуулж, автомашины хөдөлгөөнийг зохицуулан, иргэдийн аюулгүй зорчих боломжийг бүрдүүлэн ажилласан.

8-р сарын 15-ны өдөр “Нүүдэлчин Монгол-2022” их наадам зохион байгуулсан газар орныг цэвэрлэх, наадмын талбайд баригдсан гэр, асар, хоолны газар, бусад бүтээн босгосон зүйлсийг буцаан хураах, буулгах ажилд давхардсан тоогоор 254 ЦАХ хамрагдсан.

Оройн 18:45 цагт орчныг хүлээлгэн өгч Улаанбаатар хот руу 3 нэгж автобус, 3 нэгж ачааны автомашинтайгаар хөдөлсөн.

Дүгнэлт

“Нүүдэлчин” дэлхийн соёлын фестивалийн хүрээнд аймаг, нийслэлийг отог хэлбэрээр зохион байгуулсан нь соёлын биет бус өвийн 7 ай сав, 362 өвийн төрөл зүйл, Монгол Улсаас ЮНЕСКО-д бүртгэгдсэн 15 соёлын биет бус өвийг сурталчлан таниулах, түгээн дэлгэрүүлэх, олон нийтийн мэдлэг ойлголтыг нэмэгдүүлэхэд чухал ач холбогдолтой арга хэмжээ болов. Мөн, тус арга хэмжээнд Соёлын яамны харьяа 13 байгууллагын 160, аймаг, нийслэлийн 100 гаруй албан хаагчид байрлан ажиллаж, зохион байгуулалтад оролцон ажиллав.

Соёлын биет бус өвийг хамгаалах нэг шинэ орон зай нь музей болохыг Европын орнуудад судалж, туршиж эхлээд 20 гаруй жил өнгөрсөн энэ үед Монгол Улсын музейд соёлын биет бус өвийг хамгаалах, сурталчлах, өвийн талаарх мэдлэг ойлголтыг нэмэгдүүлэх, өвлөн уламжлагчдыг алдаршуулахад хичээл зүтгэл гарган хамтран ажиллаж, шинэ туршлага хуримтлуулсан байна.

“Нүүдэлчин” дэлхийн соёлын фестивалийг цаашид зохион байгуулахдаа олон улсын хэмжээнд улам өргөжүүлэн, төсөв, санхүүжилтийг хугацаа алдахгүйгээр шийдвэрлэх, боломжтой тохиолдолд зохион байгуулалтад оролцох оролцогч талуудын тухайн жилийн “Гүйцэтгэлийн төлөвлөгөө”-нд тусгах (тухайн байгууллагуудын үндсэн үйл ажиллагаатай давхцахгүй байх, хүний нөөцийн оновчтой төлөвлөлт хийх, тухайн үйл ажиллагааны хүртээмжийг нэмэгдүүлэх боломж бүрдэнэ) зэрэг саналууд зарим байгууллагаас ирснийг уг дүгнэлтэд тусгав.

Мөн, байнга тогтсон нэг газраа зохион байгуулах нь төлөвлөлт гаргаж эртнээс бэлтгэл хийхэд өндөр ач холбогдолтой болно. Бэлтгэл ажлын төлөвлөлт, санхүүгийн бэлтгэл ажлыг эртнээс хийж, ажил нэг бүрийг нарийвчлан төлөвлөх, нэг хүнд очих ачааллыг багасгаж, цаг тулгасан шийдвэр гаргахгүйгээр ажлыг хэрэгжүүлэх нь илүү бүтээлч, зардал хэмнэсэн арга хэмжээ болно. Эртнээс төлөвлөж төрийн үйлчилгээний байгууллагуудын дэмжлэг туслалцаа, оролцоотойгоор зохион байгуулах нь хүн нөөцийн зохион байгуулалтыг бүрэн хангах боломжтой байна.

Мөн, иргэдийн худалдаа үйлчилгээний асуудлыг зохицуулж, оролцуулахад анхаарах нь чухал байсан бөгөөд зөвшөөрөлгүй худалдаа үйлчилгээ үзүүлж байгаа иргэдийн үйл ажиллагаанаас болж хоол хүнсний аюулгүй байдал алдагдах, эмх замбараагүй байдал үүсэх өндөр эрсдэлтэй байв.

“НҮҮДЭЛЧИН МОНГОЛ - 2022” СОЁЛЫН БИЕТ БУС ӨВИЙН ИХ

НААДМЫН УДИРДАМЖ

НЭГ. ЭРХ ЗҮЙН ҮНДЭСЛЭЛ

1.1 Монгол Улсын Их Хурлын 2020 оны 5 дугаар сарын 13-ны өдрийн 52 дугаар тогтоолоор баталсан “Алсын хараа-2050” урт хугацааны хөгжлийн бодлогын 1.2-т “Үндэсний оюун санаа, өв соёл, сэтгэлгээнд тулгуурласан бүтээгч монгол хүн төвтэй нүүдлийн соёл иргэншлийг хадгалсан тэргүүлэх улс болно”, 1.5-д “Дэлхий дахинд монгол үндэсний үнэт зүйлсийн дархлаа тогтож, монгол соёлыг түгээн дэлгэрүүлж, Монгол Улсын нэр хүнд, үнэлэмжийг дээшлүүлж, хилийн чанад дахь монголчууд, монгол угсаатны хамтын ажиллагаа төлөвшинө” гэж тус тус заасан.

1.2 Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 2.2.2.3-т “Үндэсний уламжлалт спортоор олон улсын спортын наадмын брэнд бий болгох”, 2.6.2.6-д “Соёлын өвийг дэлхий дахинд сурталчлах чиглэлээр олон улсын арга хэмжээг зохион байгуулна”, 2.6.3.4-т “Нүүдлийн соёл иргэншлийн суурь дээр тулгуурласан мэргэжлийн урлагийг хөгжүүлж, бүс нутаг, олон улсад өрсөлдөх чадвар бүхий монгол брэндийг буй болгож соён гэгээрүүлэх үйл ажиллагааг идэвхжүүлнэ”, 3.4.5.1-т “Байгаль, түүх, соёлын аялал жуулчлалын эвент арга хэмжээнүүдийг тогтмол зохион байгуулж, цар хүрээг өргөжүүлнэ” гэж тус тус заасан.

1.3 Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.2 дахь хэсэгт Соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага соёлын биет бус өвийг хадгалж хамгаалах, түүнийг өвлөн уламжлагчийг тодруулах, алдаршуулах, авьяас билгийг хөгжүүлэх, олон нийтэд сурталчлан түгээн дэлгэрүүлэх зорилгоор гурван жил тутам улсын хэмжээнд соёлын биет бус өвийн их наадмыг зохион байгуулна гэж тусгасан.

1.4 Соёлын сайдын 2022 оны 06 дугаар сарын 13-ны өдрийн “Ажлын хэсэг байгуулах тухай” А/181 дүгээр тушаал.

1.5 Соёлын яамны стратеги төлөвлөгөө (2021-2024): Зорилт 9. Дэлхийн Монгол угсаатны ардын урлагийн их наадам зохион байгуулна.

Зохион байгуулагч:

Ерөнхий зохион байгуулагч: Соёлын яам

Хэрэгжүүлэгч: Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Соёл, урлагийн газар.

ХОЁР. ЗОРИЛГО

2.1 Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 39 зүгээр зүйлийн 39.2 дахь заалтыг хэрэгжүүлэх зорилгоор “Нүүдэлчин соёлын наадам” соёлын биет бус өвийн их наадмыг үндэсний нэгдмэл үнэт зүйлийг бэхжүүлэх, бүх нийтийн соён гэгээрэл, соёлын бүтээлч үйлдвэрлэл, соёлын аялал жуулчлалыг хөгжүүлэх, байгальд ээлтэй - эко соёлыг төлөвшүүлэх хүрээнд зохион байгуулна.

ГУРАВ. ЗОРИЛТ

3.1 “Нүүдэлчин Монгол - 2022” соёлын биет бус өвийн их наадмыг отог хэлбэрээр зохион байгуулах;

3.2 Их наадмаар дамжуулан тэг хаягдал бүхий уламжлалт, нүүдэлчдийн байгальд ээлтэй соёлыг сэргээх, нүүрс төрөгчийн ялгарлыг бууруулах (carbon limited) ажлыг зохион байгуулах;

- Тэг хаягдал (zero waste) гэдэг нь байгальд ээлтэй уламжлалт хэрэглээний соёлыг дэлгэрүүлэх замаар аливаа бүтээгдэхүүн, нөөцийг боломжит хязгаарт нь хүртэл дахин ашиглаж, хог хаягдал үүсэхээс урьдчилан сэргийлэхийг хэлнэ.
- Нүүрс төрөгчийн ялгарал (carbon limited)-ыг саармагжуулах гэдэг нь сэргээгдэх эрчим хүчний төрөл бүрийн үүсгүүр ашиглаж, нүүрстөрөгчийг аль болох ялгаруулахгүй байхыг хэлнэ.

3.3 Соёлын биет бус өв, түүнийг өвлөн уламжлагчийг гэрэл зураг, дуу, дүрс бичлэгээр баримтжуулж, Соёлын өвийн Улсын нэгдсэн бүртгэл, мэдээллийн санг баяжуулах;

3.4 Соёлын биет бус өв, түүнийг өвлөн уламжлагчдыг хамгаалах, дэмжих;

3.5 Өвлөн уламжлагчдыг тодруулах, алдаршуулах, авьяас билгийг хөгжүүлэх;

3.6 Өвлөн уламжлагчдын авьяас билиг, арга барил, дэг сургуулийг олон нийтэд сурталчлан таниулж, түгээн дэлгэрүүлэх;

3.7 Хүүхэд, залуучууд, гадаад, дотоодын жуулчид, үзэгч олон нийтийг соёлын биет бус өвийн төрөл зүйл, үндэсний уламжлалт спортын төрлөөс суралцах, өвлөн уламжлуулах боломжийг бүрдүүлж, соёлын биет бус өв, түүнийг өвлөн уламжлагчид болон сонирхогчдын хүрээг нэмэгдүүлэх;

3.8 Соёлын бүтээлч үйлдвэрлэлийг хөгжүүлэх, дэмжих;

3.9 “Нүүдэлчин Монгол - 2022” соёлын биет бус өвийн их наадмыг өргөжүүлэн 2023 онд олон улсын хэмжээнд “Нүүдэлчин” дэлхийн соёлын их наадам зохион байгуулах бэлтгэл ажлыг хангах.

ДӨРӨВ. БАРИМТЛАХ ЗАРЧИМ

“Нүүдэлчин Монгол - 2022” соёлын биет бус өвийн их наадмыг дараах зарчмын дагуу зохион байгуулна. Үүнд:

4.1 Их наадмыг ил тод, нээлттэй зохион байгуулах;

4.2 Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын “Бүртгэл шинэчлэн батлах тухай” 2019 оны 11 дүгээр сарын 29-ний өдрийн А/759 дүгээр тушаалын 2 дугаар хавсралтаар батлагдсан “Монгол Улсын Яаралтай хамгаалах шаардлагатай соёлын биет бус өвийн үндэсний бүртгэл”-д бүртгэгдсэн өвийн төрөл, зүйлийг хамруулах;

4.3 Шашин шүтлэг, нас, хүйс үл хамааран, угсаатны цөөнхийн тэгш оролцоог хангах.

ТАВ. ХАМРАХ ХҮРЭЭ

5.1 Их наадамд Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2019 оны 11 дүгээр сарын 29-ний өдрийн “Бүртгэл шинэчлэн батлах тухай” А/759 дүгээр тушаалын нэгдүгээр хавсралтаар баталсан “Монгол Улсын соёлын биет бус өвийн Төлөөллийн үндэсний бүртгэл”, хоёрдугаар хавсралтаар баталсан “Яаралтай хамгаалах шаардлагатай соёлын биет бус өвийн үндэсний бүртгэл”-д хамаарах дараах 7 ай савыг хамруулна. Үүнд:

1. Эх хэл, аман уламжлал, илэрхийллүүд;
2. Ардын язгуур урлаг;
3. Уламжлалт баяр наадам, зан үйл, ёс, тоглоом наадгай, уриа дуудлага;
4. Байгалийн болон сав шим ертөнцийн тухай мэдлэг, зан үйл;
5. Уламжлалт арга ухаан;
6. Мал маллах арга ухаан;
7. Уламжлалт гар урлал.

(Тушаалын хавсралтыг Соёлын өвийн үндэсний төвийн <http://ncch.gov.mn/method> цахим хуудаснаас татаж авна уу.)

5.2 Аймаг, нийслэлийн соёлын биет бус өвийг өвлөн уламжлагч хувь хүн, бүлэг, хамт олон.

ЗУРГАА. ИХ НААДМЫН ҮЕ ШАТ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

“Нүүдэлчин Монгол - 2022” соёлын биет бус өвийн их наадмыг улсын хэмжээнд 2 үе шаттай зохион байгуулна.

6.1 Их наадмын I шат:

6.1.1 Аймаг, нийслэлийн Соёл, урлагийн газар нь их наадмын I шатны үйл ажиллагааг 2022 оны 07 дугаар сарын 04-ний өдрөөс 8 дугаар сарын 01-

ний өдрүүдийн хооронд харьяалах нутаг дэвсгэртээ энэхүү удирдамжийг удирдлага болгон бие даан зохион байгуулна.

6.1.2 Аймаг, нийслэл нь “Нүүдэлчин Монгол - 2022” соёлын биет бус өвийн их наадмын үйл ажиллагаанд шаардлагатай холбогдох зардлыг бүрэн хариуцах бөгөөд дараах санхүүгийн эх үүсвэрээс бүрдүүлж болно:

- Улс, орон нутгийн төсөв
- Наадмын үйл ажиллагааны орлого
- Гадаад, дотоодын байгууллага, иргэдээс өгсөн хандив, тусламж
- Хууль тогтоомжоор зөвшөөрөгдсөн бусад орлого

6.1.3 Их наадмын үйл ажиллагаанд хандивласан хөрөнгийг санхүүгийн тайланд тусгаж, зориулалтын дагуу ашиглаж, тайлагнана.

6.1.4 Их наадмыг зохион байгуулах хорооноос гаргасан доорх зааврыг мөрдөж ажиллана.

- Отог үүсгэх үйл ажиллагааны заавар;
- Түр байрлахад мөрдөх заавар;
- Эрүүл мэнд, аюулгүй байдлыг хангах заавар;
- Эрүүл ахуйн зааварчилгаа (Зааврыг VII/25-ны өдрийн дотор зохион байгуулах хорооноос хүргүүлнэ).

6.2 Их наадмын II шат:

6.2.1 Их наадмын II шатны үйл ажиллагааг 2022 оны 08 дугаар сарын 12-14-ний өдрүүдэд Улаанбаатар хотноо “Горхи-Тэрэлжийн байгалийн цогцолборт газар”-т зохион байгуулна.

6.2.2 Их наадмын II шатанд оролцогч аймаг, нийслэл нь зохион байгуулах хорооноос “Горхи-Тэрэлжийн байгалийн цогцолборт газар”-т отог үүсгэх үйл ажиллагааны зааврын дагуу 2022 оны 08 дугаар сарын 11-ний өдөр нэгдсэн зохион байгуулалт, өнгө төрхтэйгөөр өөрсдийн отог (гэрүүдийг)-ийг байгуулна.

6.3 Их наадмын II шатанд дараах зохион байгуулалттайгаар оролцоно.

6.3.1 Их наадмын II шатанд оролцох аймаг, нийслэл нь удирдлага зохион байгуулалтаар хангах зорилгоор тухайн орон нутгийн соёлын асуудал эрхэлсэн захиргааны байгууллагын 2-5 хүртэлх хүнийг оролцуулна.

6.3.2 Өвлөн уламжлагч, зохион байгуулагчдын тооны хязгаар 38-61 хүртэлх хүн байна.

6.3.3 Их наадмын II шатанд оролцох өвлөн уламжлагчдын мэдүүлгийг баталсан маягтын дагуу бэлтгэж зан үйл, язгуур урлагийн тоглолт, үзүүлбэрийн хөтөлбөрийн хамт 2022 оны 08 дугаар сарын 01-ний өдрийн

дотор Зохион байгуулах хороонд цахим (agency.culture.gov@gmail.com) шуудангаар хүргүүлнэ.

6.4 Аймаг, нийслэл нь отгийн зохион байгуулалтаар дараах 4 чиглэлээр оролцоно. Үүнд:

6.4.1 Зан үйл, язгуур урлагийн тоглолт, үзүүлбэр:

- 8 ханатай 1 гэр байх;
- Баг, хамт олон 25-35 хүртэлх хүний бүрэлдэхүүнтэй байх;
- Соёлын биет бус өвийн уламжлалт ахуй, орчныг бүрдүүлж, язгуур хэв шинж, нутгийн болон угсаатны онцлогийг харуулсан 40 хүртэлх минутын хугацаатай үзүүлэх тоглолт байх;
- Удирдамжийн 5.1 дэх хэсэгт заасан 1, 2, 3 дахь ай савын төрөл зүйлийг хамруулна.

6.4.2 Гар урлалын үзэсгэлэн:

- 5-8 ханатай 1 гэр байх;
- Баг, хамт олон 4-6 хүртэлх хүний бүрэлдэхүүнтэй байх;
- Гар урлалын бүтээлийн үзэсгэлэнг дэглэсэн байх (малын тоног хэрэгсэл, уран хатгамал, ширмэл, сийлбэр, Монгол уран дарханы урлал гэх мэт);
- Удирдамжийн 5.1-т заасан 7 дахь ай савын төрөл зүйлийг хамруулна.

6.4.3 Соёлын биет бус өвийг таниулан сурталчлах:

- 6 ханатай 1 гэр байх;
- Баг, хамт олон 5-10 хүртэлх хүний бүрэлдэхүүнтэй байх;
- Сүүлийн 5 жилд соёлын биет бус өвийг хамгаалах, түгээн дэлгэрүүлэх чиглэлээр зохион байгуулсан үйл ажиллагаа болон шилдэг туршлагыг таниулан сурталчлах;
- Уламжлалт тоглоом наадгай, бэсрэг уралдаан, тэмцээн зэрэг танин мэдэхүйн болон суралцах боломжийг бүрдүүлсэн олон нийтэд чиглэсэн үйл ажиллагаа зохион байгуулах;
- Удирдамжийн 5.1 дэх хэсэгт заасан 4, 5 дахь ай савын төрөл зүйлийг хамруулна.
- Удирдамжийн 5.1 дэх хэсэгт заасан 5 дахь буюу Уламжлалт арга ухааны ай савд багтах уламжлалт анагаах арга ухааны өвийн өвлөн уламжлагчдыг Зохион байгуулах хорооноос нэг дор төвлөрүүлэн зохион байгуулна. Оролцох аймаг, нийслэл нь хүсэлтээ Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Соёл, урлагийн газарт албан бичгээр ирүүлнэ. 2 хүртэлх хүнийг оролцуулж болно.
- Удирдамжийн 5.1 дэх хэсэгт заасан 6 дахь буюу Мал маллах арга ухааны өвлөн уламжлагчдын оролцоог богино хэмжээний (5-7 минут) контент байдлаар бэлтгэн 08 дугаар сарын 05-ны

өдрийн дотор цахим (agency.culture.gov@gmail.com) шуудангаар ирүүлнэ.

6.4.4 Соёлын бүтээлч үйлдвэрлэл, үзэсгэлэн худалдаа:

- Зохион байгуулах хорооноос 5x5 хэмжээтэй 1 асар олгоно;
- Баг, хамт олон 2-5 хүртэлх хүний бүрэлдэхүүнтэй байх;
- Нутгийн онцлог бүхий уламжлалт идээ ундаа, бараа, бүтээгдэхүүнийг худалдаална.
- Удирдамжийн 5.1 дэх хэсэгт заасан 5, 7 дахь ай савын төрөл зүйлийг хамруулна.

6.5 Хүндэтгэлийн гэр: Аймаг, нийслэл нь орон нутгаа сурталчилсан 1 хүндэтгэлийн өргөөг тохижуулан олон талт үйл ажиллагааг нээлттэй зохион байгуулж болно.

ДОЛОО. ШҮҮГЧДИЙН БҮРЭЛДЭХҮҮН, ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ

7.1 Их наадмын шүүгчдийн бүрэлдэхүүний ажиллах журмыг Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Соёл, урлагийн газрын дарга батална.

7.2 Шүүгчид нь мэргэшсэн, техникийн гэсэн 2 үндсэн бүрэлдэхүүнтэй байна.

7.3 Мэргэшсэн шүүгчдийн бүрэлдэхүүн нь соёлын биет бус өвийн 7 ай савын чиглэлээр мэргэшсэн судлаач, эрдэмтэн, шинжээч зэрэг нийт 15 хүний бүрэлдэхүүнтэй байна.

7.3.1 Мэргэшсэн шүүгчид нь их наадмын II шатанд оролцогчдыг шалгаруулах үйл ажиллагааг хариуцна.

7.4 Техникийн шүүгчдийн баг нь соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, төрийн захиргааны байгууллагын төлөөлөл бүхий 10 хүртэлх хүний бүрэлдэхүүнтэй байна.

7.4.1 Техникийн шүүгчид нь I, II шатны зохион байгуулалтад удирдамжийн 7.6-д заасан холбогдох шалгуурын дагуу техник үйл ажиллагаанд үнэлгээ өгнө.

7.4.2 Техникийн шүүгчдийн оноо 20, үзэгчдийн санал 20, мэргэшсэн шүүгчдийн оноо 60 хүртэлх хувь байна.

7.5 Зохион байгуулах хорооноос баталсан хуваарийн дагуу шүүгчдийн бүрэлдэхүүн ажиллана.

7.6 Их наадмын шүүгчдийн бүрэлдэхүүн нь оролцогч аймаг, нийслэл, өвлөн уламжлагч, баг, хамт олныг дараах шалгуур, үзүүлэлтийг баримтлан шалгаруулна. Үүнд:

7.6.1 Оролцогч аймаг, нийслэлийг шалгаруулах:

- Удирдамжийн 6.4-т заасан 4 чиглэлийн дагуу отог (гэр), соёлын биет бус өвийн 7 ай савын төрөл зүйл, өвлөн уламжлагчийн тоон үзүүлэлт болон удирдамжийн 7.6.2-7.6.4 хүртэлх шалгуур үзүүлэлтийг хангасан байдал;
- Их наадмын I болон II шатанд өвлөн уламжлагч, баг, хамт олны оролцоог хангасан байдал;
- Төрийн болон төрийн бус байгууллага, хувийн хэвшлийг их наадмын үйл ажиллагаанд татан оролцуулж, санхүүгийн болон бусад боломжит дэмжлэг авах үйл ажиллагааг зохион байгуулсан байдал;
- Олон нийтийн оролцоог хангах чиглэлээр гаргасан хүчин чармайлт, зохион байгуулсан үйл ажиллагаа (хэвлэл мэдээллийн хэрэгсэл, олон нийтийн цахим сүлжээгээр түгээсэн, зар, сурталчилгаа, контент, хандалтын тоо гэх мэт).
- Дээр дурдсан шалгуур үзүүлэлтийн дагуу зохион байгуулсан үйл ажиллагааг нотлох гэрэл зураг, дүрс бичлэг (шторк, сурталчилгааны контент), холбогдох баримт бичгийн хуулбар (тушаал, тогтоол, захирамж), санхүүгийн баримт (зарцуулсан төсөв, орлого, зарлагын баримт)-ын хуулбар зэргээр баталгаажуулсан тайлан.

7.6.2 Зан үйл, язгуур урлагийн тоглолт, үзүүлбэрт оролцогчдоос шилдэг өвлөн уламжлагч, баг, хамт олныг шалгаруулах:

- Язгуур хэв шинж, уламжлалыг илэрхийлсэн байдал;
- Үзүүлэх хэлбэр, ур чадвар, гүйцэтгэл, онцлогийг илэрхийлсэн байдал;
- Соёлын биет бус өвийг түгээн дэлгэрүүлж, сурталчилсан байдал;
- Соёлын биет бус өвийн төрөл, зүйлийг өвлүүлэн уламжлуулах зорилгоор танхимын болон шавь сургалт зохион байгуулсан байдал зэргийг харгалзан үзнэ (холбогдох баримт, баталгаажуулах гэрэл зураг гэх мэт);
- Өвлөн уламжлагч нь тухайн орон нутгийн засаг захиргааны харьяалалтай байх;
- Соёлын биет бус өвийн тоглолт, үзүүлбэрт орчин үеийн техник ашиглахгүй байх, язгуур хэв шинжээр нь үзүүлэхийг эрмэлзэнэ.

7.6.3. Соёлын бүтээлч үйлдвэрлэл, үзэсгэлэн худалдааг шалгаруулах:

- Уламжлалт арга, технологийг ашиглан бүтээсэн байдал;
- Инновац шингэсэн байдал (уламжлалт мэдлэгт суурилсан шинэлэг бүтээл, бүтээгдэхүүн);
- Сав баглаа боодол;
- Чанарын баталгаа, гэрчилгээгээр баталгаажсан бол давуу тал болно;

7.6.4. Гар урлал, үзэсгэлэн:

- Гар урлалын уламжлалт аргаар урласан бүтээл, эд зүйлсийг хамруулна (орон нутгийн гаралтай түүхий эд, уламжлалт арга технологийг ашиглан бүтээсэн бол давуу тал болно);
- Хэвлэмэл болон үйлдвэрийн аргаар бүтээсэн гар урлал, эд зүйлс болон музейн үзмэрийг хамруулахгүй;

НАЙМ. ШАГНАЛ УРАМШУУЛАЛ

8.1 Их наадмын I шатны шалгаруулалтад оролцсон өвлөн уламжлагч, баг, хамт олныг шагнаж урамшуулах асуудлыг тухайн орон нутаг хариуцна.

8.2 Их наадмын II шатанд амжилттай оролцсон аймаг, нийслэлийг шалгаруулж дараах байдлаар шагнаж урамшуулна. Шагналын сан 260,000,000 төгрөг. Үүнд:

I БАЙР - 1 (100,000,000 төгрөг)

II БАЙР - 1 (70,000,000 төгрөг)

III БАЙР - 1 (50,000,000 төгрөг)

IV БАЙР - 2 (20,000,000 төгрөг)

8.3 Их наадмын II шатанд амжилттай оролцсон өвлөн уламжлагч, шилдэг баг, хамт олныг шалгаруулж дараах байдлаар шагнаж урамшуулна. Шагналын сан 37,500,000 төгрөг. Үүнд:

8.3.1 Шилдэг 36 өвлөн уламжлагч

- Шилдэг 21 өвлөн уламжлагч – 1,000,000 төгрөг (7 ай сав тус бүр 3 өвлөн уламжлагч)
- Хамгийн олон шавь сургасан - 5 хүн – 500,000 төгрөг
- Хамгийн өндөр настай - 5 хүн – 500,000 төгрөг
- Шилдэг өвлөн суралцагч - 5 хүүхэд – 300,000 төгрөг

8.3.2 Шилдэг 10 баг, хамт олон

- Шилдэг гар урлал, үзэсгэлэн - 5 баг (1,000,000 төгрөг)
- Шилдэг бүтээлч үйлдвэрлэл - 5 баг (1,000,000 төгрөг)

8.4 Нийт шагналын сан 297,500,000 төгрөг.

ЕС. САНХҮҮЖИЛТ

9.1 Аймаг, нийслэл нь “Нүүдэлчин Монгол - 2022” соёлын биет бус өвийн их наадамд оролцоход шаардагдах зардлыг хариуцна.

АРАВ. БҮРДҮҮЛЭХ МАТЕРИАЛЫН ЖАГСААЛТ

10.1 Зохион байгуулах хорооноос аймаг, нийслэлд хүргүүлэх баримт бичгийн жагсаалт:

№	Нэр	Үзүүлэлт	Тоо ширхэг	Хугацаа
Зохион байгуулах хорооноос хүргүүлэх баримт бичиг:				
1	Отог үүсгэх үйл ажиллагааны заавар;	Заавар, зааварчилгааг зохион байгуулах хорооноос хүргүүлнэ. (удирдамжийн 6.1.4.)	1	VII/25
2	Түр байрлахад мөрдөх заавар;		1	
3	Эрүүл мэнд, аюулгүй байдлыг хангах заавар;		1	
4	Эрүүл ахуйн зааварчилгаа.		1	
5	Их наадмын II шатанд оролцох өвлөн уламжлагчдын мэдүүлгийн маягт	Мэдүүлгийн маягтыг зохион байгуулах хорооноос баталж хүргүүлнэ. (удирдамжийн 6.3.3.)	1	

10.1 Аймаг, нийслэлээс зохион байгуулах хороонд хүргүүлэх баримт бичиг, хэрэглэгдэхүүний жагсаалт:

№	Нэр	Үзүүлэлт	Тоо ширхэг	Хугацаа
1	Их наадмын II шатанд оролцох өвлөн уламжлагч, зохион байгуулагч нарын мэдүүлэг	Батлагдсан мэдүүлгийн маягтаар (удирдамжийн 6.3.3)	38-61 хүн	VIII/01
2	Зан үйл, язгуур урлагийн тоглолт, үзүүлбэрийн хөтөлбөр	40 хүртэлх минут (удирдамжийн 6.4.1.)	1	

3	Уламжлалт арга ухааны ай савд багтах уламжлалт анагаах арга ухааны өвийн өвлөн уламжлагчдын оролцох хүсэлт	Албан бичгээр (удирдамжийн 6.4.3.)	2 хүртэлх хүн	
4	Соёлын бүтээлч үйлдвэрлэл, үзэсгэлэн худалдаа	Худалдаалах уламжлалт идээ ундаа, бараа бүтээгдэхүүний нэр төрөл, тоо хэмжээ (удирдамжийн 6.4.4.)	Өөрсдийн сонголтоор	
5	Мал маллах арга ухааны өвлөн уламжлагчдын богино хэмжээний контент	5-7 минут (удирдамжийн 6.4.3.)	1	VIII/05
6	Гар урлалын бүтээлийн үзэсгэлэнд дэглэгдэх бүтээл, эд зүйлсийн жагсаалт	Бүтээл, эд зүйлсийн нэр төрөл, тоо хэмжээ (удирдамжийн 6.4.2.)	1	
7	Соёлын биет бус өвийг таниулан сурталчлах үйл ажиллагааны хөтөлбөр	Хөтөлбөр (удирдамжийн 6.4.3.)	1	VIII/01
8	Зохион байгуулсан үйл ажиллагааны тайлан, нотлох баримт	Гэрэл зураг, дүрс бичлэг, холбогдох баримт бичиг (удирдамжийн 7.6)		
9	Гэр (удирдамжийн 6.4)	Зан үйл, язгуур урлагийн тоглолт, үзүүлбэрийн 8 ханатай гэр	1	VIII/11
10		Гар урлалын үзэсгэлэнгийн 5-8 ханатай гэр	1	

11		Соёлын биет бус өвийг таниулан сурталчлах 6 ханатай гэр	1	
12		Хүндэтгэлийн гэр, өөрийн сонголтоор	1	

**НҮҮДЭЛЧИН МОНГОЛ-2022” СОЁЛЫН БИЕТ БУС ӨВИЙН ИХ НААДАМД
ОРОЛЦОГЧДОД ӨГӨХ ОТОГ БАЙГУУЛАХ, АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ЭРҮҮЛ АХУЙН
ЗААВАРЧИЛГАА**

2022 оны 08-р сарын 12-14-ны өдрүүдэд Улаанбаатар хотноо “Горхи-Тэрэлжийн байгалийн цогцолбор газар”-т зохион байгуулагдах “Нүүдэлчин монгол -2022” наадамд оролцох оролцогч таньд дараах отог байгуулах, аюулгүй байдал, эрүүл ахуйн зааварчилгааг өгч байна. Зааварчилгааг бүрэн уншиж танилцаж ойлгож мэдсэний дараа гарын үсгийг зурна уу.

“Нүүдэлчин Монгол – 2022” соёлын биет бус өвийн их наадамд аймаг, нийслэлээс оролцогч нь дараах зааврыг баримталж оролцоно.

I. Отог үүсгэх үйл ажиллагааны заавар.

1. Ерөнхий зүйл:

1.1. Аймаг, нийслэлээс оролцогч баг, хамт олон нь “Нүүдэлчин Монгол - 2022” наадмын зохион байгуулах хорооноос оноосон талбайд тус тусын отгоо 2022 оны 08 дугаар сарын 10, 11-ний өдрийн 18:00 цагаас өмнө байгуулна.

1.2. Отгийн хаягийг Наадмыг зохион байгуулах хорооноос нэгдсэн байдлаар байршуулна.

1.3. Отог байгуулж, орчин бүрдүүлэхэд дараах зүйлсийг бэлтгэж ирнэ.

1.3.1. Нутгийн бэлгэдэл туг эсвэл далбааг авчрах, мөн ивээн тэтгэгч байгууллагын туг, далбааг байршуулж болно. Туг, далбааны ишний өндөр 2м байна. (Төрийн тугний стандарт хэмжээг баримталан Наадмын бэлгэдэл, лого бүхий тугийг өгөгдсөн загварын дагуу заавал байршуулна)

1.3.2. Отогийн гэр барих туг далбааг байрлуулах, аливаа овор бүхий эд зүйлийг байгалийн үзэгдэл бороо, салхинаас хамгаалах даруулга, бэхэлгээг /хүндрүүлэгч, элс, шороо г.м./ аймаг, нийслэлийн дүүргүүд/ бэлтгэсэн байна.

1.3.3. Отгийн гадна талбайд боломжоо харгалзан “Монголын нэг өдөр”-ийн орчныг бүрдүүлэхэд анхаарна.

1.3.4. Байгалийн болон сав шим ертөнцийн тухай мэдлэг, арга ухааны ай савыг үзүүлэх мал, гаршуулсан амьтан авч ирэх тохиолдолд малын хашаа, шинжилгээний бичиг, малчинтай ирэхээс гадна эрүүл ахуйн дэглэмийг хатуу сахиж, орчны аюулгүй байдлыг 24 цаг хангаж ажиллана.

1.4. Отгоор байрлахдаа гэрийн аюулгүй ажиллагааг хангах галын хор, хүрз, элс, шороо зэргийг байрлуулахаар бэлдэж, мөн биет бус өвөө сурталчилахад зайлшгүй шаардлагатай эдлэл, хэрэгслүүдийг тооцож авчирна.

1.5. Орон нутгийг сурталчилах соёлын бүтээлч үйлдвэрлэл, бүтээгдэхүүн худалдааг их наадмын Зохион байгуулах хорооноос заасан цэгт байгуулж, худалдаалж болно. (Архи согтууруулах идээ ундаа, илт хурдан хугацаанд муудах, сав баглаа боодолгүй, баталгаат

хугацаагүй, хөргүүр сав шаардсан хүнсний бүтээгдэхүүний худалдаа, хэрэглээ, үйлчилгээг цээрлэх).

2. Анхааруулга:

2.1. Отгийн үйл ажиллагаанд музейн үзмэр ашиглахгүй.

2.2. Үнэтэй, ховор эд зүйлсийн хадгалалт хамгаалалтыг Соёлын биет бус өвийн их наадмын Зохион байгуулах хороо хариуцахгүй.

3. Отгийн ажиллах цагийн хуваарь:

3.1. 2022 оны 08 дугаар сарын 10, 11-ний өдөр 21 аймаг, нийслэлийн өвлөн уламжлагчдын багууд “Нүүдэлчин Монгол - 2022” наадмын план зурагт заасан тус тусын талбайд отгоо байгуулна.

3.2. “Нүүдэлчин Монгол - 2022” наадмын үйл ажиллагааны цагийн хуваарь:

- 07:00 - 09:00 цагт Аймаг, нийслэл тус бүр отгийн аюулгүйн ажиллагааг шалгаж, нээх бэлтгэл ажлыг хангана. VIII/12-VIII/14
- 09:00 – 20:00 цагт батлагдсан хөтөлбөрийн дагуу отгийн үндсэн арга хэмжээ явагдана.
- 20:00 – 20:30 цагт Отгийн эрүүл ахуй, ариун цэврийн шаардлагыг хангаж цэвэрлэгээ үйлчилгээ хийгдэнэ. Энэ үед давхар аюулгүй ажиллагааг шалгаж, отгийг хааж лацдана.

3.3. 2022 оны 08 дугаар сарын 15-ны өдөр багууд Отгоо буулгаж, орон нутагтаа буцна.

4. Отогт нийтээр баримтлах сахилга бат, дэг журам:

4.1. “Нүүдэлчин Монгол - 2022” наадмын үргэлжлэх хугацаанд оролцогчид хөтөлбөрийн дагуу цагийг чанд баримталж үйл ажиллагаанд хамрагдана.

4.2. Их наадмын оролцогчид хүмүүнлэг аж төрөх ёсыг баримталж бусдыг хэл амаар доромжлохгүй, аливаад хүлээцтэй хандах, нийгмийн хэв журмыг чанд сахина.

4.3. Удирдлагын зөвшөөрөлгүйгээр Отог болон үйл ажиллагаа явагдаж байгаа газар, талбайг орхиж явахыг хориглоно.

4.4. Шийдвэрлэх асуудал гарсан тохиолдолд Их наадмын Зохион байгуулах хорооны штабт шуурхай мэдэгдэнэ.

II. ОРОЛЦОГЧДЫГ ТЭЭВЭРЛЭХ ТАЛААР:

Тээврийн хэрэгслийн жолооч нар аялалд гарахын өмнө холбогдох албан тушаалтнаас ХАБЭА зааварчилгааг дэлгэрэнгүй авч, танилцсан талаар гарын үсэг зурж баталгаажуулсан байна. Томилолтонд явахын өмнө 12 цагаас доошгүй унтаж амарсан байх. Жолооч нь тээврийн хэрэгслийг оношилгоонд хамруулж түүний дагуу шаардлагатай

засвар үйлчилгээг хийсэн байх ба ирж буцахдаа батлагдсан маршрутын дагуу явна. Шаардлагатай тохиолдолд хэрэглэх дараах эд зүйлсийг бүрэн гүйцэд авч явах. Үүнд:

- Галын хор,
- ослын гурвалжин,
- эмийн сан,
- засвар хийхэд шаардлагатай багаж хэрэгсэл, татлага тросс, домкрат, нөөц дугуй, нөхөөс гэх мэт

Жолооч нь тээврийн хэрэгслийн аюулгүй, бүрэн бүтэн байдлыг хариуцна.

- Хөдөлгөөнд оролцохдоо “Монгол Улсын замын хөдөлгөөний дүрэм”-ийг дагаж мөрдөнө.
- Замын хөдөлгөөнд оролцохдоо гар утас болон бусад анхаарал сарниулах зүйлсийг ашиглахгүй байх.
- Тээврийн хэрэгслийн хурдыг тохируулахдаа тухайн авто замын хэсгийн зөвшөөрөгдсөн хурдны дээд хязгаараас хэтрүүлэлгүй зорчих.
- Тээврийн хэрэгслийн суудлын тоогоор зорчигчдыг суулгах, хүн хэтрүүлж суулгахгүй байх, огцом зогсох, жолоо шилжүүлэхийг хориглоно.
- Зорчигчдыг тээврийн хэрэгсэлд гүйцэд бууж суусны дараа анхааруулга дохио өгч хөдөлгөөн хийх.
- Шатахуун түгээх газар болон шатах, тослох материалын орчимд ил гал гаргах, тамхи татахыг бүрэн хориглоно.
- Авто зам дээр ажил үүрэг гүйцэтгэж байгаа хүн, явж байгаа мал амьтны дэргэдүүр өнгөрөхдөө хурдаа хасч, түүнд болон өөрсдөдөө аюул, осолтой байдал үүсгэхгүйгээр зорчих.
- Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангаж чадахааргүй өвчтэй (толгой өвдөх, дотор муухайрах, халуурах гэх мэт) буюу ядарсан үедээ ахалж яваа ажилтанд даруй мэдэгдэж хөдөлгөөнд оролцохгүй байх.
- Түр зогсолт хийхдээ тээвэрлэн яваа зорчигчдод аюул учруулахгүй байх, замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангаж зогсолт хийх.
- Тээврийн хэрэгслийн тоормосны систем, жолоодлогын хүрдний механизм ажиллахгүй болсон, чиргүүлийн холбоос / чиргүүлтэй үед / эвдэрсэн, харанхуй үед болон үзэгдэх орчин хязгаарлагдсан нөхцөлд хол, ойрын буюу ар талын дохионы гэрэл асахгүй болсон, бороо орж байгаа үед жолооч талын шил арчигч ажиллахгүй зэрэг нөхцөл байдал үүссэн тохиолдолд хөдөлгөөнөө үргэлжлүүлэхийг хориглоно.
- Гол усны гүнийг урьдчилан үзэхгүйгээр гатлах гэж оролдохгүй байх.
- Наадмын талбайд ирээд зохион байгуулах хорооноос зааж өгсөн автомашины зогсоолд тээврийн хэрэгслийг байрлуулна.
- Дур мэдэн наадмын талбай руу тээврийн хэрэгсэл оруулахыг хориглоно.

Зааварчилгаа авсан:

Жолооч: Овог..... Нэр

Гарын үсэг.....

.....он.....сар.....өдөр

III. “НААДМЫН ОРОЛЦОГЧ НАРТ”

1. Аюулгүй байдлыг хангахад тавигдах шаардлага:

- 1.1 Оролцогч аймаг, нийслэл нь Хөдөлмөр аюулгүй байдал (ХАБ) хариуцсан 1 ажилтанг заавал томилж ажиллуулна.
- 1.2 Наадмын оролцогч бүрд зохион байгуулах хорооноос хүргүүлсэн “Аюулгүй байдал, эрүүл ахуйн зааварчилгаа”-г уншиж танилцуулан гарын үсгээр баталгаажуулж зохион байгуулах хорооны “Аюулгүй байдал-Эрүүл ахуй хариуцсан” ажилтанд өгөх.
- 1.3 “Нүүдэлчин монгол-2022” наадамд ирж, буцахдаа өөрийн аймгаас томилогдсон ахлагчийн удирдлаган дор батлагдсан тээврийн хэрэгслээр зорчино. Тээврийн хэрэгслээр зорчихдоо өөрийн болон бусдынхаа аюулгүй байдалд хяналт тавьж явах. Тээврийн хэрэгслийг гүйцэд зогсоогүй явдал дунд бууж суухгүй байх, тээврийн хэрэгслийн цонхоор толгой, гараа гаргаж явахгүй байх, өвөр дээр халуун савтай халуун хоол, цай тавьж явахгүй байх зэргийг анхаар. Автомашин зогсох үед тээврийн хэрэгслийн ард зогсохгүй, суухгүй байх, ганц нэгээр холдож явахгүй байх.
- 1.4 Насанд хүрээгүй хүүхдийг ганц нэгээр явуулахгүй байх, асран хамгаалагчийн хамт явуулах.
- 1.5 Наадмын үйл ажиллагааны хүрээнд Зохион байгуулах хорооноос гаргасан “Отог үүсгэх үйл ажиллагааны заавар”, “Түр байрлах заавар”, “Аюулгүй байдал, эрүүл ахуй зааварчилгаа”-г дагаж мөрдөнө.
- 1.6 Наадмын талбайд ажиллах хэв журам сахиулах байгууллагуудаас тогтоосон дүрэм журмыг мөрдөнө.
- 1.7 Хаалт, хамгаалалт, анхааруулах тэмдэг, тэмдэглэгээг дагаж мөрдөнө.
- 1.8 Гэр барьж цахилгаан хэрэгслүүдээ залгах, салгахдаа нойтон гараараа цахилгаан тоноглол, кабель утсанд хүрэхгүй байх, шалбарч гэмтсэн болон кабель утас ил гарсан кабель утсыг хэрэглэхгүй байх, Олон залгуурт хэт олон зүйлсийг нэг дор залгахгүй байх
- 1.9 Гэрлийг даавуу, хөшиг гэх мэт шатамхай материалаас хол байрлуул.
- 1.10 Бороо хур их орж голын усны түвшин ихээр нэмэгдэж байгаа тул голын ойр орчмоор явахгүй байх, голд орохгүй байх
- 1.11 Бороо орох, цахилгаан цахих үед өндөр хүчдэлийн шугамын ойр орчинд зогсохгүй байх, гэрэл цахилгаанаа тэжээлээс салгах, шалбарч гэмтсэн, кабель ил гарсан цахилгааны утаснаас хол байх
- 1.12 Ахуйн хэрэглээний газыг ил задгай наранд тавихгүй байх
- 1.13 Хөгжлийн бэрхшээлтэй иргэд, өндөр настай өвлөн уламжлагчдад анхаарал халамж тавина.
- 1.14 Аймаг, нийслэлээс Зохион байгуулах хороотой шууд харилцаж ажиллах захиргааны байгууллагын 1 хүнийг томилж ажиллуулна.

2. Эрүүл ахуйн зааварчилгаа:

- 2.1 Ирж, буцах замд оролцогчийн биеийн байдал тавгүйрэх байдал мэдэгдмэгц ахалж яваа ажилтанд нэн даруй мэдэгд. Суурь өвчтэй болон эмчийн хяналтанд эм уудаг оролцогч шаардлагатай эм, эмийн бүтээгдхүүнээ биедээ авч яв. Аймаг бүр эмнэлэгийн анхны тусламж үзүүлэх эмийн хайрцаг бэлдэж бэлэн авч явах.

- 2.2 Наадамд оролцогчдыг хариуцаж яваа ажилтан оролцогчдын сахилга бат болон биеийн эрүүл мэндийн байдалд хяналтыг тавьж явах ба аймгаас гарахдаа анхны тусламжийн эмийн хайрцгийг бэлдэж авч гарах.
- 2.3 “COVID” цар тахлын халдварын тоо нэмэгдэж байгаатай холбогдуулан халуурах, ханилгах , биед мэдэгдэхүйц өөрчлөлт гарсан тохиолдолд яаралтай эмнэлгийн цэгт хандаж зөвлөмжийн дагуу холбогдох арга хэмжээг яаралтай ав.
- 2.4 Оролцогч бүр өөрийнхөө болон бусдынхаа аюулгүй байдалд хяналт тавьж , учирч болох эрсдэлээс урьдчилан сэргийлэхэд анхаарна.
- 2.5 Наадмын талбай отог, түр байрандаа зохион байгуулах хорооноос өгөгдсөн зааварчилгааны дагуу дэг журамтай, эмх цэгцтэй , ариун цэврийн шаардлагыг хангаж байрлана.
- 2.6 Оролцогчдын биеийн байдал эвгүйрэх , өвдөх тохиолдолд наадмын зохион байгуулах хорооны эмнэлгийн үйлчилгээний цэгт хандаж , эмнэлгийн тусламж үйлчилгээ авна.
- 2.7 Хэт халуунд нарших, оройн сэрүүн, бороотойд даарах , хорхой шавьжинд хазуулах , явганаас унаж бэртэх зэрэг осол гэмтлээс болгоомжил.
- 2.8 Хүнсний бүтээгдхүүн хэрэглэхдээ чанар, баталгаат хугацааг анхаарч хоолны хордлогонд орохоос урьдчилан сэргийлэх.
- 2.9 Ариун цэврийн шаардлага хангасан зориулалтын талбайд хоол хүнсийг боловсруулж хэрэглэ.
- 2.10 Хүнсэнд хэрэглэх махан бүтээгдхүүнийг бэлнээр хэрэглэх /мал , амьтан төхөөрөхгүй байх/

3. Хориглох зүйлс:

- 3.1 Согтууруулах төрлийн ундаа, сэтгэцэнд нөлөөлөх эм бэлдмэл, мансууруулах бодис хэрэглэх, үнэртэх
- 3.2 Шөнө оройн цагаар сэлгүүцэх, багийн бус зохион байгуулалтаар , ахалж яваа ахлагчийн зөвшөөрөлгүй наадмын үйл ажиллагаанаас бусад чиглэл, зүйлд явахыг хориглоно.
- 3.3 Ахалж яваа ажилтны зөвшөөрөлгүй автомашины зогсоолоос тээврийн хэрэгсэл хөдөлгөхийг хориглоно.
- 3.4 Шатах, тослох материал, амархан шатах материалын ойролцоо, ил гал гаргах, тамхи татах
- 3.5 Голын эрэг гол руу явахыг хориглоно.
- 3.6 Цахилгаан тоног төхөөрөмжийг дур мэдэн залгах, салгах
- 3.7 Зөвшөөрөлгүй галт зэвсэг, хутга мэс, ангийн хэрэгсэл авч ирэхийг хориглоно.
- 3.8 Ил задгай гал асаахыг хориглоно.
- 3.9 Халдварт өвчний эрсдэлээс урьдчилан сэргийлж , хорио цээр тогтоосон хүнс, ургамал хэрэглэх (ангийн мах, амьтны гаралтай хүнс, ургамал гэх мэт)
- 3.10 Олон нийтийн амгалан тайван байдлыг алдагдуулах , бусдын биед халдах, буруу зүйлд татан оролцуулах
- 3.11 Зориулалтын бус газар бие засах, ил задгай нус цэрээ хаях
- 3.12 Хог хаягдлыг хогийн сав болон тогтоосон цэгээс бусад газарт ангилан ялгалгүй хаях
- 3.13 Шингэн хаягдлыг зориулалтын бус газарт асгах
- 3.14 Наадмын хүрээнд мал муулах , малын арьс , шир , үс , ноос , сэвс хаях

Зааварчилгаа өгсөн:

..... Овог нэр..... албан тушаалгарын үсэг

.....он.....сар.....өдөр

IV. “БАЙГАЛЬД ЭЭЛТЭЙ – СОЁЛ”

1. Монгол Улсын Хог хаягдлын тухай хуулийн дагуу **ИРГЭН** Таны **ХҮЛЭЭХ ҮҮРЭГ**:

1.1. “Байгальд ээлтэй-Соёл” уриан дор наадмын отог, хамрах талбайд хоггүй, цэвэр орчныг ханган ажиллаж, хүний эрүүл мэнд, байгаль орчинд үзүүлэх хортой, сөрөг нөлөөллийг бууруулахад онцгой анхаарах бусдад зөв үлгэр дууриал үзүүлэх;

1.2. Хог хаягдлаа цуглуулан зориулалтын хогийн сав, цэгт ангилан ялгаж хаях буюу хог хаягдал цуглуулж тээвэрлэх эрх бүхий байгууллагад шилжүүлнэ.

1.3. Хог хаягдлын улмаас хүний эрүүл мэнд, байгаль орчинд хохирол учирсан, учруулж болзошгүй байдал үүссэн тохиолдолд наадмын зохион байгуулагч, онцгой байдал, цагдаа, эрүүл мэндийн байгууллагад яаралтай мэдэгдэнэ.

1.4. Наадмын ажлын хэсгээс зохион байгуулж буй хог хаягдлын талаархи сургалтад хамрагдсан байна.

Эх орны минь хөрс Чандмань эрдэнэ/Plastic free/

Цээрлэх зүйл:

1. Наадмын үеэр пластик савтай ундаа борлуулах
2. Наадмын худалдаанд пластик тор хэрэглэх

Хэрэглээ:

1. Оролцогчид өөрийн гэсэн ус, ундааны савтай оролцох
2. Цаасан болон даавуун тор, аяга
3. Дахин боловсруулсан цаасан болон пластик тор ашиглах
4. Үйлчлэх горим – дахин боловсруулсан цаасан аяга, хувь хүний аяга, дашмаг дахин боловсруулсан аяга худалдаалах

Агаар чандмань эрдэнэ: /Low Carbon/

Цээрлэх зүйл:

1. Наадмын бүсэд моторт унаа ашиглахгүй байх

Хэрэглээ:

1. Ердийн хөсөг хэрэглэх /унадаг дугуй, үхэр болох морин хөсөг/
2. Нарны энергийг ашиглах.

2. Хориглох үйл ажиллагаа:

2.1. Хог хаягдлыг эх үүсвэр дээр ангилан ялгалгүй хаях;

2.2. Хог хаягдлыг дэд бүтцийн шугам хоолой, ногоон бүс, нийтийн эзэмшлийн гудамж, зам талбай, далан, шуудуунд ил задгай хаях;

2.3. Хог хаягдлыг ил задгай болон нийлэг материалтай хог хаягдлыг шатаах;

2.4. Хог хаягдлыг хогийн сав болон тогтоосон цэгээс бусад газарт хаях;

2.5. Наадмын хүрээнд мал муулах, малын арьс, шир, үс ноос, сэвс хаяхыг хатуу хориглоно.

Хүлээх хариуцлага

Зааварчилгааг дагаж мөрдөөгүй тохиолдолд дараах хариуцлагыг хүлээлгэнэ.Үүнд:

1. Соёлын биет бус өвийн их наадмын шалгаруулалт үзүүлэлтийн үнэлгээ буурахад нөлөөлнө.
2. Зохион байгуулах хороогоор хэлэлцэж наадмаас хасах хүртэл арга хэмжээ авна.
3. Хуулийн бусад хариуцлагыг хүлээлгэнэ.
4. “Хог хаягдлын тухай хууль”-ийн 23.1.3 дахь заалтын дагуу торгууль ногдуулна

V. ЯАРАЛТАЙ ҮЕД ХОЛБОГДОХ УТАС:

“Нүүдэлчин Монгол – 2022” наадам зохион байгуулах хугацаанд соёлын биет бус өвийн их наадмын төв штаб өдөр бүр ажиллана. Оролцогчдод түгээгдэх гарын авлагад штабын байршил, холбогдох утас тавигдсан байна.

Яаралтай тусламжийн дугаарууд:

Гал түймэр:	101
Гамшиг осол, аврах ажиллагаа:	105
Гэмт хэрэг, зөрчил, зам тээврийн осол:	102
Эмнэлгийн түргэн тусламж:	103

“НҮҮДЭЛЧИН МОНГОЛ-2022” СОЁЛЫН БИЕТ БУС ӨВИЙН ИХ НААДМЫН
МЭРГЭШСЭН ШҮҮГЧДИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Ерөнхий шүүгч: Соёлын өвийн үндэсний төвийн захирал, соёл судлалын ухааны доктор Ph.D Г.Энхбат

Гишүүд: ШУА-ийн Хэл зохиолын хүрээлэнгийн Аман зохиол судлалын секторын эрхлэгч, соёл судлаач, доктор Ph.D профессор А.Алимаа (Эх хэл, аман уламжлал, илэрхийллүүд)

ШУА-ийн Хэл зохиолын хүрээлэнгийн Хэл шинжлэлийн секторын ЭША, Монгол хэл бичгийн ухааны доктор Sc.D, дэд профессор Г.Батзаяа (Эх хэл, аман уламжлал, илэрхийллүүд)

Монгол Улсын Урлагийн гавьяат зүтгэлтэн А.Цэдэн-Иш (Ардын язгуур урлаг)

Соёл судлаач, доктор Ph.D, дэд профессор Ш.Эрдэнэцэцэг (Ардын язгуур урлаг)

Соёл судлаач, соёл судлалын ухааны доктор Ph.D С.Юндэнбат (Уламжлалт баяр наадам, зан үйл, ёс, тоглоом наадгай, уриа дуудлага)

Монгол Улсын Урлагийн Гавьяат зүтгэлтэн, урлаг судлалын шинжлэх ухааны доктор Sc.D, профессор Л.Эрдэнэчимэг (Уламжлалт баяр наадам, зан үйл, ёс, тоглоом наадгай, уриа дуудлага)

Угсаатны зүйч, доктор Ph.D, профессор М.Ганболд (Байгалийн болон сав шим ертөнцийн тухай уламжлалт мэдлэг, зан үйл)

Монгол Улсын Соёлын гавьяат зүтгэлтэн, доктор Ph.D Б.Галаарид (Байгалийн болон сав шим ертөнцийн тухай уламжлалт мэдлэг, зан үйл)

Монгол Улсын Соёлын гавьяат зүтгэлтэн, доктор Ph.D, профессор Н.Уртнасан (Уламжлалт мэдлэг арга ухаан)

Монгол Улсын Соёлын гавьяат зүтгэлтэн, Ардын багш, доктор Ph.D, профессор Л.Дашням (Уламжлалт мэдлэг арга ухаан)

ШУА-ын Түүх, угсаатны зүйн хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ажилтан М.Энхбаатар (Мал маллах арга ухаан)

Монгол Улсын Соёлын гавьяат зүтгэлтэн, Малчин телевизийн сэтгүүлч Д.Шагдарсүрэн (Мал маллах арга ухаан)

Монгол Улсын Соёлын гавьяат зүтгэлтэн, МУ-ын Соёлын элч, урлаг судлаач, доктор Ph.D Б.Сувд (Уламжлалт гар урлал)

Дүрслэх урлагийн академийн сургуулийн багш, Урлаг судлалын ухааны доктор Ph.D, профессор С.Бадрал (Уламжлалт гар урлал)

Туслах шүүгчид:

Соёлын яамны Соёлын өвийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын Соёлын биет бус өвийн асуудал хариуцсан мэргэжилтэн, докторант Ц.Цолмон

Соёлын өвийн үндэсний төвийн Соёлын биет бус өвийн шинжээч, ЮНЕСКО-ийн шинжээч, докторант А.Саруул

Нарийн бичгийн дарга:

Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Соёл, урлагийн газрын Соёлын биет бус өв, баримтат өв хариуцсан мэргэжилтэн, докторант Ж.Насанжаргал

“НҮҮДЭЛЧИН МОНГОЛ-2022” СОЁЛЫН БИЕТ БУС ӨВИЙН ИХ НААДМЫН
ТЕХНИКИЙН ШҮҮГЧДИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Ахлагч:	Соёлын яамны Соёлын өвийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын Соёлын баримтат өвийн асуудал хариуцсан мэргэжилтэн, Соёл судлалын ухааны доктор Ph.D Д.Мэндсайхан.
Гишүүд:	Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Соёл, урлагийн газрын Соёл, соёлын өвийн хэлтсийн ахлах мэргэжилтэн Л.Шинэбат Соёл, урлагийн газрын Соёл, соёлын өвийн хэлтсийн мэргэжилтэн О.Ганболд Монголын үндэсний музейн номын санч С.Энхцэцэг Монголын үндэсний музейн тайлбарлагч С.Мөнхжин Соёлын өвийн үндэсний төвийн сан хөмрөгч Л.Оргилтуяа
Нарийн бичгийн дарга:	Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Соёл, урлагийн газрын Соёл, соёлын өвийн хэлтсийн мэргэжилтэн Ж.Ууганцэцэг

“НҮҮДЭЛЧИН МОНГОЛ-2022” Соёлын биет бус өвийн их наадмын Мэргэшсэн болон Техникийн шүүгчдийн ажиллах дүрэм

Нэг. Ерөнхий зүйл.

- 1.1. “Соёлын өвийг хамгаалах тухай хууль”-ийн 39 дүгээр зүйлийн 39.2 дахь заалтыг хэрэгжүүлэх зорилгоор Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Соёл, урлагийн газрын даргын баталсан “Нүүдэлчин Монгол-2022” соёлын биет бус өвийн их наадмын Удирдамж”-ийн 7 дугаар зүйлийг баримтлан их наадмын II шатны шалгаруулалтыг шүүх шүүгчдийн оноо өгөх, дүнг нэгтгэхэд энэхүү дүрмийг баримтална.
- 1.2. Их наадмын үеэр Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2019 оны А/759 дүгээр тушаалаар баталсан Монгол үндэсний соёлын биет бус өвийн Төлөөллийн болон Яаралтай хамгаалах шаардлагатай үндэсний бүртгэл дэх:
 1. Эх хэл аман уламжлал, илэрхийллүүд;
 2. Ардын язгуур урлаг;
 3. Уламжлалт баяр наадам, зан үйл, ёс, тоглоом наадгай, уриа дуудлага;
 4. Байгалийн болон сав шим ертөнцийн тухай мэдлэг, зан үйл;
 5. Уламжлалт арга ухаан;
 6. Мал маллах арга ухаан;
 7. Уламжлалт гар урлалын ай савд хамаарах 362 өвийн оролцоо, хамрах хүрээг хангасан эсэхийг харгалзан үзнэ.
- 1.3. Шалгаруулалтад Улаанбаатар хот, 21 аймаг нийт 22 баг отог (гэр) хэлбэрээр оролцох ба шүүгчид отог тус бүрд хуваарийн дагуу ажиллана.
- 1.4. Шүүгчид их наадмын II шатанд оролцож буй 21 аймаг, нийслэлээс 1,2,3,4 дүгээр байрыг тус тус шалгаруулна.
- 1.5. Шүүгчид их наадмын II шатанд оролцож буй өвлөн уламжлагч, оролцогчдоос:
 - 7 ай сав тус бүрээс 3, нийт 21 шилдэг өвлөн уламжлагч;
 - Хамгийн олон шавь сургасан өвлөн уламжлагч багш 5 хүн;
 - Хамгийн өндөр настай оролцогч 5 хүн;
 - Шилдэг өвлөн суралцагч 5 хүүхэд тус бүрийг нэр дэвшүүлж шалгаруулна.
- 1.6. Шүүгчид их наадмын II шатанд оролцож буй аймаг, нийслэл болон үйлдвэрлэл эрхлэгч баг хамт олноос:
 - Шилдэг гар урлал, үзэсгэлэнгийн төрлөөр 5 баг;
 - Шилдэг бүтээлч үйлдвэрлэл төрлөөр 5 багийг нэр дэвшүүлж шалгаруулна.

- 1.7. Шалгаруулалтыг хийхдээ отог дээр ажилласан шалгаруулалтын үр дүн болон Удирдамжийн 7 дугаар зүйлд буй шалгуур үзүүлэлтийг хангасан эсэх үр дүнг харгалзан үзнэ.

Хоёр. Шүүгчдийн бүрэлдэхүүн, тоо

- 2.1. Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Соёл урлагийн газрын даргын тушаалаар Мэргэшсэн болон Техник, Туслах шүүгчдийг батална.
- 2.2. Мэргэшсэн шүүгчид нь 15 хүний бүрэлдэхүүнтэй байна.
- 2.3. СББӨ-ийн 7 ай сав тус бүрд 2 шүүгч, 1 ерөнхий шүүгч, 2 туслах шүүгч ажиллана.
- 2.4. Техникийн шүүгчид нь 10 хүний бүрэлдэхүүнтэй байна.

Гурав. Шүүгчийн ажиллах дэг

- 3.1. Мэргэшсэн шүүгчийн ажиллах дэг;
 - 3.1.1 Мэргэшсэн шүүгчид отогт ажиллана.
 - 3.1.2 Аймаг, нийслэлээс 1,2,3,4 дүгээр байрыг тус тус шалгаруулахад онооны үнэлгээний хуудас ашиглана (Хавсралт 1).
 - 3.1.3 Дүрмийн 1.5, 1.6 дахь заалтад буй шилдэг өвлөн уламжлагч, хувь хүн, баг, хамт олныг (Хавсралт 2, 4, 6, 7) өгөгдсөн үнэлгээний хуудсанд нэр дэвшүүлж тодруулна.
 - 3.1.4 Шүүгч тус бүрд Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Соёл, урлагийн газраас баталсан үнэлгээ өгөх хуудсыг тараана.
 - 3.1.5 Шүүгч бүр зөвхөн өөрт оногдсон үнэлгээний хуудсанд бичигдсэн шалгуур үзүүлэлтийн дагуу үнэлгээг өгнө.
 - 3.1.6 Шүүгчид үнэлгээний дүгнэсэн хуудас, нэр дэвшүүлсэн хуудсыг бөглөсөн даруйдаа нарийн бичгийн даргад хураалгана.
 - 3.1.7 Хүндэтгэх шалтгааны улмаас тухайн цаг үед шүүгч ажиллахгүй тохиолдолд Ерөнхий шүүгч орлох шүүгчийг давхар томилох, туслах шүүгчдийг орлуулан ажиллуулж болно.
 - 3.1.8 Орлон ажиллах шүүгчийн хүний нөөц хүрэлцэхгүй тохиолдолд нийт шүүгчийн онооны дундаж оноогоор үнэлгээг тооцно.
- 3.2. Туслах шүүгчийн ажиллах дэг;
 - 3.2.1. Туслах шүүгч нь Ерөнхий шүүгчийн заавраар ажиллана.
 - 3.2.2. Туслах шүүгч нь Ерөнхий шүүгч, Мэргэшсэн шүүгчийн адил үнэлгээ өгнө.
 - 3.2.3. Мэргэшсэн шүүгчийн нэгдсэн үнэлгээ тэнцсэн тохиолдолд Туслах шүүгчийн үнэлгээг харгалзан үзнэ.
 - 3.2.4. Нэгдсэн үнэлгээний оноонд Туслах шүүгчийн үнэлгээ хамаарахгүй болно.

3.2.5. Хүндэтгэх шалтгааны улмаас тухайн цаг үед Мэргэшсэн шүүгч ажиллахгүй тохиолдолд Ерөнхий шүүгчийн шийдвэрээр түр болон бүр мөсөн чөлөөлөгдсөн шүүгчийг орлон ажиллана.

3.3. Техникийн шүүгчийн ажиллах дэг;

3.3.1. Техникийн шүүгчид нь Удирдамжийн 7.6.1-ийн холбогдох заалт, зохион байгуулалт, цагийн хуваарь, дэг журам гэсэн чиглэлээр үнэлгээний хуудас ашиглан зохих оноог дүгнэнэ.

3.3.2. Техникийн шүүгчид нь өөрсдийн хариуцсан чиглэлээр оноог дүгнэж техникийн шүүгчдийн нарийн бичгийн даргад хүргүүлнэ.

3.3.3. Техникийн ахлагч нь онооны дүнг нэгтгэн Мэргэшсэн шүүгчдийн нарийн бичгийн даргад хүргүүлнэ.

Дөрөв. Үнэлгээ өгөх

4.1. Мэргэшсэн шүүгчдийн үнэлгээ;

4.1.1. Мэргэшсэн шүүгчид нь Соёлын биет бус өвийн 7 ай сав тус бүрийн чиглэлийн 14, ерөнхий 1, нийт 15 мэргэшсэн шүүгч байна.

4.1.2. Шүүгч нь “Шилдэг аймаг, нийслэл (отог, гэр)-ийг шалгаруулахдаа үнэлгээний ерөнхий 3 шалгуур тус бүрд 10 хүртэлх оноо, нийт 30 хүртэлх оноог өгнө. (Хавсралт 1.)

4.1.1. Соёлын биет бус өвийн 7 ай сав тус бүрийн чиглэлийн 14 шүүгч нь өөрсдийн чиглэлээр, Ерөнхий шүүгч нь 7 ай савын бүх чиглэлээр оноог өгнө.

4.1.2. Шүүгч тус бүр өөрсдийн ай савын хүрээнд “Шилдэг өвлөн уламжлагч” төрөлд өвлөн уламжлагчдыг нэр дэвшүүлж нийт 21 хүнийг шалгаруулна. (Хавсралт 2.)

4.1.3. “Шилдэг өвлөн суралцагч хүүхэд” төрөлд шүүгч тус бүр өвлөн суралцагч хүүхдийн нэрийг дэвшүүлж шүүгчдийн саналын тоогоор нийт 5 хүүхдийг шалгаруулна. (Хавсралт 5.)

4.1.4. “Шилдэг гар урлал, үзэсгэлэн” төрөлд шүүгч тус бүр аймаг, нийслэлийн баг, хамт олныг нэр дэвшүүлж шүүгчдийн саналын тоогоор нийт 5 багийг шалгаруулна. (Хавсралт 6.)

4.1.5. “Шилдэг бүтээлч үйлдвэрлэл” төрөлд шүүгч тус бүр аймаг, нийслэлийн баг, хамт олныг нэр дэвшүүлж шүүгчдийн саналын тоогоор нийт 5 багийг шалгаруулна. (Хавсралт 7.)

4.2. Техникийн шүүгчдийн үнэлгээ;

4.2.1. Техникийн шүүгчид нь багаар ажиллан онооны үнэлгээ өгнө.

4.2.2. Аймаг, нийслэл нь нийт онооны 20 хувь буюу 150 хүртэлх оноотой байна.

- 4.2.3. Зохион байгуулалт, цагийн хуваарь, дэг журам болон Удирдамжийн 7.6.1-д хамаарах дараах 6 шалгуурыг үндэслэн оноог хасах байдлаар тооцож үнэлгээг өгнө. Үүнд: (Хавсралт 7.)
1. Их наадмын II шатанд өвлөн уламжлагч, баг, хамт олны оролцоог хангасан байдал;
 2. Мэдүүлэг, холбогдох баримт бичгийг цаг хугацаанд нь ирүүлсэн байдал;
 3. Мал маллах арга ухааны ай савын контент ирүүлсэн байдал;
 4. Ирц болон цагийн хуваарийн дагуу үйл ажиллагаанд оролцсон байдал;
 5. Орчны ариун цэвэр, хог хаягдал;
 6. Харилцааны ёс зүй;
- 4.2.4. Мэдүүлэг болон холбогдох баримт бичгийг үндэслэн дараах 2 төрлөөр өвлөн уламжлагч нарыг шалгаруулна. (Хавсралт 3)
- “Хамгийн өндөр настай оролцогч”-ийг мэдүүлгийг үндэслэн шалгаруулах
 - “Хамгийн олон шавь сургасан өвлөн уламжлагч”-ийг холбогдох нотлох баримт бичигт тулгуурлан шалгаруулах

4.3. Үзэгчдийн саналын үнэлгээ;

4.3.1 Үзэгчдийн саналыг тусгайлан бэлтгэсэн аймаг, нийслэлийн 22 хоргонд хурааж тооцно.

4.3.2 Аймаг, нийслэлийн хоргонд цугларсан саналыг гараар тоолж, хувьчилж дүгнэнэ.

Тав. Үнэлгээг нэгтгэх

- 5.1. “Шилдэг аймаг, нийслэл (отог)” 450 оноо буюу 60 хувь, “Техникийн шүүгчдийн оноо 150 буюу 20 хувь, “Үзэгчдийн санал”-ын оноо 20 хувь буюу 150, нийт онооны нийлбэр **750** байна.
- 5.2. Онооны эрэмбээр их наадмын II шатанд оролцогч аймаг, нийслэлийг шалгаруулж зохих байр эзлүүлнэ.
- 5.3. Үнэлгээг Ерөнхий шүүгч болон шүүгчийн нарийн бичгийн дарга нар нэгтгэнэ.
- 5.4. Шүүгчдийн оноог СББӨ-ийн ай сав бүрээр нэмж нийт оноог баг тус бүрээр гаргана.
- 5.5. Үнэлгээг нэгтгэхэд хараат бус шинжээч ажиллуулж болно.

Зургаа. Шүүгчийн ёс зүй

6.1. Шүүгч нь хамт олон, хувь хүний СББӨ-ийн оршин тогтнох орон зай, түүний хөгжилд хүндэтгэлтэй хандана.

6.2. Шүүгч нь соёлын олон талт байдал, төрөл зүйлд хүндэтгэлтэй хандана.

6.3. Шүүгч нь аливаа хэлбэрээр ялгаварлах болон аливаа ашиг сонирхлын (хамаарал бүхий этгээд, нэг нутгийн хүн гэх зэрэг) зөрчлөөс ангид байх зарчим баримтална.

6.4. Шүүгч нь шүүлтийн явцад зохисгүй үг хэллэг, үйлдэл гаргаж болохгүй бөгөөд бусдад энэ төрлийн ойлголт төрүүлэхээс зайлсхийнэ.

6.5. Шүүгч нь хараат бус, хөндлөнгийн оролцоо, нөлөөлөлд авталгүй үнэн шударга шүүх үүрэгтэй.

6.6. Шүүгч нь шүүлтийн явцад хөндлөнгөөс оролцох, нөлөөлөхийг оролдсон аливаа үйлдлийн талаар мэдүүлэх үүрэгтэй.

-oOo-

**“Шилдэг аймаг, нийслэл (отог)”
шалгаруулах үнэлгээний хуудас**

Ай савын нэр:

..... аймаг, нийслэлийн нэр

..... огноо

№	Шалгуур	Онооны үзүүлэлт	Оноо	Тайлбар
1	Өвийн язгуур хэв шинж, уламжлалыг илэрхийлсэн байдал	0-10		
2	Ур чадвар, гүйцэтгэлийг илэрхийлэх байдал	0-10		
3	Хувцаслалт, дэг ёсыг илэрхийлэх байдал	0-10		
4	Нийт дүн			

Шүүгчийн санал дүгнэлт:

<p>.....</p> <p>.....</p> <p>.....</p> <p>.....</p> <p>.....</p>
--

Шүүгчийн нэр:

Гарын үсэг.....

**“Шилдэг өвлөн уламжлагч”-д
нэр дэвшүүлэх хуудас (7 ай сав тус бүр 3 хүн)**

..... Ай савын нэр

..... огноо

№	Аймаг, нийслэлийн нэр	Өвийн төрөл зүйлийн нэр	Нэр дэвшүүлж буй өвлөн уламжлагчийн нэр	Тайлбар мэдээлэл
1				
2				
3				

Шүүгчийн нэр:

Гарын үсэг.....

“Хамгийн олон шавь сургасан өвлөн уламжлагч”-д

нэр дэвшүүлэх хуудас (нийт 5 хүн)

№	Ай сав, өвийн төрөл зүйлийн нэр	Нэр дэвшүүлж буй өвлөн уламжлагчийн нэр	Нас, хүйс	Тайлбар мэдээлэл
1				
2				
3				
4				
5				

Тайлбар: Аймаг, нийслэлээс нэр дэвшүүлсэн өвлөн уламжлагчийн баримт бичиг, нотлох баримтыг үндэслэж шалгаруулна.

Техникийн шүүгчдийн
багийн ахлагч:

..... (Нэр) Гарын үсэг

Гишүүд:

..... (Нэр) Гарын үсэг

..... (Нэр) Гарын үсэг

..... (Нэр) Гарын үсэг

-оОо-

**“Ахмад өвлөн уламжлагч”-д
нэр дэвшүүлэх хуудас (нийт 5 хүн)**

..... аймаг, нийслэлийн нэр огноо

№	Аймаг, нийслэлийн нэр	Нэр дэвшүүлж буй өвлөн уламжлагчийн нэр	Нас, хүйс
1			
2			
3			
4			
5			

Тайлбар: Аймаг, нийслэлээс нэр дэвшүүлсэн өвлөн уламжлагчийн баримт бичиг, нотлох баримтыг үндэслэж шалгаруулна.

Техникийн шүүгчдийн
багийн ахлагч:

..... (Нэр) Гарын үсэг

Гишүүд:

..... (Нэр) Гарын үсэг

..... (Нэр) Гарын үсэг

..... (Нэр) Гарын үсэг

-оОо-

**“Шилдэг өвлөн суралцагч хүүхэд”-д
нэр дэвшүүлэх хуудас” (нийт 5 хүүхэд)**

..... аймаг, нийслэлийн нэр огноо

.....Шүүгчийн нэрГарын үсэг

№	Аймаг, нийслэлийн нэр	Нэр дэвшүүлж буй суралцагчийн нэр	Тайлбар мэдээлэл
1			
2			
3			
4			
5			

**“Шилдэг гар урлал, үзэсгэлэн”-ийн баг, хамт олны төрөлд
нэр дэвшүүлэх хуудас (нийт 5 баг)**

..... аймаг, нийслэлийн нэр огноо

.....Шүүгчийн нэрГарын үсэг

№	Шалгуур хангах үзүүлэлт	Нэр дэвшүүлж буй баг, хамт олон (аймаг, нийслэл)-ы нэр		Тайлбар мэдээлэл
1	1.Уламжлалт аргаар урласан бүтээл эсэх;	1		
	2.Орон нутгийн гаралтай түүхий эд ашигласан эсэх	2		
	3.Хэвлэмэл болон үйлдвэрийн аргаар бүтээсэн бол	3		
	хамруулахгүй;	4		
	4.Музейн үзмэр, хуучны хийсэн эд зүйлийг хамруулахгүй	5		

“Шилдэг бүтээлч үйлдвэрлэл”-ийн багийн төрөлд

нэр дэвшүүлэх хуудас (нийт 5 баг)

..... аймаг, нийслэлийн нэр огноо

.....Шүүгчийн нэрГарын үсэг

№	Шалгуур үзүүлэлт	Нэр дэвшүүлж буй баг, хамт олон (аймаг, нийслэл)-ы нэр		Тайлбар мэдээлэл
1	1.Уламжлалт арга технологийг ашиглан бүтээсэн байдал;	1		
	2.Инновац шингэсэн байдал (уламжлалт мэдлэгт суурилсан шинэлэг бүтээл, бүтээгдэхүүн)	2		
	3.Сав баглаа боодол;	3		
	4.Чанарын баталгаа, гэрчилгээгээр баталгаажсан байдал.	4		
		5		

“Техникийн шүүгчдийн” шалгаруулах үнэлгээний хуудас

..... аймаг, нийслэлийн нэр ОГНОО

№	Шалгуур хангах үзүүлэлт	Онооны үзүүлэлт	Оноо (-)	Үнэлгээ хасах зарчим	Техникийн шүүгчийн нэр, гарын үсэг
1	Их наадмын II шатанд өвлөн уламжлагч, баг, хамт олны оролцоог хангасан байдал;	25		56 хүний оролцоог 100% гэж үзнэ, 1-4 өвлөн уламжлагч хасагдсан бол 2 оноо, 5-10 хүн хасагдсан бол 4 оноо, 11-15 хүний тоо хасагдсан бол 6 оноо, 16-22 хүн хасагдсан бол 8 оноо, 23 ба түүнээс дээш хүний оролцоог хангаагүй бол 10 оноо тус тус хасагдана.	
2	Мэдүүлэг, холбогдох баримт бичгийг цаг хугацаанд нь ирүүлсэн байдал;	25		Удирдамжид заасан хугацаа буюу 08 сарын 01-ний өдөр ирүүлсэн бол 100% гэж үзнэ, 1 хоног хоцроосон бол 2, 2 хоног хоцроосон бол 4, 3 хоног хоцроосон бол 6, 4 ба түүнээс дээш хоног хоцроосон бол 8 оноо тус тус хасагдана.	
3	Мал маллах арга ухааны ай савын контент ирүүлсэн байдал;	25		Контент ирүүлсэн бол оноог 100% гэж үзнэ, ирүүлээгүй бол-25 оноо хасна.	
4	Ирц болон цагийн хуваарийн дагуу үйл ажиллагаанд оролцсон байдал;	25		Цагийн хуваарь ирцийн бүрдлийг нэг удаа зөрчих бүрд 2 оноо хасагдана.	
5	Орчны ариун цэвэр, хог хаягдал;	25		Орчны ариун цэврийг өдөрт 2 удаа шалгаж зөрчил гарах бүрд 2 оноо хасагдана.	
6	Нийтийн хэв журмыг хангасан байдал /харилцааны ёс зүй, архи согтууруулах ундаа/	25		Зөрчил гарах бүрд 2 оноо хасагдана.	
	Нийт	150			